


# ҮҮЛЭН БӨР

орос ардын  
члгэрүүд



# ҮҮЛЭН БОР

## Орос ардын үлгэрүүд

[www.kiebooks.com](http://www.kiebooks.com)

# САЙХАН ВАСИЛИСА

Эрт урьд цагт энхжин тогтсон нэгэн хаант улсад өмгөр жижигхэн байшинтай өвгөн эмгэн хоёр өөдсийн чинээхэн охин

Василисатайгаа амьдран суудаг байжээ. Энх амар эрүүл саруул сайхан амьдарч суутал гэв гэнэт гай зовлон гараад иржээ. Эмгэн болсон эхийнх нь бие мүудаж үхэл зовлон хаяанд нь ирлээ гэнэ. Хөөрхий эх охин Василисагаа дуудан хажуудаа суулгаад жижигхэн хүүхэлдэй өгөн:

- Охин минь сонс. Энэ хүүхэлдэйг хадгалж яв. Хэнд ч битгий үзүүлээрэй. Хэрвээ чамд гай зовлон

тохиолдол энэ хүүхэлдэйгээ  
хооллоод яах вэ? гэж асууж зөвлө.  
Хүүхэлдэй хоол идчихээд чамд сайн  
санааны санамж үнэн сэтгэлийн үг  
хэлнэ.

Ингэж хэлээд эх Василиса охиноо  
нэг үнсээд нас баржээ. Өвгөн  
харамсан гашуудан нэлээд удсанаа  
дахин авгай авчээ. Охин  
Василисадаа сайн эх олоод өглөө  
гэсэн чинь ууртай догшин зантай,  
хорон санаат хойт эхтэй  
болгочихжээ.

Хойт эх хоёр охинтой гэнэ. Тэр хоёр  
охин нь ууртай, хорлонтой, цамаан  
зантай ажээ. Хойт эх өөрийн хоёр

охиноо хайрлан энхрийлж,  
Василисаг нүдний хог шүдний мах  
мэт үзэн гадуурхана. Василиса  
охины амьдрал тун хэцүү болжээ.  
Хойт эх нь хоёр охинтойгоо нийлэн  
загнаж зандчин харааж зүхэн, хүнд  
хүчир ажлаас турж эцэн нар салхинд  
гандаж гундаасай гэсэндээ хөөрхий  
охиноор ажлыг хэцүүг хийлгэдэг  
байв.

- Василиса, Васка. Хогоо цэвэрлэ,  
хаолоо хий. Түлээгээ оруул, үнээгээ  
саа. Алив хурдал, хурдал. тэрийг  
хий, энийг тэг гэж өдөржингөө л  
хашигирцгаана.

Харин Василиса хэлсэн бүгдийг нь

хийж, даалгасан бүгдийг нь  
гүйцэтгэнэ. Тэгээд ч өдөр ирэх тусам  
л үлам сайхан үлам хөөрхөн болоод  
байжээ. Үлгэрт хэлшгүй, үзгээр  
бичишгүй үзэсгэлэнтэй сайхан  
олжээ. Хүнд хэцүү ажил болгонд нь  
өнөөх хүүхэлдэй нь тусалдаг байж л  
дээ. Василиса өглөө эртээ гэгч  
үнээгээ саачихаад харанхуй пинд  
ороод дотроосоо түгжиж байгаад  
хүүхэлдэйдээ сүү уулган:

- Алив хүүхэлдэй минь сүү үү, амсах  
зовлонг минь сонсож үз гээд л  
хэлдэг байжээ.

Хүүхэлдэй сүүг нь үучихаад  
Василисаг тайтгаруулан тайвшруулж,

ажил болгоныг нь хийж өгнө.

Василиса модны сүүдэрт суугаад цэцэг түүнэ. Энэ хооронд нь талбайн шанг нь цэвэрлэчихсэн, усыг нь зөөчихсөн, зуухыг нь галлачихсан, байцааг нь усалчихсан байдаг байв.

Энэ бүхнийг хүүхэлдэй нь л хийчихдэг ажээ. Хүүхэлдэй нь наранд гандуулдаггүй сайн өвсийг Василисад зааж өгнө. Василиса урьд урьдынхаасаа үлам ч сайхан болно.

Нэг удаа эцэг нь удаан хугацаагаар хол юманд явжээ. Хойт эх охидтойгоо байшиндаа хорогдон үлдэв. Цонхны цаана хав харанхуй, усан бороо цутгаж салхи шуугисан, намар оройн цаг байжээ. Эргэн

тойронд нь харанхуй хар ой сүглийнэ. Ойд хүний мах иддэг Шулмас эмгэн сүудаг ажээ. Хойт эх нэг охиндоо тор нэхэх, нөгөө охиндоо оймс нэхэх, Василисад утас ээрэх ажил оноов. Тэгээд бүх гэрлийг унтраан охид ажиллаж байгаа газар ганцхан гэрэл үлдээгээд өөрөө унтахаар хэвтлээ гэнэ. Хойт эхийн үлдээсэн ганц мод төдөлгүй асаж дууслаа.

- Одоо яах вэ? Гэрт гал байхгүй, ажлаа яаж хийх вэ? Шулмас эмгэн рүү явж гал гүйж ирэхээс өөр арга алга гэж хойт эхийн хоёр охин хэлэлцсэнээ том нь

- Би л явахгүйдэг, би тор нэхэж байна, зүүнээс минь тэртэ тэргүй гэрэлтэй байна гэв.
- Би оймс нэхэм байна, зүүнээс минь надад бас гэрэлтэй л байна гэж бага нь бас хэлэв гэнэ. Тэгснээ хоёулаа нийлэн
- Василиса, Василиса, чи галд яв. Шулмас эмгэнийд очиж гал авчир гэж хашгиралдан Василисаг түлхэн гаргажээ. эргэн тойронд хав харанхуй хар ой нэлмийж хүйтэн салхи үлээнэ. Василиса үйлан халааснаасаа хүүхэлдэйгээ гарган
- Хүүхэлдэй минь намайг Шулмас

эмгэнийд очиж гал авчир гээд хөөчихлөө. Шулмас эмгэн хүнийг барьж аваад л идчихдэг гэсэн одоо би ях вэ? гэв.

- Зүгээр зүгээр, хажууд чинь би байгаа цагт чамд гай зовлон тохиолдохгүй гэж хүүхэлдэй нь хэллээ гэнэ.
- Сайн үг хэлсэнд чинь гялаалай гэж Василиса хүүхэлдэйдээ хэлээд цааш явжээ.

Өмнө хойно нь өтгөн ой харлан, тэнгэрт од мичид ч үгүй, гэрэлт сар гэрэлтэх ч үгүй ажээ. Хөөрхий охин айн чичрэн, хүүхэлдэйгээ элгэндээ

наан явсаар байв. Гэнэт охины хажуугаар цав цагаан морьтой, цалин мөнгөн хазаартай, цагаан тортон хувцастай хүн давхин өнгөрлөө гэнэ. Үүр цайлаа.

Хожуул бутанд бүдэрсээр хөөрхий Василиса арай ядан явсаар байв. Урт гэзгийг нь шүүдэр бүрхжээ, гар хөл нь хөрч хөшжээ. Гэнэт хажуугаар нь ухаа хонгор морьтой, улаан шаргал хазаартай, улаан тортон хувцастай хүн давхин өнгөрлөө гэнэ.

Нар мандаж Василиса охиныг ээн дулаацуулж гэзгэн дээрх шүүдэр хярууг нь хатаалаа. Василиса өдөржингөө явж оройдоо нэгэн том

аглагт гарч иржээ. Өмнө нь нэгэн жижигхэн байшин байна гэнэ. Байшин тойруулан хүний ясаар хашаа барьжээ. Хашааны толгой бүр нь хүний гавлын яс, хаалга нь хүний хөлийн яс, хаалганы цүү нь хүний гар, хааж түгжих түгжээ нь хүний шүд байх юм гэнэ.

Василиса охин айж балмагдан хөшөө мэт хөдөлгөөнгүй болов. Гэнэт хажуугаар нь хар морьтой, хар хазаартай, хар хувцастай эр давхин өнгөрлөө. Хар морьтон хаалга хүртэл давхиж очоод тэндээ газарт шингэх мэт алга болов. Харанхуй шөнө болов.

Гэтэл хашааны толгой дээрх гавлын яс болгоны нүд асан гэрэлтэж аглагт өдөр мэт гэгээтэй болжээ. Василиса дагжин чичирч аймшигт газраас зугтах гэтэл хөл нь газарт шигдсэн мэт хөшжээ. Гэнэт газар доргин сүртэй их чимээ гарлаа гэнэ. энэ бол Шулмас эмгэн үурандаа суугаад нүдүүрээрээ гүядан, гаргасан мөрөө шүүрдэн давхиж яваа нь юмсанжээ. Шулмас эмгэн хаалган дээрээ ирмэгцээ

- Паа, паа паа. Оросын үнэр үнэртээд байна. энд хэн байна вэ? гэж хашгирав.

Василиса охин Шулмас эмгэнд

дөхөж очоод доор гэгч бөхийн дорд  
даруухан дуугаар

- Би байнаа, би байна эмээ минь.  
Хойт эхийн хоёр охин намайг танаас  
гал олж ир гэж явуулсан гэхэд  
Шулмас эмгэн
- Аа тийм үү, Чиний хойт эх миний  
хамаатан. одоо яахав, надтай цуг  
сууж ажил хийж өг. Алсдаа учир нь  
олдоноо гэснээ хахир чангаар
- Хөөе бат бөх цүү цуурга минь,  
онгой. Баялаг өргөн хаалга үүд минь  
нээгд гэж хашгирав.

Хаалга нь ч нээгдэж Шулмас эмгэн

орж гэнэ. Василиса ч дагаад л  
орчихжээ. Хаалганых нь хажууд  
ургасан нэгэн хүс охиныг гүядахыг  
завдав.

- Хүс минь, үүний бүү шавхуурд. Би  
дагуулаад ирсэн юм гэж Шулмас  
эмгэн болиулав гэнэ. Үүднийх нь  
дэргэд хэвтэж байсан нохой охиныг  
хазахаар ухасхийв.
- Бүү хүр, би дагуулаад ирсэн юм гэж  
Шулмас эмгэн хэлэв гэнэ. Үүднийх нь  
өрөөнд ортол муур охиныг маажих  
гэв.
- Бүү хүр, би дагуулаад ирлээ гэж  
Шулмас эмгэн дахин хэлэв.

- За Василиса чи харж байгаа биздээ.  
Надаас зугтах гэдэг амаргүй шүү.  
Муур маажиж, нохой хазаж, хүс мод  
гүядна. Хаалга үүд ч онгойхгүй шүү  
дээ

Ингэж хэлээд Шулмас эмгэн  
байшиндаа ороод вандан дээр  
тэрийн хэвтээд

- Хөөе аягач хар хүүхэн, идэх уух юм  
аваад ир гэж хашгирлаа. Аягач хар  
хүүхэн үсрэн гарч ирээд Шулмас  
эмгэнд тогоо шөл, хувин сүү, хорин  
дэгдээхий, дөчин нугас, бухын өрөөл  
мах, хоёр боов, хүйтэн үндаа, амтат  
бал, хөөсрөх исгэлэн дарсын хэмжээ  
хэмээгүй өгөв. Шулмас эмгэн цөмийг

идэж уугаад Василисад талхны булангаас жаахныг өгөөд

- Алив Василиса, тэр шүүдай будааг нэг нэгээр нь ялга. Нэг ч хар үлдээлгүй цэвэрлэ. Биелүүлж гүйцэлдүүлж чадахгүй бол би чамайг иднэ гэж хэлээд дүнгэнэтэл хурхиран унтаад өгөв. Василиса талхны захаа хүүхэлдэйнхээ өмнө тавиад

- Энхрий хүүхэлдэйхэн минь сонсооч, энэ талхыг ид дээ, эдлэх зовлонг минь сонсооч. Шулмас эмгэн надад хэцүү алба оноолоо. Бас тэгээд бүгдийг хийхүй бол барьж иднэ гэнээ ... гэж хэлэв. Хүүхэлдэй

хариуд нь

- Битгий уйл, битгий гунихар.

Оройноос өглөө сэргэлэн гэдэг. одоо чи тайван үнт гэж аргадлаа.

Василиса дөнгөж үнтмагц хүүхэлдэй

- Хөх бух, хөөрхөн бор шувуухай, цэнхэр тагтаа бүгдээрээ наашаа нисээд ирээрэй, сайхан Василиса охинд saatan saatan туслаарай гэж дуудлаа. Үй түмэн шувуу нисэж ирэв. Чанга чанга дуугаран шуудай будааг ялгана. Үр мөхлөгийг нэг тийш, үртэс холтосыг нөгөө тийш нь ялгав. Тэгтэл ч хаалганы хажуугаар цагаан морьтой, цагаан торгон хувцастай хүн давхин өнгөрөв. Үүр цайлаа.

Шулмас эмгэн сэргж Василисагаас

- За ялгаж цэвэрлэсэн үү? гэв
- Ялгаж цөмийг цэвэрлэсээн

Шулмас эмгэн үурлав, гэхдээ юу ч хэлэх билээ дээ.

- За одоо би олз омог олохоор ниснэ. Тэр шуудайд вандуй, намуу цэцгийн үртэй холилдон байгаа, бүгдийг ялгаж салга. Биелүүлээгүй байвал би чамайг иднэ. Ингээд Шулмас эмгэн гадаа гарч хангинатал шүгэлдэхэд уур нүдүүр нь өнхрөн хүрч ирэв.

Улаан хувцастай морьтон эр давхин өнгөрөв. Нар мандлаа. Шулмас эмгэн үурандаа суун нүдүүрээрээ гуядан шүүрээрээ мөрөө шүүрдэн нисэн одов. Василиса хүүхэлдэйдээ талхны зах өгөөд

- Өөдөсхөн хүүхэлдэй минь, өрөвдөж хайлраач намайг, өөрийнхөө хэрээр туслаач гэв.

Хүүхэлдэй нь цангинуулан

- Алс талын, амбаар савны, айл гэрийн олон хулгана оготнуудаа, нааш ир, нааш ир гэж дуудав.

Үй олон оготно хулгана гүйн ирж

ганцхан цагийн дотор вандуй үр хоёрыг ялгаж шүүдайлав. Орой болоход аягач хар хүүхэн ширээ засан Шулмас эмгэнийг хүлээлээ. Хар морьтон эр хаалганы цаагуур давхин өнгөрөв. Шөнө боллоо. Гавлын яс болгоны ншд асаж мод шажигнаж навчис шаржигналаа. Шулмас эмгэн хүрч ирлээ.

- За Василиса, ялгаж хийсэн үү?

- Цөмийг ялгасаан

Шулмас эмгэн үурлав. Гэхдээ юу ч хэлэх билээ дээ.

- За тийм бол чи одоо явж унт, би ч

хэвтлээ. Василиса пийшингийн цаагуур ороод чих тавин чагнавал шулмас эмгэн

- Аягач хар хүүхэн чи гал түл.  
Пийшингээ халаа. Би сэрээд  
Василисаг шарж иднэ гэх нь дуулдav.

Тэгээд Шулмас эмгэн урт вандан дээрээ хэвтээд уруул амаа тавиур дээр тавиад үл тавхайгаараа хучаад үүлыг доргитол хурхиран унтаад өглөө гэнэ.

Василиса үйлан хүүхэлдэйгээ гарган талхны захаар дайлан

- энхрийхэн хүүхэлдэй минь, энэ

талхыг идээч. Эдлэх зовлонг минь сонсооч. Шулмас эмгэн намайг шарж идэх гэж байна гэв. Хүүхэлдэй Василисад юу хийх, яаж хийх, яаж зовлонгоос салахыг сайн зааж өгөв. Тэгээд ч сайхан Василиса охин аягач хар хүүхний хөлд бөхийн

- Аягач хар хүүхэн минь, аминд минь орж туслаач. Чи ийм их тод битгий түлээч, ийм их ус битгий халаагаач. Том тус хүргэвэл чинь торгон алчураа бэлэглэе гэлээ.

Аягач хар хүүхэн

- Охин минь би чамд туслая. Одоохон пийшин галлахаа азная.

Шунаг бөх унtag гэж Шулмас эмгэний хөлийн улыг маажъя. Энэ хооронд чи зүгтаа гэж зөвлөв.

- Морьтон эрс намайг барьж аваад эргэж авчрахгүй байгаа?
- Өө үгүй, Василиса. Цагаан морьтон гэрэлт өдөр, улаан морьтон алтан нар, хар морьтон харанхуй шөнө байхгүй юу. Тэд чамд хүрэхгүй

Василиса үүдний өрөө рүү гүйн гарвал муур маажих гээд хайран ирэв гэнэ. Василиса мууранд хайрсан боов шидэн өгөхөд хайран сан муур дороо зогсон хоцров. Гадаа үүдэнд гараад ирсэн нохой

хазах гээд давхин ирэв гэнэ.

Василиса нохойд талх шидэж өгсөн чинь нохой түүнийг хазсангүй гаргав. Тэгээд Василиса хаалгаар гүйгээд гарах гэсэн хус мод ороолгох гэж, Василиса ч модны мөчирт өнгийн тууз өлгөж гэнэ. Хус мод охиныг гүядаж шавхуурдсангүй гаргалаа.

Хаалга хаагдах гэхэд Василиса тос түрхэв. Хаалга ч бас нээгдлээ. Тэгээд сайхан Василиса охин хар ой рүү гартал хар морьтон давхин өнгөрч ой ч нүд сохлом харанхуй болов гэнэ. Энэ харанхуйд яаж гэрээ олох юэ? Гал гэрэл олоогүй байж яаж гэртээ орох вэ? Хойт эх алах байлгүй. Тэгтэл хүүхэлдэй нь

Василисад зааж өгөв. Василиса ч хүүхэлдэйнхээ зааснаар хашааны толгой дээрх гавлын ясыг сугалан авч урт модонд суулгав. Ингээд Василиса охин харанхуй ойн дундуур гэрийн зүг гүйлээ. Гавлын ясны нүднээс гэрэл цацарч харанхуй шөнө өдөр мэт гэгээтэй болов.

Шулмас эмгэн сэрэд суниан биеийнхээ чилээг гаргаснаа Василиса байхгүйг мэдээд үхасхийв. Үүдний өрөөнд орон

- Муур чиний хажуугаар нэг охин гүйж гарсан уу? Чи түүнийг урж маажааад бариад авсан биздээ? гэхэд муур хариуд нь

- Шулмас эмгэн минь, би чамд арван жил зүтгэлээ, чи надад талхны булан ч өгөөгүй шүү дээ. Би тэр охиныг явуулчихсаан гэв. Шулмас эмгэн гадаа гүйн гарч
- Үнэнч сайн нохой минь, чи тэр дураараа охиныг хазаж аваад байгаа биздээ? гэхэд нохой
- Хичнээн жил би чамд зүтгэлээ. Чи надад ясны хэлтэрхий ч өгөөгүй, харин тэр охин надад талх өгсөн. Би түүнийг явуулчихсан гэв.

Шулмас эмгэн хахир чангаар  
хашигирч

- Хус минь чи тэр охиныг нүдэн дундуур нь ороолгоод гаргаагүй биздээ? гэхэд хус
- Би чиний хашаанд арван жил ургаж байна. Чи миний мөчрөөс олс ч уяагүй шүү дээ. харин тэр охин өнгийн түүзаар чимсэн, би түүний явуулчихсан гэв. Шулмас эмгэн гадаа хаалган дээрээ гүйн ирж
- ээх, бат бөх хаалга минь, эрх дураараа тэр охиныг эндээс гаргаагүй биздээ? гэхэд хаалга
- Бид чамд хичнээн жил зүтгэлээ. Чи нугас нугархайд минь ус ч дусаагаагүй, харин тэр охин өөр

тосоор тосолсон. Бид тэр охиныг гаргаад явуулчихсаан гэв. Шүлмас эмгэн үурлан хилэгнэж нохойгоо нүдэж, муураа гүйдаж, үүд хаалгаа эвдэж, хус модыг хуга цавчив гэнэ. Тэгээд ядарч эцээд Василиса охины араас барих гэж хөөсөнгүй. Василиса гэртээ гүйн ирэв. Гэрт нь гэрэл гэгээ ч үгүй харанхуй байна гэнэ. Хойт эхийн хоёр охин гарч ирэн хашгирэн загнаж хараан зүхэв гэнэ.

- Гал хурдан авчрахгүй ясан үдаан явдаг юм бэ? Манай гал унтраад байх юм. Бид асаагаад асаагаад нэмэргүй, хөршийнхөөс гал авчирсан чинь дорхонoo унтарчихсан. Чиний авчирсан гал асаад байж магадгүй

гэв.

Тэгээд гавлын ясыг оруулж ирвэл гавлын ясны нүд хойт эх, хойт эхийн хоёр охиныг тас ширтэн халуун галаар хатган түлж гарав. Нөгөө гурав нүүгдах гэсэн боловч чадсангүй, хаашаа л гүйнэ гавлын нүд дагаж харж түлнэ. Гавлын яс тийнхүү цоо ширтэн түлсээр өглөө гэхэд хойт эх хоёр охинтойгоо нүүрс болов. Василисад харин хүрсэнгүй гэнэ.

Василиса гавлын ясыг газарт булахад тэр газраас улаан ягаан бут үргажээ.

Василиса энэ гэртээ үлдэхийг

хүссэнгүй, хот рүү явжээ. Тэгээд тэнд нэг эмгэнийд сух болов. нэг удаа эмгэнд

- Эмээ минь зүгээр сух үйтгартай юм. Та надад хамгийн сайн чанарын маалингын өвч худалдан авч өгөөч гэжээ. Эмгэн маалингын өвс авчрав. Василиса ч утас ээрэхээр сув. Ээрүүл нь эргэлдэн алтан үс шиг нарийхан тэгшхэн утас эвхэгдэн ороогдно. ээрсэн утсаараа Василиса сайхан даавуу нэхжээ. Тэр даавуу нь торго шиг гоёмсог агаад утасны оронд зүүнд сувлэсэн ч болмоор ажээ. Тэгээд Василиса даавуугаа цав цагаанаар будаад эмгэнд

- Эмээ минь энэ даавууг зараад мөнгийг нь өөртөө авдаа гээд өгчээ. Эмгэн даавууг хараад уулга алдан шагширч
- Үгүй ээ охин минь, зарахгүй. Ийм гоёмсог даавууг хаан хүү л өмсөх ёстой. Би ордонд л аваачиж өгнө гэв.

Хан хүү даавууг хараад гайхан

- Үүнийхээ оронд юу авах вэ? гэж асуухад
- Үнэлж баршгүй үнэтэй эд. Би чамд бэлэг болгон авчирлаа гэж эмгэн хариулав.

Хаанхүү талархан сайшаагаад эмгэнд хариу бэлэг өгөөд явуулжээ. Тэгээд тэр даавуугаар хаан хүүд цамц оёх гэсэн хэн ч оёж зүрхлэхгүй байжээ. Түн чиг нарийн хийцтэй гоёмсог даавуу болохоор хүмүүс эвдчих вий, эсгэчих вий гээд айгаад байв. хаан хүү эмгэнийг дуудаад

- Ийм даавуу нэхэж чадсан юм чинь энэ даавуугаараа цамц оёод өгөөч гэжээ. Эмгэн хариуд нь
- Хаан хүү минь би ээрээгүй, би нэхээгүй. Василиса охины хийсэн даавуу.
- Тэгвэл Василиса надад цамц оёод

өгөг гэж хаан хүү тушаав.

Василиса цамцыг оёод торгоор  
эмжээд тодхон сувдаар чимжээ.  
Эмгэн цамцыг ордоонд өгөхөөр явав.  
Василиса цонхны дэргэд сүугаад  
цэцэг хатган оёж байгаад гэнэт  
харвал хааны зарц гүйн ирж яваа  
үзэгдэнэ.

- Хаан хүү ордоонд хүрээд ир гэж  
байна

Василиса ордоонд очив. Хаан хүү  
сайхан Василисаг хараад хөдөлж ч  
чадахгүй хөшин зогсов гэнэ.

- Энэ өдрөөс хойш чамаас би

салахгүй. Эхнэр минь болооч гээд өнгөлөг цагаахан гараас нь барин өөрийнхөө хажууд суулгажээ.  
Удалгүй хуримаа ч хийж гэнэ.

Төдөлгүй Василисагийн эцэг алс холын аянаас буцаж ирээд охиныхоо хажууд амьдрах болжээ. Гэртээ суулгасан тусч эмгэнийг Василиса дэргэдээ авсан гэнэ лээ, энхрий хөөрхөн хүүхэлдэйгээ ч элгэнийхээ халааснаас салгадаггүй гэнэ лээ.

Энх амар эсэн мэнд аж төрөн эрхэм зочид бидний ирж золгохыг хүлээсээр суудаг гэнэ лээ.



# ХӨХ ЧОНО ХӨЛӨГЛӨСӨН ХААН ХҮҮ ИВАН

Берендей гэгч хаан байжээ. Гурван хүүтэй, бага хүү нь Иван гэнэ. Алтан алим үргадаг дархан цэцэрлэгтэй юмсанжээ. Гэтэл хааны цэцэрлэгт хулгай орж алтан алимнаас нь аваад байдаг болов. Хааны гол харлан гонсойэж харуул манаа гаргадаг болжээ. Гэхдээ ямар ч харуул манаа хулгайчийг барьж чадсангүй. Хаан бүр ууж идэхээ болин уруу царайлан гуниглах болжээ. Хөвгүүд нь эцгээ тайтгаруулан

- Эрхэм хүндэт эцэг минь, гуньж гутрах хэрэггүй. Бид өөрсдөө

цэцэрлэгээ маная гэв.

- Өнөөдөр би харуулд гарна гээд том хүү нь явжээ. Оройноос авахуулан яв явж онцолж хэнийг ч харсангүй гэнэ. Шөнө дундын үед зөөлөн өвсөн дээр хэвтээд зүүрмэглэн үнтаж хонов гэнэ.

Өглөө нь хаан эцэг нь асуув

- За, эцгийгээ баярлуулах үг хэлэх үү, эдтэй хүлгайчийг харав үү?

- Эцэг минь хар нүд хамхисангүй шөнөжин харуулдлаа. Харин хэнийг ч харсангүй.

Дараа шөнө нь дунд хүү манаанд  
гараад бас л шөнөжингөө унтаж  
унтчихаад өглөө нь эцэгтээ юу ч  
хэнийг ч харсангүшй гэж хэлжээ.  
Бага хүүгийн манаанд гарах ээлж  
болов. Иван эцгийн цэцэрлэгт ороод  
хэвтэх бүү хэл сууж чадахгүй зогсон  
харуулдав. Нойр нь хүрээд байвал  
өвсний шүүдрээр нүүрээ угаачихаад  
л зогсож байв. Шөнө дундаас хойш  
гэнэт цэцэрлэгт гэрэлтэй гэгээтэй  
бoloод ирлээ гэнэ. Уlam улмаар  
гэгээтэй bolж байснаа бүүр өдөр  
мэт болов. Тэгтэл нэг модон дээр  
Гал шувуу сууж алтан алим  
тоншихыг Иван харав. Иван мод руу  
мөлхөн гэтэн очиж Гал шувууны өд

сүүлнээс шүүрэн авлаа. Гал шувуу ухасхийн нисэн одоход Иваны гарг нэг өд үлдлээ. Өглөө нь Иван эцэг дээрээ ирэхэд

- За Иван, гэмтэн хулгайчийг харав үү? гэхэд Иван
- Хүндэт эцэг минь барьж авч чадсангүй, харин ямар амьтан хулгайлаад байгааг мэдлээ. Гал шувуу гараас мултран нисэн одлоо, энэ түүний өд гэв. Хаан өдийг авч үзээд баярлан хоол унданд хүртэл оржээ. Тэгээд нэг удаа хөвгүүдээ дуудан
- Хайрт хөвгүүд минь, хурдан морио

хөлөглөн өргөн хорвоог туулж Гал шувууны байгаа газарнүүдийг олж мэдэхгүй юу гэхэд гурван хүү нь эрхэм эцэгтээ үнсүүлээд хурдан морио хөлөглөөд холын замд гарчээ.

Гурвуулаа гурван өөр зүгийг барин явав. Зуны халуун өдөр байв. Иван явж явж ядраад мориноосоо буун морио чөдөрлөж тавьчихаад газар хэвтэн унтаа өгчээ. Баахан унтаж байгаад сэrsэн чинь морь нь алга байж. Ийш тийш гүйж харайж эрсэн боловч байдаггүй, хоосортол мөлжсөн хэдэн яс л үлджээ.

- Холын замд унаагүй би хаашаагаа яаж явах билээ гэж Иван халаглан

гүнив. "Одоо яахав, ийм л заяатай байж" гээд Иван цааш явган явжээ. Явж явж үхлтлээ ядраад зөөлөн ногоон зүлгэн дээр толгой гудайлган сууж байтал нэг хөх чоно давхин ирлээ гэнэ.

- Хаан хүү Иван, юундаа толгой гудайн сууна вэ?
- Гунилгүй яах вэ, үнах морьгүй үлдсэн хүн чинь
- Хаан хүү Иван, би чиний морийг идсэн...гэхдээ чамайг өрөвдөж байна. Хэрэг зориг хэнд, хэтийн санаа юунд вэ? хэлж надад яриач

- Гал шувууг олж ир гэж эцэг минь явуулсан
- Пөөх чиний морь хурдан ч гурван жил яваад хүрэхгүй байсан даа. гал шувуу хаана байдгийг ганцхан би мэднэ. морийг чинь би идсэн болохоор чамд туслая даа. Миний нуруун дээр морд, харин сайн бариарай.

Хаан хүү Иван чонын нуруун дээр мордоход чоно хөх үсыг сүүлээрээ шүргэн, хөхрөх ойг хөвөлзтөл хурдлан давхив. Ингээд чоно давхиж давхиж нэг өндөр хэрэм хашааны гадаа ирээд

- Одоо харуул манаа унтаж байгаа, чи ханыг даваад ор. Цамхгийн цонхон дээр алтан торон дотор Гал шувуу сууж байгаа. Чи гал шувууг аваад өвөртөл, харин тороонд хүрч болохгүй шүү гэв

Хаан хүү Иван хэрэм ханыг даван орвол цамхгийн цонхон дээр алтан тортой Гал шувуу байх нь харагдлаа гэнэ. Иван гоё шувууг аваад өвөртлөхдөө алтан торыг нь харан "Аах, ийм үнэтэй сайхан юмыг авахгүй яж болох вэ" гэж бодоод чонын захисныг таг мартжээ. Тэгээд Иван дөнгөж л тороонд хүрмэгц цайз цамхгаар их чимээ гарч, урт бүрээ үзлээж, хэц бөмбөр дэлдэж харуул

манааг сэрээв. Харуул манаа гүйн ирж Иваныг барин хаан Афронд аваачиж өглөө. Хаан Афрон хилэгнэн "Хаанахын хэн гэгч вэ?" гэж асуухад Иван

- Би хаан Берендейн хүү Иван гэлээ
- Хааны хүү хулгай хийнэ гэдэг ичгүүртэй биш үү?
- Таны шувуу манай цэцэрлэгт орж алтан алим тоншиж байхад яагаад болохгүй билээ?
- Үнэнээ хэлээд гүйсан бол би хаан эцгийг чинь хүндлээд чамд энэ шувуугаа зүгээр өгөх байсан. Харин

одоо чиний шившгийг хот даяар зарлана гэж хаан Афрон хэлээд нэлээд дуугүйхэн байснаа дахин - За яахав, хэрвээ надад нэг тусыг хүргэвэл би чамайг өршөөнө. нэгэн улсад хаан Кусманд алтан дэлт морь бий. Тэр морийг надад олж ирвэл би чамд алтан тортой Гал шувуугаа өгнө гэлээ.

Хаан хүү Иван гунихран хөх чоно дээрээ ирэхэд чоно

- Торонд битгий хүрээрэй гэж би чамд хэлсэн шүү дээ. Хэлсэн шгийг минь яагаад мартав? гэхэд Иван
- Хөх чоно минь өршөөж үучил гэж

гүйв.

Хөх чоно за за миний нуруун дээр суу% хийвэл бүү ай, айвал бүү хий гэдэг юм гээд дахин цааш хурдлан давхив. Тэгээд алтан дэлт морины байгаа хэрэм хашааны гадаад ирээд

- Харуул манаа нь унтаж байгаа, хана түүргыг нь даваад ор. жүчээнд байгаа морийг нь авахдаа хазаарт нь битгий хүрээрэй гэв.

Хаан хүү Иван хэрэм ханыг даван орвол харуул манаанууд цөм унтаж байлаа. Тэгээд жүчээнд нь орон алтан дэлт морийг барин авахдаа үнэт чулуун шигтгээтэй алтан

хазаарыг нь хараад алтан длт моринд энэ хазаараас өөр ямар ч хазаар таарахгүй санагдан авахсан гэж бодов. Тэгээд хазаарт дөнгөж хүртэл цайз цамхгаар их чимээ гарч, урт бүрээ үзлээж, хэц бөмбөр дэлдэж харуул манаанууд нь сэргж Иваныг барьж аваад Кусман хаанд аваачиж өгөв.

- Хаанахын хэн гэгч вэ? гэж хаан Кусман асуухад

- Би хаан хүү Иван гэлээ

- За юуны учир морь хулгайлаа вэ? Энгийн эр ингэж зүрхлэхгүй. За яахав, чи надад нэг тус хүргэвэл би

чамайг хэлтрүүлье. Хаан Далмат Сайхан Елена гэдэг охинтой. сайхан Еленаг хулгайлсан авчирч өгвөл би чамд алтан дэлт морио хазаартай нь өгнө гэлээ.

Хаан хүү Иван үлам их гунихран хөх чонон дээр ирэв.

- Хазаарт битгий хүрээрэй гэж би чамд хэлсэн шүү дээ. Үгийг минь чи дуулсангүй гэж чонын хэлэхэд Иван үучилж өршөө гэлээ.

Чоно за за, алив над дээр морд гээд дахин цааш давхин хаан Далматын гадаа ирэв. Сайхан Елена гүнж асрагч эх, аягач шивэгчингүүдтэйгээ

зугаалж явав.

Хөх чоно - Энэ удаа чамайг явуулахгүй, өөрөө орно. Чи харин буцаад явж бай. Би одоохон чамайг гүйцнэ гэлээ. Хаан хүү эргээд явав.

Хөх чоно хэрэм ханыг даван цэцэрлэг дотор орон бутны ард нүүгдан зогсоод харж байтал сайхан Елена гүнж асрагч эх, аягач шивэгчингүүдтэйгээ гарaad ирлээ гэнэ шүү. Олуулаа ингэж зугаалж яваад Сайхан Елена гүнж нөгөөдүүлээсээ жаахан хоцорсхиймэгц хөх чоно үхасхийн шүүрч аван нуруун дээрээ дүүрэн буцаж зугтав. Хаан хүү Иван замаар

орон явж байтал гэнэт хөх чоно сайхан Еленаг дүүрээд давхиад ирлээ. Иван баярлан үгтажад хөх чоно

- Алив хурдан морд, араас хөөж магадгүй. гэлээ. Ингээд хөх чоно Сайхан Елена хаан хүү Иван хоёрыг аван хөх үсүг сүүлээрээ шүргэн хөхрөх ойг хөвөлзтөл хурдлан давхисаар Кусман хааны гадаа ирэв. Хөх чоно

- Хаан хүү Иван, яагаад гунихран гуниглаа вэ? гэхэд Иван

- Яаж гунихран гунихгүй байх юм бэ? гэжээ. Тэгэхэд хөх чоно

- Сайхан Еленаг би чамаас салгахгүй.  
Хаа нэг газар нуучихъя. Би сайхан  
Елена болон хувирна, чи намайг  
хаанд аваачиж өг гэжээ. Тэгээд тэр  
хоёр Сайхан Еленагаа ойн нэгэн  
байшинд нуугаад хөх чоно нэг  
тонгорон Сайхан Еленатай яг  
адилхан болон хувирав. Иван  
түүнийг хаан Кусманд аваачиж  
өгөхөд хаан ихэд баярлан "Чи надад  
сайхан эхнэр авчирч өглөө. Алтан  
дэлт морийг хазаартай ь ав" гээд  
өгөв. Хаан хүү Иван алтан дэлт  
морио унаад Сайхан Еленагаа  
нуусан газраасаа аван урдаа  
сундлан цааш явлаа.

Хаан Кусман их найр хурим

Өдөржин хийгээд орой нь Сайхан Еленаг амрах өргөөнд оруулжээ. Тэгээд дөнгөж орондоо орон хэвттэл сайхан эхнэрийн нь оронд чонын хоншоор харагдахад үхтлээ айн орноосоо үсрэн үнав. Хөх чоно ч зугтан одлоо.

Хөх чоно хаан хүүг гүйцэж ирээд "За яагаад бодол болоо вэ?" гэж асуухад Иван

- Бодол бололгүй яахав вэ? Ийм сайхан эрдэнэ мэт алтан дэлт морио Гал шувуунаас солих харамсалтай байна гэв. Хөх чоно "За чи битгий гунихар, би чамд тусална" гээд тэд явсаар Афрон хааны гадаа ирэв. Хөх

чоно

- Энэ морь, Сайхан Елена хоёроо чи нуучих, би алтан дэлт морь болон хувиръя. Чи намайг хөтлөөд хаанд аваачиж өг гэлээ. Тэгээд Сайхан Елена, алтан дэлт морь хоёроо ойд нуугаад хөх чоно нэг тонгоороод алтан дэлт морь болон хувирсанд хаан хүү түнийг хаан Афронд аваачиж өгөв. Хаан баярлан Иванд алтан тортой Гал шувуугаа бэлэглэв гэнэ.

Хаан хүү Иван ойд очин Сайхан Еленатайгаа алиан дэлт морин дээрээ сундалдан алтан тортой Гал шувуугаа барин төрөлх нутгийн зүг

явжээ. Хаан Афрон бэлгийн морио авчруулан мордох гэтэл алтан дэлт морь хөх чоно болон хувирав гэнэ. Хаан айн цочирдож падхийн үнахад хөх чоно хар хурдаараа зугтан давхисаар хаан хүү Иваныг гүйцэн ирэд

- Хөх чоно би үүнээс цааш явж болохгүй, за баяртай гэлээ. Хаан хүү Иван мориноосоо буун газар шүргэтэл гурав дахин бөхийн хөх чоныг хүндэтгэн талархаад чоно "Үүрд баяртай гэхгүй ээ, би чамд дахин хэрэг болно" гэв.

Хаан хүү Иван дотроо "Хүсэл бүгд минь биелсэн байхад чи дахин яаж

ч, юугаар ч тус болох билээ дээ" гэж боджээ. Тэгээд Сайхан Еленатайгаа алтан тортой Гал шувууугаа барьсаар алтан дэлт морио үнан цааш явсаар төрсөн нутагтаа орж ирээд амрахаар шийдэж нэг газар бүүн байсан жаахан талхаа хуваан идээд булгийн ус уугаад хэвтэж байжээ.

Хаан хүү Иваныг дөнгөж унтмагц Гал шувууг эрэн өөр газраар явж явж гар хоосон буцаж явсан ах нар нь дайралдан хүрч ирээд Иван бүх юмыг олж авсан байхыг хараад "Иваныг алаад хамаг юмыг нь авъя" гэж тохиролцжээ.

Тэгээд Иваныг алж хаячихаад алтан торт Гал шувууг нь аван алтан дэлт морин дээр нь Сайхан Елена гүнжийг суулган авч явжээ. "Гэрт очоод юу ч битгий хэл" гэж Сайхан Еленаг айлган сүрдүүлжээ. Хаан хүү Иваны хүүрэн дээр хэрээ шувууд эргэлдэн ниснэ гэнэ. Гэтэл хаанаас ч юм бэ хөх чоно давхин ирж эх хүү хоёр хэрээг зуурان барьж аваад

- Хэрээ чи нисэн явж билгийн үс, мөнхийн үс олж ир. Тэгвэл энэ бага хэрээг чинь суллан тавина гэлээ. Том хэрээ өөр арга байхгүй тул нисэн явж билгийн үс мөнхийн үс олж ирэв.

Хөх чоно хаан хүү Иваны шархыг билгийн усаар шүршихэд анил эдгэрэв. Дараа нь мөнхийн усаар шүршвэл амь орон сэргэв.

- Би ясан бөх үнтав аа
- Чи их бөн үнtsаан. Хэрвээ би ирээгүй бол сээрэх ч үгүй байсан. Төрсөн ах нар чинь ирээд чамайг алж, олз омгийг чинь бүгдийг аваад явчихсан. Алив хурдалъя, над дээр морд гэж хөх чоно хэллээ.

Тэгээд хаан хүү Иван хөх чоно хоёр хурдлын давхисаар ах нарыг гүйцэж очив. Хөх чоно хоёр ахыг нь барьж аван хэдэн хэсэг тас татан алж тал

хөндийгөөр тараан үстгав. Хаан хүү Иван хөх чононд хүндэтгэн талархаад салах ёс гүйцэтгээд алтан дэлт морио үнан гэртээ буцаж ирлээ. Хаан аавдаа алтан тортой Гал шувуу, өөртөө Сайхан Еленаг ингэж авчиржээ. Хаан Берендей баярлан хүүгээсээ аян замын нь тухай асуухад Иван хөх чоно түүнд яж тусалсан, унтаж байхад нь ах нар нь яж алсан, дараа нь ах нарыг нь хөх чоно алж тас татсан тухай цөмийг ярьж гэнэ.

Берендей хаан гашуудан байснаа удалгүй тайтгарчээ. Хаан хүү Иван Сайхан Еленатай гэрлэн эсэн мэнд энх амар жаргажээ.



# ХОЁР ИВАН

Ах дүү хоёр Иван байжээ. Нэг нь ядуу, нөгөө нь баян гэнэ. Баян Иваны гэрт элдэв зүйлийн эд баялаг элбэг дэлбэг гэнэ. Агуулах сав нь арвай будаагаар дүүрэн гэнэ. Нуу хөндийгөөр үхэр мал нь бэлчинэ, нуур голын захаар хонь хурга нь налайна гэнэ.

Халуун зүүханд нь хөвсгөр талх бөмбийнө гэнэ. Харин Иван эхнэртэйгээ хоёулхнаа гэнэ. Баян Иван том бага үр хүүхэд байхгүй гэнэ.

Ядуу Иванд намгийн мэлхий,

мааждаг муураас өөр амьтан байхгүй гэнэ. Харин долоон хүүхэдтэй, долоон хүүхэд нь булан буланд шигдэн суугаад будаатай хоол нэхнэ. Ядуу Иваны гэрт атга чимх гурил ч байхгүй, арвай будааны үр нэг ширхэг ч байхгүй гэнэ. Аргаа барсан ядуу Иван баян ахынх руугаа явжээ.

- Ах минь сайн байна уу?

- Аа, ядуу Иван, сайн байна уу? Яагаад гэртээ тогтохгүй байна, ямар хэргээр ирэв?

- Ах минь, жаахан гурил зээлдүүлээч, дараа нь би ажил хийж төлж өгнөө

- За тэг, тэг. гадар гурил ав, харин дараа нь шуудай гурил өгөөрэй
- Ах минь, юу гэсэн үг вэ? Гадар гурил өгчихөөд шуудайг авах гэж үү? Арай их юм биш үү?
- Их гээд байгаа бол эндээс зайл. Өөр газар очиж өр зээл тавь

Аргаа барсан Иван гашуудан үйлав, тэгээд гадар гурил аваад гэрийн зүг явжээ. Тэгсэн дөнгөж үүдэн дээрээ ирээд байтал салхи дэгдэн гадар дотор байсан гурилыг нь юу л үлдээлгүй үлээн хийсгэв. Гадарт нь юу ч үлдсэнгүй. Ядуу Иван уурлан

- Ээх зүггүй салхи, чи олон хүүхдийг  
минь гомдоож өлөн хоосон  
үлдээлээ. Хойт зүгийн дүрсгүй салхи  
чамайг би олж дэггүйтсэний чинь  
хариуг заавал төлүүлнэ дээ.

Ингээд Ядуу Иван салхины араас  
явав. салхи замаар орвол Иван  
замаар орон дагав, салхи ой руу  
чиглэв, Иван ч араас нь давхив.

Нэгэн асар том царс модны хонгил  
руу салхи орчихов. Иван ч бас л  
дагаад орчихлоо.

Салхи Иваныг үзээд

- Хэрэг зориг юунд вэ? гэж асуув

- Би өлөн зөлөн хэдэн хүүхэддээ атга гурил авч явсан чинь чи нисэн ирээд хийсгэчихлээ. Одоо би гэртээ яаж гар хоосон харих вэ?

- Өө иймхэн юмны төлөө бүү гунихар. энэ шидэт бүтээлгийг ав, хүссэн бүхэн чинь энэ бүтээлэг дээр бий болно гэж салхи хэлэв. Иван баярлан салхинд доор гэгчийн мэхийн талархаад гэр лүүгээ гүйжээ.

Гэртээ ирээд шидэт бүтээлгээ ширээн дээрээ дэлгээд

- Шидэт бүтээлэг минь шидээ үзүүлээч, үүж идэх юмаар ундаалан дайлаач гэв

Энэ үгийг дөнгөж хэлтэл бүтээлэг дээр хайрсан боов, хөөсөн талх, байцаатай шөл, гахайн өөх гээд л өнгө өнгийн амттан өрөгдөн бий болов гэнэ.

Ядуу Иван хүүхдүүдийнхээ хамт цадталаа идэж ууж аваад үнтжээ. Өглөө босоод шидэт бүтээлгээ дэлгээд үндлах гэж байтал Баян Иван иржээ.

Баян Иван ширээ дүүрэн амттаныг хараад атаархсандаа нүүр нь үлайн нүд нь бүлтийн

- Дүү минь чи чинь баян болоо юу?  
гэж асуув

- Баян ч болоогүй ээ, гэхдээ гэдэс цатгалан байх болно, таныг ч гэсэн дайлж чадна. Би танд шуудай гурилын өртэй байхаа, одоохон өгье. Шидэт бүтээлэг минь шуудай гурил өгөөч

Ядуу Иваныг ингэж хэлмэгц ширээн дээр шуудай гурил бий болов. Баян Иван гурилаа аваад юу ч хэлэлгүй гарч оджээ.

Баян Иван гурилаа аваад юу ч хэлэлгүй гарч оджээ. Орой болохын үед баян Иван дүүгийндээ гүйн ирж,

- Газар дээрх ганц дүү минь, туслаач! Эрхэм баян зочид энд тэндээс

хүрээд ирлээ. Манайх гэтэл халуун галгүй, бүлээн талхгүй яадаг билээ! Нэг, хоёрхон цаг шидэт бүтээлгээ өгөөч! гэж гэнэ. Ядуу Иван шидэт бүтээлгээ өгчээ. Баян Иван эрхэм зочдоо хооллоочоод элэгсэг дотноор үдчихээд ядуу дүүдээ шидэт бүтээлгийнх нь оронд ив ижилхэн гэхдээ энгийн нэгэн бүтээлэг аваачиж өгчээ. Ядуу Иван хүүхдүүдтэйгээ оройн хоол идэхээр сүугаад бүтээлгээ дэлгэн,

- Шидэт бүтээлэг минь, шидээ үзүүлээч, унд хоолоор үндан дайлаач! гэж гэнэ.

Цагаан бүтээлэг цайран цэмцийж

ямар ч хоол унд өгсөнгүй. Ядуу Иван ахындаа гүйж очин асуув.

- Та миний бүтээлгийг ясан бэ?

- Хэн мэдэх вэ, хэвээрээ л байгаа. Ямрыг авсан тиймийг л буцааж өгсөн.

Ядуу Иван гэртээ үйлан гаслан буцаж ирлээ. Нэг өдөр, хоёр өдөр өнгөрлөө, хүүхдүүд нь идэх юм нэхэн үйлна. Иваны гэрт атга чимх гурил ч үгүй, арвай будааны үр нэг ширхэг ч байхгүй аж. Аргаа барсан Иван баян ахынх рүүгаа очжээ.

- Ах минь, сайн байна уу?

- Аа, ядуу Иван, сайн байна уу, яагаад гэртээ тогтохгүй байна, ямар хэргээр ирэв?
- Хүүхдүүд минь идэх үүх юм нэхэн уйлаад байна. Ах минь, жаахан гурил эсвэл будаа, талх өгөөч.
- Чамд өгөх гурил, будаа, талх аль аль нь алга. Зооринд торхон дээр жижиг тавагтай жимсний зутан байгаа, тэрийг авбал ав.

Ядуу Иван тавагтай зутан аваад гэрийн зүг явжээ. Нар хурцаар ээн тавагтай зутангий нь хайлуулсаар зутан нь тавагнаасаа халин газар асгарчээ. Иван уурлан,

- Аах аальгүй нар, чиний тоглоом миний хүүхдүүдэд шоглоом боллоо. Нар чамайг би олж дэггүйтсэний чинь хариуг заавал төлүүлнэ дээ!

Ингээд Иван нарны эрэлд гарчээ. Ядуу Иван яваад л байж яваад л байж өмнөхөн нь улаан нар улалзаад л байж. Зөвхөн оройдоо нар үүлын цаагуур орлоо гэнэ. Иван нарыг тэндээс олжээ. Нар Иваныг үзээд асуув.

- Хэрэг зориг юу вэ?

- Жижиг балчир хүүхдүүддээ жимсний зутан авч явсан чинь чи хурцаар ээн хутгаж хайлуулаад

асгачихлаа. Одоо би гэртээ яаж гар хоосон харих вэ?

- Өө зүгээр зүгээр, би чамайг гомдоосон, би чамайг баярлуулна. Өөрийнхөө сүргээс нэг ямаа өгнө. Бөндгөр боргоцойгоор тэжээгээрэй, бөөн бөөн алт сааж аваарай. Иван баярлан наранд доор гэгч бөхийн талархаад ямаагаа түүн гэртээ иржээ. Тэгээд бөндгөр боргоцойгоор тэжээчхээд бөөн бөөн алт сааж авах болжээ. Ядуу Иван ингэж үр хүүхдээ өлсгөлгүй сайн сайхан амьдрах болов гэнэ.

Ямааных нь тухай баян Иван сонсоод дүүгийндээ гүйн иржээ.

- Сайн байна уу, дүү минь!
- Баян Иван, сайн байна уу!
- Газар дээрх ганц дүү минь, туслаач! Ганцхан цаг ямаагаа надад өгөөч. Өр ширээ дарах гэсэн өгөх мөнгө байдаггүй!
- За ав, харин хүурч болохгүй шүү.  
Баян Иван алт сааж аваад ямааг нуугаад дүүдээ жирийн нэг адилхан ямаа туун аваачиж өгчээ.  
- Дүү минь, гялайлаа, чи надад их тус боллоо!

Ядуу Иван нөгөө ямааг нь  
боргоцойгоор тэжээгээд саасан  
чинь... Сүү гарч гэнэ. Сүү гараад л алт  
байдаггүй гэнэ.

Ядуу Иван ахындаа гүйн очвол ах нь,

- Хэн мэдэх вэ, хэвээрээ л байгаа,  
ямрыг авсан тиймийг л буцааж  
өгсөн! гэв.

Ядуу Иван үйлсаар гэртээ буцав.  
Өглөө орой ээлжилсээр өдөр хоног  
өнгөрсөөр. Хүүхдүүд нь идэх юм  
уйлан нэхнэ. Хахир хүйтэн өвөл  
болов. Харин Иваныд атга чимх  
гурил ч үгүй, арвай будааны үр нэг ч  
ширхэг байхгүй гэнэ. Аргаа барсан

Иван ахындаа очлоо.

- Хүүхдүүд идэх юм нэхээд үйлаад байна. Ах минь, атга гурил өгөөч!
  - Чамд өгөх гурил, будаа, талх алга. Өчигдөр чанасан байцаатай шөл үүдний тавиур дээр байгаа түүнийг авбал ав.
- Ядуу Иван түмпэнтэй шөл аваад гэрийн зүг явлаа. Салхи шуурга исгэрэн хүйтэн жавар тасхийж түмпэнтэй шөлийг нь тас хөлдөөжээ. Ядуу Иван уурлан,
- Аах, жартгар улаан жавар! Чиний тоглоом миний хүүхдүүдэд шоглоом

боллоо. Чамайг би олж дэггүйтсэний чинь хариуг заавал төлүүлнэ дээ! гэв.

Тэгээд ядуу Иван жаврын эрэлд явав. Аглаг хөндийгөөр жавар давхив, араас нь Иван дагав. Ойн гүн рүү орчхов, огт алдахгүй мөрдөв. Жавар хүнхэр том хүнгарын доогуур ороод хэвтэхэд Иван ч дагаад орлоо. Жавар гайхан,

- Хэрэг зориг юу вэ? гэж асуув.
- Түмпэнтэй шөл аваад явж байтал түүнийг минь чи хөлдөөчихлөө. Одоо би гэртээ яаж гар хоосон харих вэ? Шидэт бүтээлэг, алтан сүүт ямааг минь ах минь хуураад авчихсан, чи

миний шөлийг хөлдөөчихлөө.

- Өө, ердөө л энэ үү! Энэ тусг үүтыг ав. «Хоёулаа үутнаас гар!» гэхээр л хоёр хүн гараад ирнэ. «Хоёулаа үутандаа ор!» гэхлээр л эргээд орчихно гэж гэнэ.

Иван доор гэгч бөхийн талархаад гэр лүүгээ явжээ. Гэртээ ирээд үутаа гарган,

- Хоёулаа үутнаас гар! гэжээ.

Энэ үгийг хэлмэгц үутнаас хоёр нарсан бороохой үсрэн гарч ирээд Иваныг нүдэн,

- Баян хүнд бүү итгэ! Баян ахдаа бүү итгэ! Бодолтой ухаантай бай! гээд л байх юм гэнэ.

Иван арайхийн «Хоёулаа үутанд ор!» гэж амжиж хашгирав. Хоёр бороохой үутанд орон чимээгүй боллоо. Орой болмогц баян ах нь гүйн ирж,

- Хаагуур яваад ирэв, юу олж ирэв?  
гэж гэнэ.

- Жаварынд очоод ирлээ. Тус т үүт бэлэглэж байна. «Хоёулаа үутнаас гар!» гэхээр л үутнаас хоёр хүн гарч ирээд юу хүссэнийг чинь хийж өгнө!  
гэж ядуу Иван хэлэв.

- Хөөрхий ганц дүү минь, тэр үутаа надад нэг өдөр өгөөч! Байшингийн минь дээвэр нурж хэмхэрсэн, засаж залах хүн олдохгүй байна.

- Баян Иван ах минь, аваа ав!

Баян Иван тусгүй уутыг гэртээ авчраад үүдээ дотроосоо түгжиж байгаад,

- Хоёулаа үутнаас гар! гэж хэлжээ.

Тэгтэл үутнаас хоёр нарсан бороохой үсрэн гарч баян Иваныг балбаж нүдэн,

- Баян Иван, чи ядуу хүнийг бүү гомдоо, бүү хуур! Ядуу Иваны шидэт

бүтээлэг, алтан сүүт ямааг одоохон аваачиж өг! өг! өг! гээд л зогсоо чөлөөгүй балбаж гэнэ. Баян Иван ядуу дүү рүүгээ гүйхэд хоёр бороохой ч араас нь хөөн нүднэ.

- Дүү минь, авраач, амь насыг минь өршөөгөөч! Шидэт бүтээлэг, алтан сүүт ямааг чинь одоохон өгье гэв.
- Хоёулаа үутанд ор! гэж дүү Иван хашгирлаа. Хоёр бороохой үутандаа орон нуугдав. Үхэхээ шахсан баян Иван ядуу дүүдээ шидэт бүтээлэг, алтан сүүт ямааг нь авчирч өгчээ.

Ядуу Иван тэр цагаас хойш үр хүүхдүүдийнхээ хамт энх амар сууж

эсэн мэнд жаргажээ. Долоон хүүхэд нь долоон буландаа сүугаад тостой амтлаг будаагаа хээтэй өнгөтэй халбагаар тавтай түхтай иддэг гэнэ лээ.

# ГЭРЭЛТ ШОНХОР ФИНИСТ

Нэгэн тариачин байжээ. Эхнэр нь нас барж гурван охинтой үлджээ. Өвгөн хөлсний хүн авч гэр орны ажилдаа туслуулах гэсэн боловч бага охин Марьушка нь,

- Эцэг мињь, гаднын хүн авч ажиллуулаад юухэв, гадаа гэр дэх ажлаа би амжуулаад байна гэжээ.

За тэгээд охин Марьушка нь гэр орныхоо бүх ажлыг хийх болов гэнэ. Бага охинд нь чадахгүй хийхгүй юм гэж алга байлаа, сайн ч хийнэ, хурдан ч хийнэ гэнэ. Ийм ухаантай ажилсаг охин өсөж байгаад эцэг нь

баярлан, Марьюшкадаа их л хайртай байдаг байжээ. Марьюшка бас үзэсгэлэнтэй гоо сайхан охин гэнэ. Атаархан хорсогч хоёр эгч нь өнгө үзэмж муутай гэнэ, өдөржингөө зүгээр сууж эрх биеэ янзалж элдэв хувцас өмсдөг гэнэ. Ховдог хоёр эгчид нь ямар ч бошинз бошинз биш, ямар ч гутал гутал биш, ямар ч алчуур алчуур биш гэнэ. Нэг удаа эцэг нь зах явах болж охидоосоо,

- Хайртай гурван охин минь, дуртай бэлгээ захиарай гэж гэнэ.

Том дунд хоёр охин нь,

- Алтан утсаар хатгасан алаг том

цэцэгтэй алчуур авчирч өгөөрэй гэв.  
Харин Марьушка дув дуугүй  
зогсоно.

- Охин минь, чамд юу авчрах вэ? гэж  
эцэг нь дахин асуухад Марьушка,
- Эцэг минь, та надад гэрэлт шонхор  
Финистийн ганцхан өд авчирч өгөөч  
гэжээ.

Эцэг захаас эргэж ирэв, их дунд  
охиддоо алчуур авчрав.

Харин өд олсонгүй ажээ.

Дараа нэг удаа эцэг бас л зах явах  
олж,

- Хайртай охид минь, дуртай юмаа захиарай! гэв. Том дунд хоёр охин нь баярлан,
- Мөнгөн тахтай хөнгөн сайхан гутал авчирч өгөөрэй! гэж захив.
- Эцэг минь, та надад гэрэлт шонхор Финистийн ганцхан өд авчирч өгөөрэй! гэж Марьюшка захиж гэнэ. Эцэг өдөржингөө яваад өд олсонгүй, мөнгөн тахтай хөнгөн гутал л олжээ. Тэгээд өдгүй буцаж ирлээ.

Гурав дахь удаагаа өвгөн зах явахад хоёр том охин нь торгон бошинз захижээ. Марьюшка дахиад л,

- Эцэг минь, гэрэлт шонхор  
Финистийн ганц өд авчирч өгөөрэй  
гэв.

Өдөржингөө эцэг зах дээгүүр яваад  
өд сөдийг олсонгүй гэнэ. Тэгээд  
хотоос гараад явж байсан өөдөөс нь  
нэг хөгшөөн өвгөн явж харагдана  
гэнэ.

- Амар сайн уу, өвөө!

- Амар сайн уу, хүү минь! Хаанаас  
хаа хүрч явна даа?

- Харьж явнаа, харин гаслантай  
зовлонтой явна даа. Бага охин минь  
гэрэлт шонхор Финистийн ганц өд

захисан би олсонгүй.

- Нандигнан хадгалдаг нэг өд наадад бий, сайн хүнд харамгүй өгнө.

Тэгээд өвгөн өврөөсөө нэг өд гарган өгсөн нь энгийн нэгэн өд аж.

Марьушка энэ өдний юунд нь дурласан юм бол доо! гэж тариачин харих замдаа бодов. Өвгөн охиддоо бэлгээ өгөхөд том дунд хоёр охин нь шинэ хувцсаа өмсөн үзэж бас Марьушкаг шоолон хөхрөлдөнө.

- Ээх тэнэг минь, тэнэг минь, энэ өдөө үсэндээ зүүгээд гоё доо!  
ГЭЦГЭЭНЭ.

Марьушка юу ч хэлсэнгүй холдон  
яваад шөнө болж цөм хүн унтсаны  
дараа өдөө шалан дээр тавиад  
шивгэнэн,

- Гэрэлт шонхор Финист минь, хүсэн  
хүлээсэн нөхөр минь, хүрээд ирээч!  
ГЭВ.

Тэгтэл үгээр хэлшгүй үзэсгэлэнтэй  
сайхан залуу бий болж гэнэ. Өглөө  
сайхан залуу шал мөргөн шонхор  
шувуу болоход Марьушка гэгээвчээ  
нээв. Гэрэлт шонхор шувуу хөхрөх  
тэнгэрийн гүн рүү хөөрөн нисэн одов  
гэнэ. Ингээд гэрэлт шонхор шувуу  
өдөртөө хөх тэнгэрээр нисэн  
шөнөдөө Марьушка рүү нисэн ирж

сайхан залуу болон хувирсаар гурван хоног болов гэнэ. Дөрөв дэх өдөр нь атаархагч хорон санаат хоёр эгч нь үүнийг олж мэдээд эцэгтээ ховложээ.

- Та нар өөрсдийнхөө байгааг хар! гэж эцэг нь хоёр том охиноо хариу зэмлээд өнгөрөв.

«Аа тийм үү! Ахиад цаашилбал юу болохыг харья л даа!» гэж хоёр эгч нь шүд зуугаад Марьюшкагийн цонхны жаазанд олон хурц хутга шивэн зоогоод өөрсдөө нуугдан харж байжээ.

Гэрэлт шонхор шувуу нисэн ирээд

Марьушкагийн гэгээвч цонхоор орох гээд чадсангүй, зүтгэж зүтгэж энгэр биеэ эсгэж шархдуулав. Гэрэлт шонхор шувуу,

- Хэрэгтэй болоод эрсэн хүн хэзээ ч гэсэн намайг олно. Гэхдээ энэ амар биш. Төмөр гутал гурвыг элээж, төмөр таяг гурвыг хугалж, төмөр малгай гурвыг сэтэлж байж л намайг олно гэв.

Энэ үгийг сонсоод Марьушка орноосоо үсрэн босож цонхoo харвал шонхор шувуу байдаггүй гэнэ. Харин цонхон дээр нь цусны мөр үлдсэн байна гэнэ. Марьушка гашуун нулимсаа урсган үйлж цусан

мөрийг нулимсаараа угаажээ. Гэхдээ улам сайхан үзэсгэлэнтэй болов гэнэ. Тэгээд эцэг дээрээ очин,

- Эцэг минь, аашилж битгий хориорой, алсын замд явъя би. Эсэн мэнд байвал эргэж үулзах биз, үхэл хэрвээ дайрвал үйл лай тэр биз гэж гүйжээ.

Хайртай охиноо алсад явуулах гэдэг хөгшин эцэгт их л хэцүү байлаа, гэхдээ явуулжээ.

Марьюшка төмөр гутал гурвыг, төмөр таяг гурвыг, төмөр малгай гурвыг захиалж хийлгээд гэрэлт шонхор Финистээ эрэхээр алсын

замд гарлаа гэнэ. Өндөр уул, өргөн тал, харлах их ой, харгуй урт замаар яваад л байжээ. Жигүүртэн шувууд хөгжилдөн жиргэж зүрхийг баясгана, жижигхэн гол горхи сэргүүцүүлэн угаана, харанхуй ой шөнөдөө унтах гэр болно гэнэ. Хөх чоно, хүрэн баавгай, шар үнэг цөм

Марьушкай андлан цугларсан болохоор охинд хэн ч халдан довтолж чадахгүй байлаа.

Марьушка явсаар явсаар төмөр гутлаа элээжээ, төмөр таягаа хүгалжээ, төмөр малгайгаа сэтэлжээ. Тэгээд нэгэн аглагт гарвал тахиан хөлт байшин эргэлдэн байна гэнэ. Марьушка байшинд,

- Байшинхан байшинхан, ар ханаа ой рүү ангайх хаалгаа над рүү харуулаач. Үүд хаалгаар чинь орж үмх талх идье гэж гэнэ.

Байшин ар ханаа ой рүү ангайх хаалгаа Марьушка рүү харууллаа. Охин байшинд явж орвол тэнд тааз тулсан хамартай, тахир ясан хөлтэй Шулмас эмгэн хамар амаа тавиур дээр тавиад хананаас хананд хөлөө жийгээд хэвтэж байв.

Шулмас эмгэн Марьушкаг үзмэгцээ орилон,

- Паах пөөх, оросын үнэр үнэртэж байна! Сайхан бүсгүй минь, хэрэг

зориг юунд вэ? гэлээ.

- Эмээ минь, гэрэлт шонхор Финистийг эрж явнаа.
- Өө үзэсгэлэнт охин минь, эрлийн зам чинь урт юм байна! Чиний гэрэлт шонхор зуун уулын цаанатаа зургаан улсын тэртээ бий! Илбэт хатан түүнийг ногоон хандаар дайлж эхнэр нь болон суусан даа. Гэхдээ би чамд тусална. За май, энэ мөнгөн таваг алтан өндгийг аваад яв. Зуун уулын цаанатаах зургаан улсын тэртээх улсад очмогцоо хатных нь зарц бол. Хий гэснийг нь хийчихээд мөнгөн таваг дээрээ алтан өндгөө өнхрүүлж тогло, өндөг

өөрөө өнхрөн эргэлдэнэ. Хатан зараач гэж гуйвал бүү өг, харин гэрэлт шонхор Финисттэй үулзуул гэж гүй. Ингэж Шулмас эмгэн зааж өгөв.

Марьушка Шулмас эмгэнд талархаад цааш явав. Ой мод харанхуйлан зүг чиг харагдахаа байхад Марьушка урагш алхахаас айн зогстол өмнөөс нь нэг муур гарч ирээд,

- Марьушка, бүү ай, урагшаа яв яв. Улам аймшигтай болно, чи эргэж харалгүй яваад бай гэлээ. Муур нуруу нь үзэгдээд л алга болов. Марьушка цааш явжээ. Ой улам

харанхуй боллоо. Марьушка явсаар төмөр гутлаа элээжээ, төмөр таягаа хугалжээ, төмөр малгайгаа сэтэлжээ. Тэгсэн гал гэрэл улалзсан гавлын ясан толгойтой шивээ хашаан дотор тахиан хөлт байшин байна гэнэ.

- Байшинхан байшинхан, ар ханаа ой рүү ангайх хаалгаа над рүү харуулаач. Үүд хаалгаар чинь орж үмх талх идье гэж Марьушка хэлэв.

Байшин ар ханаа ой рүү ангайх хаалгаа Марьушка рүү харуулав. Охин байшинд орвол тааз тулсан хамартай, тахир ясан хөлтэй Шулмас эмгэн хамар амаа тавиур дээр тавиад хананаас хананд хөлөө

жийгээд хэвтэж байна гэнэ. Шулмас эмгэн Марьюшкаг хараад,

- Паах пөөх, оросын үнэр үнэртэж байна. Үзэсгэлэнт бүсгүй минь, хэрэг зориг юунд вэ? гэлээ.
- Эмээ минь, гэрэлт шонхор Финистийг эрж явнаа.
- Миний дүүгийнхээр орсон биз дээ?
- Орсоон орсон, эмээ минь.
- За яахав, би чамд тусалъя. Энэ мөнгөн тэлүүр алтан зүүг ав. Энэ зүү үзмийн өнгөт хамбан дээр алтан мөнгөн утсаар өөрөө оёх болно.

Зараач гэвэл битгий зар, гэрэлт шонхор Финисттэй уулзуулаач гэж гүй гэж зааж өгөв.

Марьушка Шулмас эмгэнд талархаад цааш явлаа. Энд тэнд түг түг юм нүдэн исгэрч хашгирах дуу чимээ гарна. Гавлын яс ойг гэрэлтүүлнэ. Марьушка айн зогстол өмнөхөн нь нэг нохой гүйж явав.

- Охин минь, бүү ай, урагшaa яв яв. Улам аймаар болно, харин чи эргэж харалгүй яваад бай.

Нохой ингэж хэлээд алга болчихов. Марьушка цааш яваад л байж ой ч улам их харанхуй болоод байж.

Ханцуйнаас нь татах юм гэнэ, хөлөөс нь зуурах юм гэнэ... Марьюшка эргэж харалгүй яваад л байжээ. Ийнхүү явсаар төмөр гутлаа элээжээ, төмөр таягаа хугалжээ, төмөр малгайгаа сэтэлжээ. Тэгээд нэгэн аглагт гарвал улалзах улаан галтай адууны гавлан толгойтой шивээ хашааны дотор тахиан хөлт байшин эргэлдэн байна гэнэ.

- Байшинхан байшинхан, ар ханаа ой руу ангайх хаалгаа над руу харуулаач гэж Марьюшка хэлэв. Байшин ар ханаа ой руу ангайх хаалгаа Марьюшка руу харууллаа. Охин байшинд орвол тааз тулсан хамартай, тахир ясан хөлтэй Шулмас

Эмгэн хамар амаа тавиур дээр тавиад хананаас хананд хөлөө жийгээд хэвтэж байна гэнэ. Аймаар хар тэр Шулмас эмгэний амнаас нэг соёо ёрдойно. Шулмас эмгэн Марьушкаг үзээд,

- Паах пөөх, оросын үнэр үнэртэж байна! Үзэсгэлэнт бүсгүй минь, хэрэг зориг юунд вэ? гэлээ.
- Эмээ минь, гэрэлт шонхор Финистийг эрж явнаа.
- Эх, эрлийн зам чинь эндэлтэй дондолтой. За яахав, би чамд тусалъя. Май, энэ мөнгөн суурьтай алтан ээрүүлийг ав. Ээрүүлийг

гартaa авахад л энгийн биш алтан утас эргэлдэн эргэлдэн цуврах болно.

- Эмээ минь, танд гялайлаа.
- Баярлах гялайхаа сүүлд хэл, одоо захих хэлэх үгийг минь тогтоо. Алтан ээрүүлийг чинь авъя гэвэл бүү зараарай. Харин гэрэлт шонхор Финисттэй уулзуулаач гэж гүй. Шулмас эмгэн ингэж зааж өгөв.

Марьушка Шулмас эмгэнд талархаад цааш явлаа. Ой шуугин исгэрэн, үлээх их чимээ гарч, ууль шувуу нисэлдэн, хулгана оготно нүхнээсээ гаран Марьушка рүү

дайрав. Гэнэт өмнө нь хөх чоно гүйж яваа харагдav.

- Охин минь, бүү ай, бүү сандар. Нуруун дээр минь суу, эргэж битгий хар гэж чоно хэллээ гэнэ. Марьушка чонын нуруун дээр суумагц чоно ч хурдлан давхилаа. Урд нь өргөн тал өнгөт ногоон нуга, жимсэн эрэг, бал гол харагдана. Өндөр уул үүлэнд тulan сүндэрлэнэ. Марьушка давхиад л байлаа. Гэнэт өмнө нь болор цамхаг тулав. Хээлж сийлсэн довжоотой гэнэ, хээ хуартай цонхтой юм гэнэ. Цонхон дээрээ хатан алсыг ширтэн зогсоно.

- За Марьушка, бүү даа. Энэ хатны

зарц бол гэж чоно хэллээ.

Марьушка баадангаа барьсаар бууж чононд талархаад болор цамхаг рүү орж хатанд мэхийн,

- Алдар нэрийг тань мэдэхгүй юм, өршөө, ажил хийх хүн хатан танд хэрэггүй биз? гэлээ.
- Утас ээрч, юм нэхэж, оёж хатгах хүнийг аль хэдийнээс би эрсэн билээ гэж хатан хариулахад Марьушка,
- Энэ бүх ажлыг би хийж чадна гэв.
- За тэгвэл ор, заасан бүгдийг хий. Ингээд Марьушка тэр хатны зарц болжээ. Өдөржин ажилчихаад орой

боловхойн мөнгөн таваг алтан өндгөө гарган,

- Алтан өндөг мөнгөн тавган дээгүүр өнхөр өнхөр, амраг хонгорыг минь надтай уулзуул гэж шивнэнэ. Алтан өндөг мөнгөн тавган дээгүүр өнхрөн бөндөгнөхөд тавган дээр гэрэлт шонхор Финистийнх нь дүр гараад ирнэ. Хайртыгаа харсан Марьюшка нулимсаа цувруулан,

- Гэрэлт шонхор Финист минь, Финист минь, гэргий чинь чамайг санан гашуудан үйлж байна... гэнэ.

Хатан энэ үгийг нь тагнаж чагнаад,

- Марьушка, мөнгөн таваг алтан өндгөө надад зараач гэхэд  
Марьушка,
- Энэ юмыг зарж худалдаж болохгүй. Хэрвээ та гэрэлт шонхор Финистийг харах зөвшөөрөл өгвөл би энэ таваг өндөг хоёроо өгнө гэлээ. Хатан бодож бодож,
- За тэг тэг. Шөнө унтахаар нь чи хараарай гэв. Шөнө болов.  
Марьушка гэрэлт шонхор Финистийн амрах өргөөнд орлоо гэнэ. Хайртай нөхөр нь гүн нойронд дарагдан унтаж байв. Марьушка харж ханахгүй зогсоно. Амтат уруулаараа үнсэнэ, ангир цээжиндээ

тэвэрнэ, хайртай нөхөр нь гүн  
нойронд дарагдан унтыаар л байв.  
Өглөө боллоо. Марьушка нөхрөө  
сэрээж чадсангүй... Дараа өдөр нь  
Марьушка өдөржин ажиллачихаад  
орой нь мөнгөн тэлүүр алтан зүүгээ  
гарган хээ угалз хатган,

- Угалз хээ минь, урга урга, гэрэлт  
шонхор Финист өглөө босоод энэ  
алчуураар нүүрээ арчиг гэж  
шивгэнэн суужээ.

Хатан үүнийг нь тагнан чагнаад,

- Мөнгөн тэлүүр алтан зүүгээ надад  
зараач гэв.

- Гэрэлт шонхор Финисттэй уулзуулах юм бол би зүгээр өгнө. Хатан бодож бодож,
- За яахав, шөнө ирээрэй гэжээ.

Шөнө болов. Марьюшка гэрэлт шонхор Финистийн амрах өргөөнд орлоо гэнэ. Хайрт нөхөр нь гүн нойронд дарагдан унтаж байв гэнэ.

- Гэрэлт шонхор Финист минь, сэрээч, босооч! Гэрэлт шонхор Финист гүн нойрондоо дарагдан унтараар байв. Марьюшка дуудаад дуудаад сэрээж чадсангүй. Маргааш өдөр нь Марьюшка мөнгөн суурьтай алтан ээрүүлээ гарган утас ээрэв.

Хатан түүнийг нь харчихаад,

- Надад зараач, зараач! гэж гэнэ.
- Зарахгүй ээ, харин гэрэлт шонхор Финисттэй нэг цаг болохноо ч үулзахыг зөвшөөрвөл зүгээр өгнө гэж Марьушкаг хэлэхэд хатан «Тэртэй тэргүй сэрээж чадахгүй» гэж бодоод тэг тэг гэжээ. Шөнө болов.  
Марьушка гэрэлт шонхор  
Финистийн амрах өргөөнд оров.  
Хайрт нөхөр нь гүн нойронд  
дарагдан унтана гэнэ.
- Гэрэлт шонхор минь, сэрээч,  
босооч! Марьушка хайрт нөхрөө  
дуудаад дуудаад сэрээж чадсангүй,

удахгүй үүр цайх болсон тул гашуун нулимсаа цувруулан,

- Энхрий Финист минь, сэрээч сэрээч, эхнэр намайгаа хараач хараач, элэг зүрхэндээ наан тэврээч гээд л үйлжээ.

Марьушкагийн нулимс гэрэлт шонхрын нүцгэн мөр дээр дусан халуу цоргин түлэв гэнэ. Гэрэлт шонхор гэнэт сэрэн сэхээрч гэргий Марьушкагаа харан тэврэн авч үнсээд,

- Марьушка, энэ чинь чи ю? Төмөр гутал гурвыг элээж, төмөр таяг гурвыг хугалж, төмөр малгай гурвыг

сэтэлж намайгаа олов уу? Одоохон эх нутагтаа буцъя гэлээ. Тийнхүү тэр хоёрыг эх нутгийн зүг явахаар бэлдэхийг харсан хатан урт бүрээ үлээж, улс амьтан цуглувалж, урвагч нөхрийн тухай уухайлан зарлахаар зарлигдлаа гэнэ.

Тайж ноёд, тариачид худалдаачид цуглаж, урвагч мую нөхөр гэрэлт шонхор Финистийн гэм зэмийг шүүх боллоо. Тэгэхэд нь Финист.,

- Эртний тангаргаа буцалгүй эгнэгт бат хайлрадаг нь уу, элдэв зүйлсийн бараанаас эр нөхрөө худалддаг нь уу, аль нь жинхэнэ эхнэр вэ? гэж асууж гэнэ.

Тэгээд гэрэлт шонхор Финистийн жинхэнэ эхнэр бол Марьюшка гэж тогтжээ. Тэр цагаас хойш хайрт хоёр хагацалгүй жаргажээ. Улс орондоо ирээд урт бүрээ үлээж, их буу буудаж олныг донсолгосон найр хурим хийжээ.

# ЭГЧ ДҮҮ ХОЁР

Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр байжээ. Тэднийх Алёнушка гэдэг охинтой, Иванушка гэдэг хүү

Эмгэн өвгөн хоёр нас барж эгч дүү хоёр хоёулхнаа үлджээ. Алёнушка ажил хийхээр болж дүүгээ аваад явжээ. Тэгээд хоёулаа өргөн талаар алсыг зорин явж байтал Иванушка ам цангаад байна гэв.

- Худаг хүртэл тэвч дээ, дүү минь гэж эгч нь хэлээд тэр хоёр цааш яваад л байж, яваад л байж. Улаан нар төөнөхийг хэлэх үү, үстай худгийн холыг хэлэх үү!

- Эгчээ, би энэ үхрийн туурайнд тогтсон үснаас ууя гэж гэнэ.
- Болохгүй, дүү минь болохгүй, тугал болчихно. Дүү нь үгэнд нь орж цаашаа явжээ. Улаан нар төөнөхийг хэлэх үү, үстай худгийн холыг хэлэх үү!
- Эгчээ, би энэ морины туурайнд тогтсон үснаас ууя гэж Иванушка дахиад л гүйжээ.
- Болохгүй, дүү минь болохгүй, унага болчихно. Тэгээд хоёулаа цаашаа яваад л байж. Улаан нар төөнөхийг хэлэх үү, үстай худгийн холыг хэлэх үү!

- Эгчээ, энэ ямааны туурайнд тогтсон уснаас уүя, ам цангаад үхэх нь гэж Иванушка дахиад гүйжээ.

- Болохгүй, дүү минь болохгүй, ишиг болчихно. Иванушка эгчийнхээ үгэнд орсонгүй, ямааны туурайнд тогтсон уснаас үучижжээ. Тэгээд тэр дорхноо ишиг болоод хувирчихаж...

Алёнушка дүүгээ дуудаад л байж гэтэл дүүгийнх нь оронд нэг цагаан ишиг гүйгээд иржээ.

Алёнушка нэгэн жижиг бухлын дэргэд суугаад үйлав гэнэ.

Хажууд нь цагаан ишиг тонгочин

тоглоно.

Тэр үед дэргэдүүр нь нэг худалдаачин явж байгаад,

- Үзэсгэлэнт охин минь, юундаа үйлаа вэ? гэхэд Алёнушка юу болсноо цөмийг ярьжээ.

Худалдаачин,

- Авааль эхнэр минь болохгүй юу? Алт мөнгөөр гоёно, амь насаа зориулна. Ишиг ч бидэнтэй үргэлж хамт байг гэжээ. Алёнушка бодож бодож худалдаачны эхнэр болжээ.

Тэгээд гурвуулаа амар сайхан амьдарч ишиг ч Алёнушкатай нэг

аяганаас хоол үнд ууж идэн жаргалтай сууцгаажээ. Нэг удаа худалдаачныг эзгүй байхад хаанаас ч юм нэг эмгэн хүрч ирээд Алёнушкаг усанд орьё гэж их л эелдэгхэн дуудаж гэнэ. Гэтэл энэ нь Шулмас эмгэн байжээ. Шулмас эмгэн Алёнушкаг гол дээр авчраад гэнэт дайран барьж хүлээд хүзүүнд нь хүнд чулuu зүүгээд ус руу түлхчихжээ.

Тэгээд өөрөө Алёнушка болж хувираад хувцас хунарыг нь өмсөөд гэрт нь ирээд сууж байжээ. Энэ тухай хэн ч мэдсэнгүй, эмгэн Шулмасыг хэн ч таньсангүй, тэр ч байтугай худалдаачин эргэж ирээд ч таньсангүй. Зөвхөн ишиг л бүгдийг

мэдэж байжээ. Цагаан ишиг толгойгоо унжуулан юм ууж идэх ч үгүй, өглөө оройдоо голын эргээр гүйн,

- Эгч минь, эгч минь!

Эрэг рүү сэлээд гарaad ирээч дээ!.. гэнэ.

Үүнийг нь Шулмас эмгэн мэдчихээд худалдаачнаас энэ ишгийг алаад өгөөч гэж гүйжээ...

Ишгэнд дасаж хайртай болсон худалдаачин ишгийг алж чадахгүй өрөвдөөд байжээ. Гэтэл эхнэр нь алаач алаач гэж гүйгаад байх юм

гэнэ. Худалдаачны арга нь барагджээ. Шулмас эмгэн их гал түлж ширмэн тогоо тавиад хурц хутга ирлэ! гэж тушаав гэнэ.

Ишиг хуурай аав нь болсон худалдаачинд,

- Үхэхийнхээ өмнө гол рүү очиж балга үс үүж гэдсээ зайлъя гэж гүйжээ.

Худалдаачин тэг тэг гэжээ. Ишиг ч гол рүү гүйн ирж гомдолтой дуугаар,

- Эгч минь, эгч минь! Эрэг рүү сэлээд гараад ирээч! Ширүүн гал асаж

Ширмэн тогоо халж байна.

Болд хутгаа ирлээд

Бор гэдсийг минь хагалах гэж байна!

Алёнушка хариуд нь,

- Хөөрхий бяцхан дүү минь дээ!  
Хүзүүн дэх чулүү ёроол рүү чангаана.  
Хөвөрсөн өвс ногоо хөл гарыг  
орооно. Хүрэн шар элс цээжийг  
дарна! гэж гэнэ.

Шулмас эмгэн ишгийг алуулах гэж  
эрж эрж нэг зарцаа гол рүү  
явуулжээ.

Зарц гол дээр иртэл ишиг голын  
эргээр гүйж гомдолтой дуугаар  
эгчийгээ дуудаж байна гэнэ.

- Эгч минь, эгч минь! Эрэг рүү сэлээд  
гараад ирээч! Ширүүн гал асаж

Ширмэн тогоо халж байна.

Болд хутгаа ирлээд

Бор гэдсийг минь хагалах гэж байна!

Голоос эгч нь түүнд,

- Хөөрхий бяцхан дүү минь дээ!  
Хүзүүн дэх чулuu ёроол руу чангаана.

Хөвөрсөн өвс ногоо хөл гарыг

орооно. Хүрэн шар элс цээжийг  
дарна! гэж хариулж байх юм гэнэ.

Зарц эргэж гүйн худалдаачинд  
сонссон харсан бүхнээ хэлжээ.  
Худалдаачин олон хүн цуглуулан том  
урт тортон тор гол руу хаяж  
Алёнушкаг гаргаж авав.  
Алёнушкагийн хүзүүн дэх чулууг авч  
хаяад, булгийн усанд оруулаад шинэ  
хувцас өмсүүлэхэд урьдынхаасаа  
улам сайхан болон амь орон босож  
иржээ.

Цагаан ишиг баярлахдаа гурав  
тонгортол дахиад Иванушка болон  
хувирав. Ингэж эгч дүү хоёр эсэн  
мэнд эргэж үулзжээ.

Харин хорон санаат Шулмас  
эмгэнийг хурдан морины сүүлнээс  
үян тас татуулжээ.

# ҮҮЛЭН БОР

Гурван хүүтэй өвгөн байжээ. Хоёр том хүү нь орон гэрийнхээ ажлыг амжуулдаг овсгоотой сэргэлэн гэнэ. Бага хүү Иван нь тэнэг гэнэ. Ойд явж мөөг түүх дуртай, гэртээ бол пийшин дээрээ хэвтээд өнждөг гэнэ. Өвгөн нас эцэслэх цаг болоход хөвгүүдээ дуудан,

- Намайг үхсэний дараа гурван шөнө дараалан булшин дээр минь очиж талх авчирч өгөөрэй гэж захижээ. Тэгээд ч өвгөн насан эцэслэж хөвгүүд нь оршуулжээ. Эхний шөнө болж булш руу явах том хүүгийн ээлж ирэв. Том хүү нэг бол залхуурч, нэг

бол айсан уу, ямар ч гэсэн явсангүй,  
харин Иванд,

- Чи өнөө шөнө миний оронд эцгийн булшин дээр талх аваачиж өгөөд ирээч! Би чамд боов авч өгнө шүү гэв. Иван зөвшөөрч талх аван эцгийн булшин дээр очин хүлээн суув. Шөнө дунд гэнэт газар хагаран эцэг нь босож ирээд,

- Хэн ирээв? Миний том хүү юу? Орос нутгаар сонин юу байна? Өлөн чоно үлилдаж, өлсгөлөн ноход хуцаж, үр хүүхэд минь уйлж байна уу? гэж асууж гэнэ.

- Таны хүү байнаа. Орос нутаг амар

тайван байнаа, эцэг минь! гэж Иван хариулав.

Эцэг талх цадталаа идээд булшиндаа эргэж хэвтэв. Иван замдаа баахан мөөг түүгээд гэртээ харив. Том ах нь,

- Аав байна үү? гэв.

- Байнаа.

- Талх идэв үү?

- Идсээн, цадталаа идсэн.

Хоёр дахь шөнө болов. Дунд хүүгийн явах ээлж болоход тэр залхуурсан ч

юм уу, айсан ч юм уу, ямар ч гэсэн явсангүй. Харин Иванд,

- Чи миний оронд эцэг дээр очоод ирээч! Би чамд шаахай сүлжиж өгнө шүү гэв.

Иван зөвшөөрч талх аван эцгийн булшин дээр очиж хүлээн суув. Шөнө дунд гэнэт газар хагаран эцэг нь босож ирээд асуув.

- Хэн ирээв? Миний дунд хүү юу? Орос нутгаар сонин юу байна? Өлөн чоно улилдаж, өлсгөлөн ноход хуцаж, үр хүүхэд минь үйлж байна юу?

- Таны хүү байнаа. Орос нутаг амар тайван байнаа, эцэг минь! гэж Иван хариулав.

Эцэг талх цадталаа идээд бүлшиндаа эргэж хэвтлээ. Иван замдаа баахан мөөг түүгээд гэртээ ирэхэд дунд ах нь,

- Эцэг талх идэв үү? гэв.

- Идсэн, цадталаа идсэн. Гурав дахь шөнө болов. Иван ах нартаа,

- Би хоёр шөнө дараалан явсан. Одоо та хоёр эцгийн бүлшин дээр оч, би амармаар байна гэжээ. Хоёр ах нь,

- Иван, чи юу ярина вэ! Чи явж сурсан, чи л явсан дээр! гээд халгаасангүй.

Иван талх аваад явав. Шөнө дунд газар хагаран эцэг нь босож ирээд

- Хэн ирээв? Миний бага хүү Ваня юу? Орос нутгаар сонин юу байна? Өлөн чоно улилдаж, өлсгөлөн ноход хуцаж, үр хүүхэд минь үйлж байна ўу? гэж асуухад Иван,

- Таны хүү Иван энд байнаа. Орос нутаг амар амгалаан, эцэг минь гэв.

Эцэг талхыг цадталаа идээд,

- Миний захиасыг ганцхан чи л биелүүллээ. Гурван шөнө миний булш руу айлгүй ирлээ. Чи цэлгэр хөндий, цэнхэртэх талд гараад «Илбэт Үүлэн бор морь минь, эрээн үүлыг эрэлзтэл эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч!» гэж хашгиран дууд. Сайхан морь чам руу давхиад ирнэ, чи баруун чихээр нь ороод зүүн чихээр нь гар. Тэгээд чи хүч чадал ихтэй сайн эр болно, сайхан мориндоо мордож алсыг зорь гэжээ.

Иван хазаарыг аван эцэгтээ талархаад замдаа баахан мөөг түүгээд гэртээ харив гэнэ. Хоёр ах нь,

- Аав байна үү? гэв.

- Байнаа.

- Талх идэв үү?

- Идсээн, цадталаа идсэн, дахиж битгий ирээрэй гэсэн.

Энэ үед хаан ард олныхоо дунд зар тараажээ. «Ганц бие, хань бүлгүй сайн эрчүүд хааны ордны гадаа цуглар. Хааны Хосгүй үзэсгэлэнт охин арван хоёр баганатай арван хоёр давхар гуалин цагирагтай цамхаг босгохыг зарлигдсан гэнэ. Тэр цамхгийнхаа хамгийн өндөрт Хосгүй Үзэсгэлэнт гүнж суугаад ямар эр

мориныхоо ганц үсрэлтээр уруулд нь хүрч үнсэхийг хүлээнэ гэнэ.  
Гүнжийн уруулд хүрч үнссэн хүчит морьтон эрд ямар хүний үр байсан ч хамаагүй, хаан охиноо эхнэр болгон өгч хаант үлсынхаа хагасыг нэмж бэлэглэнэ» гэнээ.

Энэ тухай хоёр ах нь сонсоод хоорондоо «Азаа үзье» гэж ярилцав гэнэ.

Тэгээд сайн морьдоо тэжээж үслаад өөрсдөө сайхан хувцсаа өмсөөд үсээ самнаж зүсээ янзлав гэнэ. Иван пийшин дээрээ сүүж байснаа,

- Ах нар минь, намайг аваад яваач.

Цүг явж азаа үзье! гэхэд нөгөө хоёр нь,

- Пийшин Иван, чи дуугүй бай! Олны доог болж явснаас ойд явж мөөг түү гэжээ.

Ингээд хоёр ах нь малгай юугаа духдуулаад магнай морио унаж үүн гэж хавираад уухайлан давхижээ, улаан тоос л ард нь үлджээ. Тэгэхэд Иван хазаараа аван цэлгэр талд гараад эцгийнхээ зааснаар,

- Илбэт Үүлэн бор морь минь, эрээн үүлыг эрэлзтэл эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэж дуудав.

Гэтэл газар дэлхий чичиргэн нэгэн морь давхин ирсэн нь хамрынх нь нүхнээс дөл дүрэлзэн, чихнээс нь утаа олгойдно гэнэ. Морь газар хадагдах мэт зогтусан,

- Тушаагтун! гэв.

Иван морио илэн таалаад хазаарлан, баруун чихээр нь орж зүүн чихээр нь гарвал үгээр хэлшгүй үзгээр бичишгүй сайхан төрсөн сайн эр боллоо гэнэ. Тэгээд мориндоо мордон хааны ордон руу давхижээ. Үүлэн бор морь нь нисэх мэт давхихад газар дэлхий чичрэн үул толгод урсан ханарч ургаа хад хэвтээ хожуул дөрвөн туурайн хоорондуур

жирэлзэн өнгөрнө гэнэ. Иваныг хааны ордны гадаа ирэхэд үй олон хүн үймэлдэн цугларсан байв. Арван хоёр баганатай арван хоёр давхар гуалин цагирагтай цамхгийнхаа хамгийн өндөрт цонхон дээрээ Хосгүй Үзэсгэлэнт гүнж сүүж байв гэнэ. Хаан үүдэн дээрээ гаран,

- За, эрхэм сайн эрчүүдээ! Та нарын хэн нь мориныхоо харайлтаар тэр цонх хүртэл үсэрг ч охины минь уруулыг үнсэх вэ? Тэр эрд би охиноо, хаант үлсынхаа хагасыг өгнө гэв.

Сайн эрчүүд ээлжлэн давхиж үзлээ. Цамхгийн оройд хүршгүй өндөр аж!

Иваны хоёр ах харайгаад цамхгийн дунд нь ч хүрсэнгүй. Иваны ээлж ирлээ. Иван Үүлэн бор морио гүядан үүхай хийн үхасхийн үсэрвэл хоёрхон цагираг дутав. Дахин цойлж ахиад нэг үсэrsэн чинь ганцхан цагираг дутав гэнэ. Гурав дахь удаагаа цойлон Үүлэн бор морио тасхийтэл гүядан үүлэнд тултал үсэрч өндөр цонхонд хүрч Хосгүй Үзэсгэлэнт гүнжийн балын амтат уруулыг шүргэн үнсэхэд гүнж ч Иваны духан дээр бөгжөөрөө хүрч тэмдэг тавьж амжив гэнэ. Олон түмэн шуугилдан,

- Эрэлхэг эрийг бариад ав, бариад ав! гэлээ.

Гэтэл эрэлхэг эр бараа сураггүй давхин одов. Иван цэлгэр талд давхиж ирээд Үүлэн борынхoo зүүн чихээр орж баруун чихээр гараад дахин тэнэг Иван болон хувирчээ. Тэгээд морио суллан тавиад замдаа баахан мөөг түүгээд гэртээ ирж духаа алчуураар боогоод пийшин дээрээ гарч хэвтжээ.

Хоёр ах нь буцаж ирээд хаана байсан, юу үзсэнээ ярив гэнэ.

- Сайхан төрсөн сайн эрчүүд цугларсан даа. Гэхдээ нэг онцгой сайн эр мориороо үсрэн гүнжийг үнсэж чадсан. Хаанаас ирснийг нь цөм харсан, харин хаашаа явсныг нь

хэн ч мэдэхгүй хоцорлоо гэцгээв.

- Тэр чинь би байсан юм биш үү? гэж Иваныг хэлэхэд хоёр ах нь уурлан,
- За тэнэг минь, дуугаа тат. Пийшин дээрээ мөөгөө идэж суу гэлээ.

Гүнжийн бөгжөөрөө хүрч тэмдэг тавьсан духныхаа боолтыг Иван автал гэр дүүрэн гэрэл туяа цацрав. Хоёр ах нь айн,

- Тэнэг минь, чи юу хийж байна? Гэр орон шатаах нь үү! гэж хашгирлаа.

Маргааш нь хаан өргөн их найр хийх болж дээд түшмэлээс аваад доод

ардыг хүртэл баян ядуу, хөгшин залуу хүн бүгдийг урин залж гэнэ. Иваны хоёр ах найранд явахаар бэлдэхэд Иван,

- Би цуг явъя! гэв.

- Тэнэг минь, олны инээдэм болсноос орон гэртээ суугаад олсон мөөгөө идэж бай гээд хоёр ах нь малгай юугаа духодуулаад магнай морьдоо унаад яваад өгч гэнэ. Иван явган явсаар хааны найранд ирээд хамгийн захын ширээнд суужээ.

Хосгүй Үзэсгэлэнт гүнж зочин олноо зочлон хүндэтгэж амтат балтай аягыг өргөн барьж аль хүний духан дээр

тэмдэг байна гэж харна гэнэ.

Гүнж бүх зочиндоо бал бариад Иван руу дөхөж ирэхдээ зүрх нь шимшрэн өвдлөө гэнэ. Тэгээд Иваныг харвал үс гэзэг нь арзайсан үнс тортог болсон хүн сууж байна гэнэ. Хосгүй  
Үзэсгэлэнт гүнж,

- Хаанах газрын хүн бэ? Хaa хүрч явна вэ? Юуны учир духаа боогоо вэ? гэж түүнээс асуухад Иван,
- Цохичихсон юмаа гэж өчив.

Гүнж духовных нь боолтыг тайлбаас ордон дүүрэн гэрэл туяа гялбан цацрав гэнэ.

- Энэ миний тэмдэг байна! Миний заяаны хань энэ байна! гэж гүнж хэлэв.

Хаан ойртон ирж,

- Юуны чинь заяаны хань! Үнс тортог болсон аймаар амьтан байх чинь гэхэд Иван,

- Нүүр гараа угаагаад ирэхийг зөвшөөрнө үү гэв. Хаан зөвшөөрчээ. Иван гадаа гараад эцгийнхээ зааснаар,

- Илбэт Үүлэн бор морь минь, эрээн үүлыг эрэлзтэл эрэг газрыг жирэлзтэл давхиад ирээч! гэж

дуудлаа.

Тэгтэл ч хамрынх нь нүхнээс дөл дүрэлзсэн, чихнээс нь утаа олгойдсон нэгэн морь тэнгэрээс унасан мэт давхиж ирэхэд газар дэлхий ганхан чичрэв гэнэ. Иван мориныхоо баруун чихээр ороод зүүн чихээр гарч тааж хэлж баршгүй тайлж зурж болшгүй сайхан төрсөн сайн эр болон хувирч гэнэ. Үй олон ард үймэлдэн гайхав гэнэ, үг дуугарч чадалгүй үулгалан суув гэнэ.

Хөлгүй их найрыг хөгжилтэй хурим залгаж гэнэ, сонин үлгэр ингээд төгслөө, сонссон хүнд гялайлаа.

## ЖАВАР

Нэгэн өвгөн өөрийн эхнэргүй болоод өөр эмгэнтэй сув. Өвгөн нэг охинтой, эмгэн нэг охинтой гэнэ. Хойт эхийн гарг амьдарна гэдэг ямар хэцүүг цөм мэднэ, тоглон гүйлээ гэж зодуулна, томоотой суулаа гэж балбуулна, илүүдүүллээ гэж нудруулна, дутуудууллаа гэж дугтчуулна. Өөрийнхөө охиныг юу ч хийсэн магтан ухаантай сайныг нь гайхан үруул цорвойн үнсэж үгийн сайныг хэлнэ, үс толгойгий нь илнэ.

Өвгөний охин үүрээр босон үнээгээ саана, үс түлээгээ оруулна, зуух

пийшингээ галлана, гэр орноо  
шүүрдэнэ...

Харин хойт эх хашгиран хараан  
загнана, юу ч хийсэн мүү гэнэ,  
мүухай гэнэ.

Дэгдсэн салхи намддаг байхад  
дэндсэн эмгэн харин уlam давардаг  
байлаа. Тэгээд бүр хөөрхий охиныг  
хөөж, энэ хорвоогоос тонилгох гэж  
шийдээд,

- Энэ охиныг хоёр нүдэнд минь  
харагдахгүй холын хол аваачиж хая!  
Харанхуй хар ойд хага хөлдөөх  
жаварт аваачиж хая! гэж өвгөндөө  
үглэх болжээ.

Өвгөн гашуудан гунихран үйлж үйлж арга чаргаа баржээ. Авгайн үгнээс зөрөхийн арга байхгүй байлаа.  
Тэгээд морио тэргэндээ хөллөн,

- Охин минь, чарганд суу гээд авч яваад харанхуй ойд аваачаад хунгар их цасан дунд том гачуур модны доор орхичихоод явчихжээ.

Хөөрхий охин гачуурын доор суун дааран бөндгөнөтөл чичрэн байв.  
Тэгээд чих тавин чагнавал Жавар өвгөн хажууханд нь гачуураас гачууранд үсрэн ороолгож чахран исгэрэх нь дуулдав. Жавар өвгөн охины байгаа гачуурын дээр ирээд асуув.

- Охин минь, дулаахан байна уу, даараагүй биз дээ?
- Даараагүй ээ, даараагүй, Жавар өвөө минь! Жавар доошлон тас няс хийтэл үлээн,
- Хөөрхөн охин минь, даараагүй биз дээ? Дулаахан байна уу? гэж асуухад охин бээрч хөшсөн эрүү амаа арай ядан эвлүүлэн,
- Даараагүй ээ, даараагүй, Жавар өвөө минь!

Жавар бүүр ч доошлон охиныг ороолгон тас няс хийтэл исгэрэн үлээв.

- Хөөрхөн охин минь, даараагүй биз дээ? Дулаахан байгаа биз дээ?  
Даараагүй биз дээ? гээд л дахин асуув. Охины хамаг бие нь хөшин хөлдөж эхэллээ, тэгсэн ч уруулаа хөдөлгөн,

- Даараагүй ээ, даараагүй, Жавар өвөө минь! гэлээ. Тэгэхэд Жавар өвгөн охиныг өрөвдөн дулаахан дээлээр хүчин, өдөн хөнжлөө нөмөргөв.

Хойт эх охиныг оршуулах юм бэлдэн хуймаг бин хайрч өвгөнийг хашгиран загнан,

- Алив, хөгшин зөнөг толгой чи яваад

охиноо аваад ир, одоо оршуулах  
болсон биз! гэлээ.

Өвгөн ой руу явж нөгөө газраа ирвэл  
том гачуурын доор охин нь халууцан  
хацар нь улайчихсан, булган дээл,  
алт мөнгөн гоёл өмсөж зүүчихсэн,  
хөгжилтэй хөөртэй зогсож байв гэнэ.  
Охиных нь хажууд үнэт бэлэг дүүрэн  
хайрцаг сав өрөөстэй гэнэ.

Өвгөн баярлан охиноо чаргандаа  
суулган бэлэг сэлтийг нь ачин гэрийн  
зүг давхижээ.

Хойт эх гэртээ хүймаг бин хайрна,  
ширээн доорх нохой нь,

- Хав, хав! Өвгөний охин алт мөнгөнд хүчигдан ирж явна, эмгэний охиныг эр нөхөр авахгүй дээ гэх юм гэнэ. Хойт эх нохойд бингээсээ шидэж өгөөд,
- Худлаа хуцаад байх юм! «Эмгэний охиныг эр нөхөр авна, өвгөний охины ясыг авчирч явна» гэж хуцаач! гэв.

Тэгтэл нохой ахиад л,

- Хав хав! Өвгөний охин алт мөнгөнд хүчигдан ирж явна, эмгэний охиныг эр нөхөр авахгүй дээ! гэх юм гэнэ. Хойт эх бингээсээ шидэж өгсөн ч нохой нөгөө л хэлдгээ хэлнэ гэнэ,

нохойгоо гүядаж шавхуурдаж үзэж гэнэ, нохой нөгөө л хэлдгээ хэлээд хүцах юм гэнэ.

Гэнэт хаалга дуугаран үүд нээгдэн гэрэл гэгээ цацарсан алт мөнгөн гоёлтой булган дээлтэй сайхан охин орж ирсэн нь өвгөний охин байв. Хойноос нь үнэт их бэлэгтэй том том хайрцаг сав оруулж ирэв. Хойт эх гарaa алдлан уулгалж...

- Хөөе, хөгшин толгой чи морио хөллө! Миний охиныг тэр газраа аваачаад орхи...

Өвгөн чаргандаа эмгэний охиныг суулган ойд аваачин нөгөө том

гачуурын доор гүн их хунгар дээр бүулгаж орхиод буцаж ирэв гэнэ. Эмгэний охин дааран эрүү ам нь хавиран сууна. Жавар өвгөн гачуураас гачууранд үсрэн тас няс хийтэл ороолгон исгэрэн, эмгэний охиныг харж байснаа,

- Охин минь, даараагүй биз дээ? гэхэд эмгэний охин,
- Ясан хүйтэн юм бэ! Тас няс хийтэл бүү үлээгээч! гэж орилов гэнэ.

Жавар улам доошлон бууж улам ширүүн шууран үлээгээд,

- Даараагүй биз дээ, охин минь,

даараагүй биз дээ? гэлээ.

- Хөл гар хөлдлөө хөлдлөө, хүйтэн  
Жавар чи холд холд... гэж дахиад л  
орилов.

Жавар модны ёроол руу буун  
охиныг тас няс хийтэл үлээн исгэрэн,

- Хөөрхөн охин минь, даараагүй биз  
дээ? Даараагүй биз дээ? гэв.

- Аах оох, хөлдөж үхлээ! Хараал  
идсэн хар Жавар чи далд орооч! гэж  
эмгэний охин хашгирав.

Жавар уурлан хилэгнэж үлам  
ширүүнээр шуурахад эмгэний охин

хөлдөж үхжээ.

Гэгээ ормогц эмгэн өвгөнөө загнан,

- Хөгшин толгой, морио хөллө! Алив хурдал, алт мөнгөнд хучигдсан охиныг минь аваад ир!.. гэжээ. Өвгөн яваад өгөв. Ширээн доороос нохой,

- Хав хав! Өвгөний охиныг эр нөхөр авна, эмгэний охины ясыг шуудайд хийгээд авчирна даа гэв.

Эмгэн нохойд боов шидэж өгөөд,

- Худлаа хуцаад байх юм! «Эмгэний охин алт мөнгөнд хучигдан ирж

явна» гэж хуцаач! гэхэд нохой нөгөө л хэлдгээ хэлээд хуцаад байв гэнэ.

- Хав хав! Эмгэний охины ясыг шуудайд хийгээд авчирч явна...

Гадаа чимээ гарахад эмгэн охиноо угтхаар гүйн гараад хаалга үүдээ нээвэл хөлдөж үхсэн охин нь чарган дээр хэвтэж байлаа.

Эмгэн халаглан үйлав, гээд өнгөрсөн хойно яах ч билээ!

## ЭС МЭДЭХ ЗҮГТ ЗОРЧ, ҮЛ МЭДЭХ ЮМЫГ АВЧИР

Эрт урьд цагт ганц бие нэг хаан байжээ. Андрей гэгч мэргэн харваачтай юмсанжээ.

Нэг өдөр Андрей харваач ан гөрөөнд яваад өдөржингөө ой шугуйгаар хэссэн боловч ан ав олз омог дайралдсангүй. Тэгээд үдшиин хэрд их л урамгүй буцаж явтал нэг хүүрзгэнэ шувуу модон дээр сууж байх харагдав гэнэ. «Хоосон буцсанаас энэ шувууг аваад явъя» гэж бодоод харватал шархдан газар үнажээ. Андрей хүүрзгэнэ шувууны хүзүүг нугалж үүргэвчиндээ хийхээр

газраас автал шувуу хүний хэлээр,

- Алтан амийг минь өршөөгөөч, ам хүзүүг минь бүг мушгиач! Амьдаар минь аваачаад цонхон дээрээ суулга, тэгээд зүүрмэглэж эхэлмэгц баруун гараараа цохиод аваарай. Тэр цагт танд аз жаргал ирнэ гэх юм гэнэ. Хүний хэлээр ярьдаг сонин шувуу анх удаагаа үзсэн Андрей хормын зуур гайхашран зогссонoo шувууны хүссэнээр бүгдийг хийхээр шийдэж хүүрзгэнэ шувууг гэртээ аваачин цонхон дээрээ суулгаад хэзээ л үүрэглэх бол гээд харуулдан зогсжээ.

Хүүрзгэнэ үdsан ч үгүй далавчин

доогуураа толгойгоо шургуулан үүргэлж эхлэв гэнэ. Андрей хэлсэн ёсоор нь баруун гараараа цохиод автал шувуу элгээрээ харуулдан газарт унуутаа үгээр хэлшгүй үзэсгэлэн гоо, үлгэрийн дагина мэт Марья гүнж болон хувирав гэнэ.  
Тэгээд,

- Авчирч намайг чадсан юм чинь асран халамжилж чадах биз дээ. Энэ ганц насы чинь элбэрэлт хань чинь болъё гэж өгүүлжээ.

Тэгээд мэргэн харваач Андрей Марья гүнжтэй ханилан сууж амар сайхан амьдрах болжээ. Гэхдээ Андрей үүрийн гэгээнээр босож

өдөржин ой модоор явж элдэв ан авлаж эзэн хаанаа баярлуулдаг эртний уламжлалт албаа өчүүхэн төдий ч мартаагүй гэнэ. Марья нэг удаа нөхөртөө,

- Андрей минь, амьдрал маань ядуухан байна. Чи хүнээс зүүн рубль зээлдэж олоод өнгө өнгийн тортон утас авчирч өгөөч, хоёулаа ахуй амьдралаа дээшлүүлье гэж гэнэ. Андрей олон хүнээс ганц нэгээр зээлдсээр зууд хүргэн өнгө өнгийн тортон утас худалдан аваад Марья гүнжид авчирч өгчээ. Марья гүнж утсыг нь аваад,

- Оройноос өглөө сэргэлэн гэдэг дээ,

за одоо чи унтаж амар гэжээ.

Андрейг унсаны дараа Марья гүнж авчирсан утсаар нь шөнөжингөө хивс нэхэн суужээ. Улс гүрнээ бүхэл бүтнээр нь, хот тосгон, уул шугуй, ус мөрөнтэй нь багтаан, хөх тэнгэрт нь жигүүртэн шувуу ниссэн, хөглөгөр хаданд нь ан гөрөө сүлжилдсэн, хөлгүй далайд нь загас жараахай сүрэглэсэн, нар сар ээлжлэн гийсэн, навч цэцэг нь эрээлэн алагласан, урьд өмнө үзэгдэж харагдаагүй сайхан хивс нэхэж гэнээ.

Өглөө Марья гүнж хивсээ нөхөртөө өгөөд,

- Энэ хивсийг зах зээлийн газар аваачаад зарчихаад ир! Өөрөө чи битгий үнэ хэлээрэй. Хүн ямар л үнэ өгнө, түүгээр нь зарчихаад ир гэжээ.

Андрей хивсээ гар дээрээ тохон захаар явж байтал нэг худалдаачин ирж,

- Эрхэм минь, хивс ямар үнэтэй вэ? гэж гэнэ. Андрей,

- Чи наймаа хийдэг хүн, өөрөө үнэ өгөөд ав гэжээ. Гэтэл тэр худалдаачин Андрейн хивс шиг хивс үрьд нь үзээгүй болохоор үнэлж чадахгүй, дэмий л хивсний сайхныг магтан зогсоход хүмүүс тал талаас

гүйлдэн ирсээр төдөлгүй олон хүн шавааралдан цуглаж хивсний гоё сайхныг магтана. Гэхдээ хэн нь ч таарч тохирох үнэ хэлж чадсангүй.

Тэр үед тэдний хажуугаар өнгөрч явсан хааны зөвлөх олон хүн цугласныг хараад сүйх тэрэгнээсээ буун хүмүүсийн дундуур хүчлэн зүтгэсээр голд нь орон,

- Эрхэм худалдаачид, харийн зочид оо! Сайн байцгаана үү? Та нар юунд ийнхүү шавааралдана вэ? гэж асуухад худалдаачид,

- Энэ хивсийг үнэлж чадахгүй байна гэв. Хааны зөвлөх Андрейн ер бусын

гоёмсог сайхан хивсийг хараад,

- Чи ийм сайхан хивс хаанаас олов?

гэхэд мэргэн харваач,

- Манай эхнэр нэхсэн билээ гэв.

- Ямар үнэтэй юм бэ дээ?

- Би үнэ хэлж мэдэхгүй байна. Тэгээд ч эхнэр маань хүний хэлсэн үнээр өгөөрэй гэж захисан юм.

- Тэгвэл би арван мянгаар авъя гээд хааны зөвлөх хивсийг нь авч хаандаа үзүүлэхээр явахад Андрей ч мөнгөө аван гэрийн зүг буцжээ.

Хааны зөвлөх хаандаа хивсээ авчирч үзүүлбэл улс гүрэн нь уул ус газар тэнгэртэйгээ гоёмсог сайхнаар багтсаныг хараад хаан дуу алдаж,

- Чи яадагсан өөрөө мэд, харин хивсийг чинь би буцааж өгөхгүй гээд хорин мянган рубль гаргаж гартаа нь албан хүчээр атгуулжээ. Хааны зөвлөх хорин мянган рубль авахдаа «За яахав, би үүнээс гоёыг хийлгээд авна даа» гэж боджээ.

Тэгээд сүйх тэргээ хөлөглөн давхисаар мэргэн харваачийн гэрийг хайж олоод хаалгыг нь тогшжээ. Хааны зөвлөх хаалга тайлж өгсөн Марья гүнжийг хармагцаа

зорьж ирсэн хэргээ мартан, зогссон газраасаа хөдөлж чадахгүй хөшин, үзэсгэлэн гоог нь ширтэн гөлрөн зогсжээ. Марья гүнж түүнийг юу хэлэх гэсэн юм бол хэмээн хүлээж ядаад хаалгаа хаажээ. Тэр цагаас эхлэн хааны зөвлөх харваачийн эхнэрийг бодож хоол үнднаасаа гарч хорчийн турж царай алджээ.

Хаан зөвлөхийнхөө байдлыг ажиж мэдээд,

- Яагаад чи ийнхүү уруу царайлан явах болов? гэж асуувал зөвлөх нь,
- Мэргэн харваач Андрейн эхнэрийг үзсэнээс хойш тэр хүүхэн үргэлж

бодогдоод байдаг болчихлоо. Хоол унд ч орохoo болилоо гэжээ.

Хаан зөвлөхөөсөө ийм үг сонсоод тэр эхнэрийг өөрөө очиж үзмээр санагджээ. Тэгээд хаан энгийн хувцас өмсөөд харваачийн гэрийг олж очин хаалгыг нь тогшиж гэнэ. Хаан хаалга нээж өгсөн Марья гүнжийг хармагцаа зорьж ирсэн хэргээ мартан, босгон дээгүүр нь нэг хөлөө тавиад орж ч чадахгүй, буцаж ч чадахгүй хөшиж, үзэсгэлэн гоо гүнжийг ширтэн гөлрөн зогсов гэнэ.

Марья гүнж юу хэлэхийг хүлээж ядаад үүдээ арга буюу хаажээ.

Тэр цаг мөчөөс хойш хаан «Би юунд ингэж ганцаар гуниглан амьдарна вэ! Энэ сайхан хүүхэнтэй гэрлэхсэн. Хааны хатан байваас зохих хүүхэн юм!» гэж зүрх шимшрэн боддог болжээ.

Тэгээд хаан харваачаас эхнэрийг нь салгаж, амьдын хагацалд учруулъя гэсэн нэгэн хар санаа санажээ.  
Ингээд зөвлөхөө дуудан,

- Би харваачийн эхнэртэй суумаар байна. Тэгэхээр чи Андрейг үгүй хийх арга сүвэгчил. Хэрвээ чамайг тийм арга олох юм бол бүхэл бүтэн хот тосгон хөрөнгө мөнгөөр урамшуулан шагнана, чадахгүй бол

толгойгий чинь авна гэжээ.

Энэ зарлигийг яаж биелүүлэх вэ? гэж хааны зөвлөх их л бодож шаналжээ, гэхдээ харваачийг үгүй хийх арга олсонгүй. Ингээд уй гашуугаа нимгэлж хундага дарс ууж дотроо онгойлгохоор үндааны газар оржээ. Гэтэл тэнд сууж байсан ноорхой нэгэн хүн дэргэд нь ирэн,

- Хааны зөвлөх та үйтгарлан гуниглаж уруу царайлахын учир юу вэ? гэж асуув.
- Олон таван юм ярилгүй, эндээс зайл! гэж хааны зөвяөх тэр ноорхой эрийг хөөхөд,

- Хөөж загнахынхаа оронд хундага дарс авч өг, тэгвэл би хэргийг чинь бүтээж өгье гэж гэнэ. Тэгэхээр нь хааны зөвлөх тэр ноорхойд аяга дарс өгөөд өөрийнхөө зовлонгоо ярьжээ.
- Андрей харваачийг алах түн амархан. Өөрөө эргүү тэнэг энгийн хүн, харин эхнэр нь л арга заль ихтэй дээ. Гэхдээ бид эхнэр нь ч даахааргүй алба онооё. Чи хаандаа очоод Андрей харваачийг насан эцэслэсэн хаан эцгийнхээ амар мэндийг мэдээд ир гэж явуул. Андрей яваад эргэж ирэхгүй гэж гэнэ.

Хааны зөвлөх ноорхой эрд  
талархаад ордон руу гүйн очив.

- За хаан минь, харваачаас хагацах нэг арга байна гээд хааш нь юунд явуулах аргаа зааж өгөв гэнэ. Хаан баярлан Андрей харваачийг дуудуулав.
- За Андрей минь, ан авын ажлыг үнэнчээр чи гүйцэлдүүлдэг, одоо нэг алба биелүүл! Чи диваажинд очоод хаан эцэг минь ямаршуухан амьдарч буйг мэдээд ир. Мэдэж ирэхгүй юм бол миний сэлэм гялс чиний толгой бөндгөс... гэв.

Андрей гэртээ буцаж ирээд вандан

дээрээ толгой гудайлган суухад  
Марья гүнж,

- Юндаа гуниглаа вэ? Гай зовлон  
тохиолдов үү? гэхэд Андрей хаан  
эзэн ямар алба оноосныг ярив.  
Марья гүнж,

- Үүнд юунд нь шаналах вэ! Энэ ч  
бага алба, жинхэнэ хэцүү алба  
цаашид тохиолдоно. Одоо чи унт,  
оройноос өглөө сэргэлэн гэдэг гэж  
гэнэ.

Андрейг өглөө эрт сэрэхэд Марья  
гүнж хүүдий дүүрэн хатсан талх, нэг  
алтан бөгж өгөөд,

- Одоо хаанд очин зөвлөхөө та надтай хамт явуулаач, ганцаар явбал тэр газар очоод ирснийг хэн ч итгэхгүй гэж хэл. Тэгээд замд гармагцаа бөгжөө өмнөө шид, очих газрыг чинь заагаад өгнө гэлээ.

Андрей хүүдий талх, алтан бөгжийг аваад эхнэртэйгээ салах ёс хийгээд хааны ордон руу явжээ. Хаан зөвлөхөө Андрейтэй цуг диваажинд очоод ир гэж зарлигдахаас өөр аргагүй болов.

За тэгээд хоёул замд гарчээ. Андрей бөгжөө өмнөө шидэхэд бөгж нь бөмбөрөн өнхөрнө. Андрей бөгжөө даган өргөн тал, өвст нуга, ус голыг

гатлан туулан явахад араас нь хааны зөвлөх дагана.

Ядарч цуцахаараа талхнаасаа идчихээд л цааш явна. Ийнхүү явсаар явсаар өтгөн шигүү ойд орж гүнзгий жалганы ёроолд бууж иртэл гэнэт бөгж нь зогсчихжээ. Андрей, хааны зөвлөх хоёул суугаад талхаа идэж байсан чинь хоёр чөтгөр нэг хөгшин хааныг баахан мод овоолж ачсан тэргэнд хөллөчихсөн хоёр талаас нь бороохойdon хөөж яваа үзэгдэв гэнэ.

- Энэ чинь манай хааны эцэг биш байгаа? гэж Андрейг хэлэхэд,

- Чиний зөв, энэ танай хааны эцэг түлээ зөөж явна гэв.

Андрей чөтгөрүүдэд,

- Эй, эрхэм чөтгөрүүд ээ! Хааны эцгийг хэдэн хором чөлөөлөөдхөөч, би ганц хоёр юм асууя гэж хэлэхэд чөтгөрүүд,

- Хүлээх зав алга! Энэ тэргэнд чинь өөрсдөө оролтой биш дээ! гэв.

Тэгэхэд нь Андрей,

- Оронд нь энэ шинэ хүнийг ав гэлээ.

Тэгтэл чөтгөрүүд хөгшин хааныг тэргэнээс суллан оронд нь хааны

зөвлөхийг хөллөөд хоёр талаас нь  
бороохойгоор гүядан хөөж одов.

Андрей харваач хөгшин хаанаас энэ  
тивд яажшуухан амьдарч байгааг нь  
асуухад хаан,

- Өө мүү мүү, энэ тивд тун мүү  
амьдарч байна! Хүүд минь мэхийн  
мэндлээд «Хүн битгий гомдоож  
яваарай» гэж намайг захиж байна  
гэдгийг сайн хэлээрэй. Эсвээс энэ  
тивд бас л над шиг зовно.

Хөгшин хаан дөнгөж ингэж хэлээд  
байтал чөтгөрүүд хоосон тэрэгтэйгээ  
буцаад ирэв. Андрей хөгшин  
хаантай салах ёс хийгээд

чөтгөрүүдээс хааны зөвлөхийг аван буцах замдаа оржээ.

Тэгээд улс орондоо буцаж ирээд хааны ордонд оров. Хаан харваачийг хармагцаа уурлан,

- Чи буцаж ирдэг ясан зүрхтэй хүн бэ? гэхэд Андрей,

- Би диваажинд очоод ирлээ. «Хүн битгий гомдоож байгаарай» гэж танд тун сайн захиарай гэж эцэг чинь хэлсэн дээ. Тэр тивд таны эцэг их л мүү амьдарч байна гэнээ.

- Тэр тивд очиж, миний эцэгтэй уулзсанаа чи юугаар нотлох юм бэ?

- Таны зөвлөхийн нуруун дээр чөтгөрүүд бороохойдсон ор мөр одоо болтол хэвээрээ байгаа шүү. Ингээд хаан итгэхээс өөр аргагүй болж Андрейг гэр лүү нь явуулжээ. Харин зөвлөхдөө дахин,

- Харваачийг тонилгох арга бод! Бодохгүй бол миний сэлэм гялс чиний толгой бөндгөс! гэж зарлигджээ. Хааны зөвлөх бүр ч шаналан толгой гудайлган явсаар нэгэн дарсны газар орон дарс авчир гэж хашгирчээ. Гэтэл ноорхой нэгэн эр гүйн ирж,

- Хааны зөвлөх юундаа гунигтай байна вэ? Надад нэг аяга дарс

аягалчих би арга ухаан заагаад өгье гэж гэнэ. Хааны зөвлөх түүнд нэг аяга дарс өгөөд юу болсныг цөмийг ярьжээ.

- За сонсож бай. Миний хэлэх энэ зүйлийг хүн хийж гүйцэтгэх нь бүү хэл, бодож олоход амаргүй юм. Чи хаандаа очоод Андрейг зуун үүлын цаанатаа зургаан үлсын тэртээ байдаг нойрсуулагч муурыг авчруулахаар явуул гэж хэл гэжээ.

Хааны зөвлөх хаандаа гүйн ирж Андрейг тонилгох уран арга олсноо ярив. Энэ санал хаанд их л таашаагдаж тэр дороо л Андрейг дуудуулав.

- За Андрей, ахиад нэг албандаа үнэнчээр зүтгэх хэрэгтэй байна даа. Зүүн үулын цаанатаа зургаан улсын тэртээ байгаа нойрсуулагч муурыг авчир. Хэрвээ авчрахгүй бол миний сэлэм гялс чиний толгой бөндгөс гэж мэдээрэй... гэв.

Андрей шаналж зовсоор гэртээ ирээд хааны алба хатуу ялын тухай эхнэртээ нэгд нэггүй ярьжээ. Марья гүнж нөхрийнхөө яриаг сонсоод,

- Үүнд юунд нь шаналах вэ! Үүнээс хэцүү алба ирнэ. Оройноос өглөө сэргэлэн гэдэг дээ, одоо унт гэлээ. Ингээд Андрейг унтахаар хэвтмэгц Марья гүнж төмрийн дарханд очиж

гурван төмөр малгай, төмөр бахь,  
төмөр, зэс, тугалган саваа гурвыг  
хийлгэжээ.

Маргааш өглөө нь Марья гүнж  
Андрейг эрт сэрээж төмөр бахь,  
гурван малгай, гурван саваагаа  
өгөөд алсын замд үдэхдээ,

- Гурван мод хэртэй газраас л  
нойрсуулагч муур чиний нойрыг  
хүргэх байх. Чи унтаж болохгүй шүү.  
Гараа хая, хөлөө хөдөлгө, аргаа  
барлаа гэхэд өнхрөөд ч болсон  
урагшил. Унтах л юм бол  
нойрсуулагч муур чамайг ална гээд  
Марья гүнж Андрейд тохиолдох  
бэрхшээлийг тоочин хэлж тэр

бүгдийг яаж давж туулах арга замыг зааж өглөө гэнэ.

Ингээд Андрей намхан газрыг нарлан өндөр газрыг өвөрлөсөөр явж зуун уулын цаанатаах зургаан улсын тэртээх харийн газрын барааг харж гэнэ. Ингээд гуравхан мод газар үлдээд байтал Андрейн нойр хүрээд болдоггүй гэнэ. Андрей гурван төмөр малгайгаа өмсөөд ямар ч байсан унтахгүй юмсан гээд гараа дааж ядан хаясаар хөлөө зөөж ядан гишгэлсээр өнхрөх газар нь өнхөрсөөр урагшаа яваад л байж. Ингэсээр өндөр баганын дэргэд тулж иржээ. Баганын сфойд шогнийн сууж байсан нойрсуулагч муур Андрейг

хараад шүд амаа ярзайн архирч байснаа гэнэт үсрэн толгойд нь наалдан нэг малгайг нь хагалав, хоёр дахь малгайг нь хагалав, тэгээд гурав дахь малгайг нь хагалахаар завдахад Андрей төмөр бахиараа хавчин авч газар савж унагаад төмөр саваагаараа балбаж гэнэ. Тэгсэн төмөр саваа нь хугарч гэнэ. Зэс савааныхаа амтыг үзүүлж, зэс саваа нь бас хугарч гэнэ. Тэгэхээр нь тугалган саваагаа гаргаад нүдэж гэнэ.

Тугалган саваа тахилзан нахилзахаас тасран хугарсангүй. Андрей балбаад байсан чинь нойрсуулагч мүур лам хувраг, чөтгөр шулам, охид

хүүхнүүдийн тухай янз бүрийн сонин хачин үлгэр ярьж эхлэв гэнэ. Андрей үлгэрийг нь сонсолгүй балбаад л байж. Нойрсуулагч муур эцэст нь ярьж чадахаа байгаад харваачаас өршөөл гүйжээ.

- Сайн санаат хүн минь, намайг жанчиж балбахаа болиоч! Юу хүссэнийг чинь хийж өгнө.
- Надтай цуг явах уу?
- Хаашаа л гэнэ, тийшээ явна.

Ингээд Андрей буцах замдаа оржээ. Улс орондоо ирээд муураа дагуулсаар хааны ордонд очив.

- Таны зарлигийг биелүүлж нойрсуулагч муурыг авчирлаа гэхэд хаан ихэд гайхан,
- За тэгвэл нойрсуулагч муур, ид шидээ үзүүл! гэлээ. Нойрсуулагч муур хумсаа сарвалзуулан хаан руу дав шилж хааны тарган цагаан хэнхдэгийг нь ярж амьд улаан зүрхийг нь суга татахыг завдав. Хаан айн сандарч,
- Андрей, энэ муураа түргэхэн зайлуул! гэлээ. Андрей муураа төмөр төрөнд хийж түгжээд өөрөө Марья гүнждээ очихоор гэрийн зүг явжээ. Тэгээд мэргэн харваач үхаант Марья гүнжтэйгээ амар сайхан

амьдарч байтал хаан эзний хорсол занал туйлдаа хүрч нэг удаа зөвлөхөө дуудан,

- Андрей харваачийг алж үстгах арга заавал ол, эсвээс миний сэлэм гялс чиний толгой бөндгөс! гэж гэнэ. Хааны зөвлөх сурсан зангаараа дарсны газар шууд явж очвол нөгөө ноорхой хувцастай эр тэнд сууж байна гэнэ. Түүнд хуучны адил учир зовлонгоо тоочин арга тус зааж өгөхийг гүйв. Ноорхой эр аяга дарсыг нь залгилчихаад аравгар сахлаа арччихаад,

- Хаандаа очиж Андрей харваачийг эс мэдэх зүгт зорчоод үл мэдэх юмыг

олж ир гэж явуул. Энэ албыг Андрей энэ насандаа биелүүлэхгүй эсэн мэнд ч эргэж ирэхгүй гэж гэнэ.

Хааны зөвлөх ордондоо гүйн ирж хаандаа арга ухаан олсноо хэлбэл хаан тэр дорхноо Андрейг дуудуулж,

- За Андрей, хааны албыг чи хоёр удаа үнэнчээр гүйцэлдүүлсэн. Одоо нэг алба байна. Чи эс мэдэх зүгт зорчоод үл мэдэх юмыг олж ир. Энэ албыг гүйцэтгэвэл хааны шагнал хүртэнэ, эсвээс миний сэлэм гялс чиний толгой бөндгөс! гэв.

Андрей гэртээ ирээд үйлахад Марья гүнж,

- Хонгор минь, юундаа шаналаа вэ?  
Гай зовлон тохиолдов үү? гэж  
асуухад Андрей хэлэв.
- Үзэсгэлэн гоо төржээ чи, үйл лайгий  
нь эдэлж байна би! Хаан эзэн  
намайг эс мэдэх зүгт зорчоод үл  
мэдэх юмыг авчир гэлээ.
- Энэ ч ёстой алба байна! За яахав,  
чи одоо унт. Оройноос өглөө  
сэргэлэн гэдэг дээ гэв.

Марья гүнж шөнө болмогц шидэт  
номоо дэлгэн удтал үншсан боловч  
хааны албыг хэрхэн гүйцэлдүүлэх  
тухайд юу ч олдсонгүй урам нь  
хугаран толгойгоо салаавчлан

бодлогошрон суув. Тэгээд довжоон дээрээ гарч зогсоод алчуураа гарган даллатал төрөл бүрийн шувуу, ан амьтад цугларан иржээ.

- Ойн эзэн амьтад минь, огторгуйг хөлөглөгч жигүүртнүүд минь, энд тэндгүй хэрэн сүлжиж элэн халин нисдэг та нар минь, эс мэдэх зүгт яаж зорчоод үл мэдэх юмыг яаж авчрах вэ? Мэдсэн сонссон юм байна уу, мэргэн сургаалаа хэлж туслаач! гэхэд амьтан шувууд,

- Огт мэдэхгүй, сонсоогүй юм байна гэлээ. Марья гүнж алчуураа дахин нэг даллахад хуран цугларсан амьтад, жигүүртэн шувууд

хоромхоноо алга болов. Марья гүнж дахин алчуураа даллахад хорвоод ховорхон хоёр аварга хүдэр эр өмнө нь ирж зогсоод,

- Танд юу хэрэгтэй болов? хэмээн асуулаа.

- Үнэнч зарц нар минь, намайг тэнгис далайн тэг дунд аваачиж өгөөч гэхэд хоёр аварга гүнжийг алган дээрээ өргөн тэнгис далайн дунд аваачиж өөрсдөө багана мэт зогсов гэнэ.

Марья гүнж алчуураа нэг даллахад далайн бүх амьтад хөвөн сэлэн ирэв гэнэ.

- Энд тэндгүй хөвөн сэлэгч эрэлчин суралчин та нар эс мэдэх зүгт яаж зорчоод үл мэдэх юмыг яаж авчирдаг тухай дуулж сонсоогүй биз? гэлээ.

- Бид огт сонсоогүй, мэдэхгүй юм байна! гэж хөвөн сэлэгч амьтад хэлэв.

Марья гүнж цөхрөнгөө бараад аварга эрчүүдэд өөрийгөө гэртээ аваачиж өгөхийг тушаав. Аварга хоёр эр Марья гүнжийг сэв хийтэл өргөн довжоон дээр нь тов хийтэл тавив

Марья гүнж өглөө эртээ гэгч Андрейг

сээрээн нэг бөөрөнхий утас, хээ углаз хатгаж оёсон алчуур хоёр өгөөд,

- Утас хаашаа бөмбөрнө, чи тийшээ дагаад яваарай. Хаана хэнийд ч очсон нүүр гарсаа угаагаад миний л алчуураар арчаарай. Хүний алчуур бүү аваарай гэж гэнэ. Тэгээд Андрей Марья гүнжтэйгээ салах ёс гүйцэтгээд дөрвөн зүгт наманчлаад алсын замдаа гарчээ. Бөөрөнхий утас урд нь бөмбөрсөөр Андрей араас нь дагаж алхсаар явав.

Ингээд явсаар явсаар, хөвсөн утас нь жижгэrsээр явсан зам нь уртассаар, нэг мэдэхнээ утас нь нүдэнд харагдахгүй шүдэнд хазагдахгүй

жижигхэн болсон байна гэнэ. Тэгтэл гүн шигүү ойд тулж иржээ, ойн дунд тахиан хөлт байшин байна гэнэ.

- Байшинхан байшинхан, ар ханаа ой руу ангайх хаалгаа над руу харуулаач! гэв.

Байшинхан ангайх хаалгаа Андрей руу харуулахад Андрей дотор нь ороод харвал вандан дээр буурал эмгэн сүугаад утас ээрч байв.

- Пөөх паах, оросын үнэр үнэрлээгүй олон жил болсон юмсан, одоо чинь өөрөө ороод ирдэг болж дээ. Халуун зуухандаа хийгээд шарж идье! гэх юм гэнэ. Тэгэхээр нь Андрей

харваач,

- Хөгшин эмгэн та замын хүнийг идэх гэж үү! Арьс яс болсон, аян замын хүнийг эхлээд үс цасанд оруулж болгож борлуул гэв.

Шулмас эмгэн халуун үсныхаа байшинг галлав. Андрей харваач усанд ороод эхнэрийнхээ өгсөн алчуураар нүүр гарсаа арчвал Шулмас эмгэн хараад,

- Энэ алчуур яагаад чамд байдаг билээ? Үүнийг чинь миний охин оёж хатгасан юм гэж асуув.

- Таны охин миний эхнэр шүү дээ.

Эхнэр минь надад энэ алчуурыг  
өгсөн дөө.

- Өө хүндэт хүргэн минь, би чамайг юугаар дайлах вэ? Ингээд Шулмас эмгэн хоол унд амтат дарс ширээ дүүрэн өрөв. Андрей ч нэрэлхэж зоволгүй идэж үүж сүүхад Шулмас эмгэн «Марья гүнж охинтой минь чи яаж гэрлэсэн, яаж амьдарч байна?» гээд олон юм асуун шалгаав. Андрей ч цөмийг яриад хаан эс мэдэх зүгт зорчоод үл мэдэх юм авчир гэсэн гээд,
- Та тусалбал сайн байна! гэв.
- Ай хүргэн минь, би ч ийм сонин

хачин юм сонсоогүй юм байна.  
Харин намагт гурван зуун жил  
амьдарч байгаа хөгшин мэлхий л  
энэ тухай мэдэж байгаа. За яхав, чи  
одоо унт, оройноос өглөө сэргэлэн  
гэдэг дээ! гэлээ.

Андрейг үнтахаар хэвтэхэд Шулмас  
эмгэн хоёр шүүр унаад нисэж  
намгийн дээр ирээд дуудав гэнэ.

- Мэлхийвауглий, та амьд мэнд үү?
- Мэндээ мэнд.
- Намгаасаа гараад ирээч.

Мэлхий эмгэн намгаасаа гарч

ирэхэд Шулмас эмгэн асуув.

- Үл мэдэх юм хаана байгааг мэдэх үү?
- Мэднээ.
- Тусалж хайлраач, хаана байгааг хэлээд өгөөч! Хүргэнд минь хүнд алба оноожээ! Эс мэдэх зүгт зорчоод үл мэдэх юмыг авчир! гэсэн гэнээ.
- Заагаад өгөхсөн. Даанч хөгшин болсон өвчтэй эмгэн би тэр хүртэл үсэрч дэвхэрч чадахгүй. Хүргэн чинь намайг бүлээн сүүн дотор суулгаад гол гол дээр хүргэж өгөг, тэгвэл би

хэлж өгнө.

Шулмас эмгэн Мэлхийвауглий эмгэнийг аваад гэртээ нисэн ирж саванд сүү саагаад сүүн дотроо мэлхийгээ суулгаад Андрейг өглөө эрт сэрээн,

- За хүндэт хүргэн минь, босож хувцасла. Бүлээн сүүтэй энэ савыг аваад яв, дотор нь мэлхий байгаа. Миний морийг үнаад гал гол хүр, тэнд очоод морио хаяад савнаасаа мэлхийгээ гаргаарай. Мэлхий чамд хаашаа явахыг зааж хэлж өгнө гэв.

Андрей босож хувцаслаад Шулмас эмгэний морийг унаж савтай сүүгээ

аван гал голыг зорин давхив гэнэ.  
Араатан амьтан алхан гаталж  
чаддаггүй, жигүүртэн шувуу нисэн  
давж болдоггүй гал голын дэргэд  
давхин ирэв гэнэ. Андрей  
мориноосоо буухад Мэлхий эмгэн,

- Намайг савнаас минь гаргаач, би  
чамайг гал гол дээгүүр гарахад  
тусалъя гэлээ.

Андрей савнаасаа Мэлхийвауглий  
эмгэнийг гарган газар тавихад,

- За сайн эр минь, миний нуруун  
дээр морд гэж гэнэ. Андрей,

- Эмээ минь, та юу ярина вэ! Ийм

жижигхэн таныг би бяц дарах биз ээ  
гэвэл,

- Бүг ай, бяц дарж чадахгүй ээ.  
Харин сайн бариад суу гэх юм гэнэ.

Тэгээд Андрей түүн дээр суухад  
Мэлхийвауглий эмгэн биеэ хийлэн  
үлээж хөөсөөр хөөсөөр бухал өвс шиг  
том болов.

- Сайн бариад сайн сууж байгаа биз?  
- Сайн сайн, би ойчихгүй.

Мэлхийвауглий дахин хөөж  
бөмбийсөөр нуруу өвс шиг том  
болов.

- Сайн бариад сууж байна уу,  
ойчихгүй биз?

- Сайн сайн, би ойчихгүй.

Мэлхийвауглий дахин биеэ хийлж үлээсээр өндөр үул шиг болоод тап хйтэл үсрэн гал голын цаана гараад дахиад бага болов гэнэ.

- За сайн эр минь, энэ жимээр ороод яв. Өмнө чинь цамхаг ч биш, байшин ч биш, амбаар ч биш нэг юм байгаа.

Чи тийшээ ороод пийшингийнх нь ард зогс. Тэндээс л үл мэдэх юмыг олно доо гэж зааж өгөв. Андрей жимээр орон явбал өмнө нь тагт

довжоогүй таглах цонхгүй намаг хөлмөгт хучигдсөн навтгар мүү байшин байна гэнэ. Андрей тэр байшинд ороод пийшингийнх нь ард зогсов.

Удалгүй ойгоор их чимээ гаран тохойн чинээ сахалтай хумсын чинээ биетэй эр орж ирээд тэнгэрт хадам чангаар,

- Хөөе Наум, хоол аваад ир! гэлээ.

Тэр эрийг ингэж хашгирмагц л торхтой пиво, бухын бүтэн жигнэсэн гулууз, хурц хутга тавьсан ширээ хаанаас ч юм бэ гараад ирэв. Тохойн чинээ сахалт хумсын чинээ биет

жигнэсэн бухын гулуузнаас хурц хутгаар огтлон амтат сармисанд дүрэн амтархан идэж сайшаан магтав гэнэ. Ингээд гулууз махаа идчихээд торхтой пиво уучихаад,

- Хөөе Наум, хог үлдэгдэл цэвэрлэ! гэж хашгирлаа. Гэнэт яс ч үгүй, торх ч үгүй болж ширээ алга болов.  
Андрей тохойн чинээ сахалт хумын чинээ биетийн явахыг хүлээж байгаад явмагц нь пийшингийн цаанаас гарч ирээд зоригтоо чангаж байгаад,

- Хөөе Наум, хоол аваад ир! гэлээ.

Тэгтэл хаанаас ч юм бэ, бүү мэд

амттан шимтэн арз дарс дүүрэн  
өрөөтэй ширээ бий болов гэнэ.  
Андрей ширээний ард сууж,

- Наум, надтай сууж хоол ид гэвэл үл үзэгдэх нэгэн дуу гарч,
- Сайн санаат хүн минь, танд гялайлаа! Хэчнээн олон жил би энд зүтгэж байна, талхны түлэнхий зах ч амсаж үзээгүй билээ. Харин чи намайг ширээнээ урилаа гэж хэлэх юм гэнэ.

Харагдах бие байхгүй мөртлөө уух идэх юм ширээнээс шүүрдэгдэх мэт алга болж арз дарс аяндаа л аягалагдан хундагалагдан байхад

Андрей гайхаж барахгүй суув.

- Хөөе Наум, чи гараад ирээч! гэж Андрейг гуйхад,
- Намайг хэн ч харж чадахгүй ээ, би хэн, юу гэдгээ өөрөө ч үл мэдэх билээ гэж хариулав гэнэ.
- Хөөе Наум, чи надад ач тус болооч!
- Бололгүй яах вэ! Чи сайн санаат хүн байна. За ингээд тэр хоёр хооллож ундалж дуусжээ.
- За юмаа хураа, надтай цуг явна шүү гэж Андрей хэлээд байшингаас гарч яваад эргэж харан,

- Хөөе Наум, чи явж байна уу? гэв.
- Явж байнаа, бүү ай, би хоцрохгүй. Тэгээд Андрей гал голын дэргэд очвол мэлхий эмгэн хүлээж байв.
- За сайн эр минь, үл мэдэх юмыг олов уу?
- Оллоо, оллоо.
- За над дээр морд.

Андрей дээр нь мордоход мэлхий эмгэн хийлэн хөөсөөр том болоод гал гол дээгүүр ганц үсрээд гарав гэнэ. Андрей мэлхий эмгэнд талархаад улс орноо зорин цааш

явав. Явж явж байгаад эргэж харан,

- Хөөе Наум, чи явж байна үү? гэхэд хариуд нь,

- Явж байнаа. Бүү ай, би хоцрохгүй гэх дуу гарав. Андрей явж явж алс холын замд ядран цуцаж гар нь унжиж хөл нь солбиж гэнэ.

- Ээх, би ямар их ядрав аа! гэвэл Наумын дуу гаран,

- Аль түрүүн надад хэлэхгүй ясан юм бэ? Би чамайг дор нь хүргээд өгөхгүй юу! гэж гэнэ.

Тэгтэл эрч хүчит салхи эргэлдэн

хүйлран Андрейг ороон авч нисэн хурдлахад доогуур нь үүл толгод, ой мод, хот тосгон жижигрэн жирэлзэн өнгөрнө гэнэ. Хөлгүй их тэнгисийн дээгүүр нисэж явахдаа Андрей айн цочирдож,

- Хөөе Наум, амрах юмсан! гэв.

Салхи намдан Андрей тэнгис дээр буухаар доошилж байв. Гэнэт харвал их долгион шүүгин байсан тэр газар жижигхэн арал бийолж, арал дээр алтан дээвэртэй ордон, ордны эргэн тойронд сайхан цэцэрлэг бий болов. Наум Андрейд,

- Ундалж хооллоод сайн амар,

харин тэнгис рүү хараарай.

Хажуугаар чинь худалдаачны гурван хөлөг онгоц хөвөн өнгөрнө. Чи хөлөгийн эзэн худалдаачдыг дуудаж дайлж зочил. Тэдэнд гурван сонин гайхамшиг бий. Чи намайг тэр гурваас айлгүй солиорой, бүү ай, би чамд эргээд ирнэ гэлээ.

Удсан ч үгүй өрнө зүгээс гурван хөлөг онгоц хөвөн гарч ирлээ. Хөлөг онгоцныхон тэнгисийн дундах арал, түүний дээрх алтан дээвэртэй ордон, ордныг тойрсон гайхамшигт цэцэрлэгийг хараад,

- Энэ чинь юун гайхамшиг вэ? Бид хэчинээн удаа үүгээр хөвлөө, хөх

уснаас өөр юм үзээгүйсэн. Алив очиж үзэцгэе! гэлцэв.

Гурван хөлөг зангуугаа хаян зогсоход гурван худалдаачин хөнгөн завинд суун арлын зүг сэлэн ирэв гэнэ.  
Андрей харваач тэднийг утган,

- Эрхэм зочид минь, тавтай морилогтун! гэж урилаа. Гурван худалдаачин нүд алдан гайхан харна. Ордны дээвэр нь алтан нар шиг гялалзана, олон өнгийн шувуу цэцэрлэгийн дотор дуулалдана, онцгой сонин хачин амьтад зам жимээр гүйлдэнэ гэнэ.

- Сайн сэтгэлт хүн минь, энэ

гайхамшигийг хэн босгосон бэ? гэж  
тэднийг асуухад Андрей,

- Миний зарц Наум нэг шөнийн  
дотор барьж босгосон гэв.

Тэгээд Андрей зочдоо ордондоо  
урин залж дайлж зочлов.

- Хөөе Наум, биднийг хооллооч!

Амттан шимтэн арз дарсаар дүүрэн  
ширээ өмнө нь нүд ирмэхийн зуур  
бий болно. Худалдаачид уулга  
алдан,

- Сайн сэтгэлт хүн минь, чи бидэнд  
энэ зарц Наумаа өгөөч, оронд нь юу

дуртайгаа аваач гэцгээлээ.

- Солиход ч болж байна. Харин та нарт дур татах юу байгаа юм бэ?

Нэг худалдаачин өврөөсөө бороохой гаргаж ирээд энэ бороохойд «Алив бороохой минь, энэ хүнд амтаа нэг үзүүлээдхээч!» гэж хэлэхэд л бороохой өөрөө балбан нүдэж ямар ч хүнийг болгоод өгнө, хашраагаад өгнө гэв. Хоёр дахь худалдаачин хормой дороосоо нэг сүх гаргаж ирээд ирийг нь доош харуулбал сүх өөрөө тас тас цавчин яах ийхийн зуургүй нэг хөлөг онгоц, хоёр хөлөг онгоц хийгээд тавчихав гэнэ. Хөлөг онгоцнууд тэнгист хөвж

их буугаар буудан эрэлхэг усан  
цэргүүд зарлиг тушаал хүлээн  
зогсоно.

Худалдаачин сүхнийхээ ирийг дээш  
харуулбал хөлөг онгоцнууд  
байгаагүй юм шиг л алга болов гэнэ.  
Гурав дахь худалдаачин  
халааснаасаа цоор хөгжим гаргаж  
ирээд үлээтэл морьтой явган олон  
цэрэг их бүү, зэр зэвсэгтэйгээ бий  
болов гэнэ. Их цэрэг жагсан жигдрэн  
алхаад хөгжим хангинаж түг залаа  
намиран, морьтой жанжнууд  
дүүхэлзэн зарлиг тушаал хүлээнэ  
гэнэ. Худалдаачин цоорынхoo нөгөө  
үзүүрээс үлээвэл их цэрэг гэнэт алга  
болов гэнэ. Андрей харваач,

- За та нарын ид шид дур татах сайн л юм байна, гэхдээ минийх илүү үнэ цэнэтэй дээ. Хэрвээ миний зарц Наумыг авъя гэвэл энэ гурваа гурвуулангий нь л өгч байж ав даа гэв.

- Ганцын оронд гурав гэдэг арай их биш үү?
- За тэгвэл солихгүй ээ.

Худалдаачид бодож бодож «Бороохой, сүх, цоор гурваар бид яах юм бэ! Наум зарцтай болбол санаа зовох юмгүй өдөр шөнөгүй хоол үндаар цатгалан өглөө үдэшгүй арз дарсаар цутгалан суух болно»

гэж шийджээ. Худалдаачид Андрей харваачид бороохой, сүх, цоор гурваа өгөөд,

- Хөөе Наум, бид чамайг авлаа шүү! Чи бидний үнэнч зарц болж чадах үү? гэж хашгиран асуухад үл үзэгдэх дүү,

- Чадалгүй яах вэ! Хаана ч амьдрахгүй юм чинь надад ялгаа юу байх вэ! гэв.

Худалдаачид хөлөг онгоц руугаа эргэн очоод найрлан суув.

- Хөөе Наум, тэрийг аваад ир! Хөөе Наум, энийг аваад ир! гэж хашгиран

идэж идэж ууж ууж согтоод сүусан газраасаа босож чадалгүй өнхрөн үнацгаав.

Андрей харваач ордондоо «Хөөрхий миний зарц Наум одоо хаана байгаа бол доо?» гэж гүнихран суутал гэнэт хажууханд нь,

- Би энд байна. Юу хэрэгтэй вэ? гэж гэнэ. Андрей баярлан,

- Хөөе Наум минь, одоо хоёулаа төрөлх нутаг руугаа буцах цаг болсон биш үү? Залуу эхнэр минь хүлээж сүугаа. Намайг гэрт минь хүргээд өгөөч гэв.

Хүй салхи хүйлран дэгдэж Андрейг шүүрэн авч төрөлх нутгийнх нь зүг давхив.

Нөгөө худалдаачид сэргэгцээ л шараа тайлах гээд,

- Хөөе Наум, хоол үнд авчир, хурдал хурдал! гэж хашгирав.

Хэчинээн хашгирч, хэчинээн дуудлаа ч юу ч байдаггүй. Өндийн босож харваас өнөөх арал ч байдаггүй. Хөх ус хөөсрөн шуугихаас өөр юм харагдсангүй. Худалдаачид «Эх, мүү санаат хүн биднийг хуурчээ!» гэж гаслан халаглаад, яах ч аргагүй болсон тул дарвуул далбаагаа өргөн

зорьсон газрыг чиглэн хөвөн одов. Андрей харваач төрөлх нутагтаа ирээд гэрийнхээ гадаа буувал байшингийнх нь оронд шатаж харласан хар яндан гозойж байв.

Андрей толгой гудайлган шаналан гунигласаар хотоос гарч хөх тэнгисийн эрэг дээр хүн амьтангүй газар ирээд сууж байв. Гэнэт хаанаас ч юм бэ, нэг бор хүүрзгэнэ нисэн ирж газар мөргөөд Марья гүнж болон хувирав гэнэ. Андрей эхнэрээ тэврэн авч хоёул баярлан үулзвав.

- Чамайг явснаас хойш би бор хүүрзгэнэ болон ой шугуй дээгүүр нисэн амьдарч байна. Хаан намайг

авах гэж гурван удаа элч илгээгээд намайг олоогүйдээ уурлан хилэгнэж орон гэрийг маань шатаасан гэж Марья гүнж ярив.

Тэгэхэд Андрей,

- Хөөе Наум, хөхрөх тэнгисийн эрэг дээрх хүн амьтангүй энэ газар ордон цамхаг босгож болох ўу? гэхэд Наум,

- Бололгүй яах вэ! Одоохон! гээд нүд ирмэхийн зуур хааны ордноос гоёмсог сайхан ордон бий болгов гэнэ. Үзэсгэлэнт ногоон цэцэрлэгт нь өнгө өнгийн шувууд дуулна гэнэ. Зам жимээр нь янз янзын сонин хачин амьтад үсрэн дэгдэнэ гэнэ.

Андрей харваач Марья гүнж хоёр ордондоо орон цонхныхoo дэргэд суугаад бие биеэ хайрлан хайрлан ширтэж, элэг зүрхнийхээ үгийг дэлгэн дэлгэн ярилцана. Ийм сайхан эв найртайгаар амьдран гай зовлонг үзэлгүй өдөр хоногийг өнгөрөөж байв.

Гэтэл тэр үед ан авлаж явсан хаан урьд нь хоосон байсан газар үзэсгэлэнт ордон байхыг хараад,

- Хэн миний нутаг дээр ингэж өөрийн дураар ордон цамхаг босгоо вэ? гээд хүн явуулав.

Явсан хүмүүс Андрей харваач энэ

ордныг босгоод залуу эхнэр Марья  
гүнжтэйгээ амьдран суудаг юм  
байна гэсэн мэдээг хаандаа авчрав.

Хаан бүүр их уурлан хилэгнэж  
Андрей эс мэдэх зүгт зорчоод үл  
мэдэх юмыг олж ирж үү, үгүй юу?  
мэдээд ир гэж элчээ дахин илгээв.

Элч нар давхин ирж дахин тагнаад  
хаандаа илтгэв гэнэ.

- Андрей харваач эс мэдэх зүгт  
зорчоод үл мэдэх юмыг авчирсан  
гэнэ!

Тэгэхэд хаан урьд урьдынхаасаа  
улам их хилэгнэн их цэргээ босгон

хөх тэнгисийн эрэг дээрх энэ ордон руу дайран довтолж эзэгнэн аваад Андрей харваач Марья гүнж хоёрыг аймшигт үхлийн аманд өг! гэж зарлигдав. Хааны их цэрэг ордон руу нь ирж явахыг харсан Андрей харваач сүхээ шүүрэн авч ирийг нь доош харуулав. Сүх нь тас тас цавчин нэг хөлөг онгоц хийн тэнгист тавив, дахин тас тас цавчин ахиад нэг хөлөг онгоц хийж тавьсаар зуун хөлгийг дор нь хийж хөх тэнгист тавилаа гэнэ. Андрей цоор хөгжмөө гарган үлээвэл морьтой явган олон цэрэг их буюу, зэр зэвсэгтэйгээ жигдрэн жагсан бий болов гэнэ.

Морьтой жанжнууд тушаал зарлиг

хүлээн дүүхэлзэнэ.

Андрей дайн тулалдаанаа эхлэхийг тушаав. Хөгжим хангинан, бөмбөр нийгнэн, их цэрэг хороо хороогоороо урагшлав. Явган цэргүүд хааны цэргүүдийг хиар цохив, морин цэргүүд хааж бүслэн баривчлан авна. Зүүн хөлөг онгоц их буугаар галлан төв хотыг бөмбөгдөнө. Цэргүүд нь буцаж зугтахыг харсан хаан өөрөө давхин ирж цэргүүдээ зогсооход Андрей бороохойгоо гаргаж ирээд,

- Бороохой минь, энэ хааныг болгоод өгөөч, хашраагаад өгөөч! ГЭВ.

Бороохой цахилан эргэлдэн хааны өөдөөс очин духан дундуур нь тасхийтэл цохиход хааны амь писхийтэл гарав гэнэ.

Дайн тулалдаан ч дуусав. Хотоос ард олон гүйн ирж Андрей харваачийг улс орны эзэн болж биднийг удирдан залаач гэж гүйв.

Андрей ч зөрж маргасангүй. Дэвэн дэлхийг донсолгосон их найр хийж гэнэ. Марья гүнжийнхээ хамт улс орноо залан урт насыг насалж удаан сайхан жаргасан гэнэ лээ.

## ХҮНГАЛУУ

Эхнэр нөхөр хоёр нэг охинтой бас нэг жижигхээн хүүтэй юмсанжээ.

- Охин минь, дүүгээ харж бай. Ээж аав хоёр нь ажилдаа явлаа, эргэж ирэхдээ чамд алчуур авчирч өгнө. Харин чи хашаанаасаа битгий гараарай, дүүтэйгээ тоглоорой гэж ээж нь хэлэв.

Ингээд аав ээж хоёр нь ажилдаа явчихаж, охин ээжийнхээ хэлснийг мартчихаад дүүгээ цонхныхоо доор өвсөн дээр суулгаж орхиод өөрөө гадаа гудамжинд гаран тоглож эрхэлсээр өнжжээ.

Энэ үед олон хунгалуу нисэн ирж дүүгий нь шүүрч аваад далавчин дээрээ суулган нисэн одов. Охин эргээд ирсэн чинь дүү нь алга байв. Айж сандран, ийш тийш харайн эрсэн чинь хаана ч байдаггүй гэнэ! Охин дүүгээ дуудан, аав ээжий хоёр загнана гэж айлгасан ч, асгартал үйлан эрсэн ч дүү нь байдаггүй гэнээ. Охин цэлгэр талд гарч харвал алсад хар ойн цаагуур хунгалуу шувуудын далавч гялалзаад л алга болж гэнэ. Хайртай дүүгий нь хунгалуу аваад явсныг охин таамаглав. Хунгалуу жаахан хүүхэд хулгайлдаг гэсэн мүү яриа аль эртнээс дуулдсан билээ.

Охин араас нь хөөн гүйв. Гүйж явтал нэг пийшин дайралджээ.

- Пийшин минь, хунгалуу шувууд хаашаа ниссэнийг хараагүй биз?  
Пийшин,
- Хар гурилан боовноос минь идвэл хэлж өгнө гэв.
- Хар гурилан боов би идэхгүй ээ!  
Гэртээ би цагаан гурилаар хийснийг ч иддэггүй юм...

Пийшин юу ч хэлсэнгүй. Охин цаашаа гүйж явсан чинь алимын мод дайралдав гэнэ.

- Алимын мод минь, хунгалуу хаашаа нисээд явчихав? гэж асуув.
- Ойн алимнаас минь амсаач, тэгвэл хэлж өгнө.
- Гэртээ би усалж тордсон цэцэрлэгийн улаан алим тоодоггүй...

Алимын мод юу ч хэлсэнгүй. Охин цааш гүйж явсан чинь жимсэн эрэгтэй сүүн гол урсаж байна гэнэ.

- Жимсэн эрэг сүүн гол минь, хунгалуу хаашаа нисээд явчихав?
- Сүүнээс миньүү, жимснээс минь ид, тэгвэл хэлж өгнө.

- Гэртээ би амттай цөцгий ч  
уудаггүй...

Ингээд охин өргөн аглагийн дээгүүр  
өтгөн ойн дундуур их л удаан  
гүйжээ. Нар жаргах гэж байдаг, одоо  
яах вэ, ганцаараа яаж буцах вэ!  
Гэтэл өмнөхөн нь сох ганц цонхтой  
таксиан хөлт байшин эргэлдэн  
эргэлдэн байх нь харагдав гэнэ.

Байшинд Шулмас эмгэн утас ээрэн,  
хөөрхөн дүү нь вандан дээр суугаад  
мөнгөн алимаар тоглож байв. Охин  
байшинд орлоо.

- Сайн байна уу?

- Сайн байна уу, охин минь!  
Зориглон ирсний учир юу вэ?

- Хөвд хаг дундуур хөвөлзөх намаг дээгүүр гүйсээр хамаг хувцсаа норгочихлоо, хатааж сэrvээхээр ирлээ.
- Аа тэгвэл май, хувцсаа хаттал утас ээрч бай. Ингэж хэлээд Шулмас эмгэн ээрүүлээ өгчихөөд гараад явчихав. Охин утас ээрч байтал гэнэт пийшин доороос нэг хулгана гарч ирээд,
- Охин минь, чанасан будаа надад өгөөч, чамд хэрэгтэй үгийг хэлж өгнө шүү гэж гэнэ.

Охин хулганад будаа өгөхөд хулгана хэлэв.

- Шулмас эмгэн халуун усныхаа байшинг галлахаар явсан. Чамайг угааж цэвэрлээд улаан галд шарж идчихээд чиний ясан дээр гулгаж тоглоно.

Охин ухаан гартлаа айж үйлан гашуудаход хулгана дахин,

- Дүүгээ аваад одоохон зугт, би чиний оронд утас ээрч байя гэж гэнэ.

Охин дүүгээ аваад зугтан гүйв.  
Шулмас эмгэн цонхныхоо гадаа ирээд л,

- Охион, чи ээрч байна уу? гэж асуухад,
  - Ээрч байнаа, ээрч байна гэж хулгана хариулаад байжээ.
- Шулмас эмгэн усаа халаачихаад охиньг авахаар орж ирвэл гэрт нь хэн ч алга байв. Шулмас эмгэн хашиграв.
- Хунгалууд аа, хурдлан хөөгөөрэй! Эгч нь дүүгээ аваад явчихлаа!..
- Эгч дүү хоёр сүүн гол дээр гүйж иртэл араас нь хунгалуу шувууд хүйлран нисэн хөөж яваа харагдав.

- Гол эх минь, бид хоёрыг нуугдуулаад өгөөч!

- Энгийн жимснээс минь идэж үз!

Охин жимснээс нь идээд жигтэй их баярлалаа гэж хэллээ. Гол жимст эргийнхээ доор эгч дүү хоёрыг нуув. Хунгалуу шувууд харсангүй хажуугаар нь нисээд нисээд өнгөрчихлөө.

Эгч дүү хоёр дахиад л цаашаа гүйж явав. Хунгалуу шувууд эргэж нисэн эгч дүү хоёрыг харахаа шахав. Одоо яанаа? Аюул аюул! Алимын мод харагдав.

- Алимын мод минь, биднийг  
далдах нуугаад өгөөч!

- Ойн алимнаас минь ид дээ!

Охин ойн алимнаас идээд онцгой их  
баярлалаа гэж хэллээ. Алимын мод  
тэднийг мөчрөөрөө бүрхэж,  
навчаараа хучив. Хунгалуу шувууд  
харсангүй хажуугаар нь нисээд  
нисээд өнгөрчээ.

Эгч дүү хоёр дахиад л цаашаа гүйж  
явав. Одоо ч гэр нь ойрхон болжээ.  
Гэтэл хунгалууд тэднийг олоод  
харчихав, олон талаас нэгэн зэрэг  
шунган нисэж, гүр гүр дуугаран  
далавчаа сэр сэр сэвэн дайрч дүүгий

нь охины гараас булааж авахыг шахлаа. Охин пийшингийн дэргэд гүйж ирээд,

- Пийшин минь, эгч дүү хоёрыг халхалж нуугаад өгөөч!
- Хар гурилан боовноос минь ид.

Охин боовноос авч амандаа хийгээд дүүтэйгээ цуг пийшингийн аманд орж нуугдан суув. Хунгалуу шувууд гүр гүр дуугаран далавчаа сэр сэр сэвэн эргэлдэн эргэлдэн ниссэн ч эгч дүү хоёрыг олсонгүй, эмгэн Шулмастaa хоосон буцжээ.

Охин пийшинд баярлалаа гялайлаа

гээд дүүтэйгээ цуг гэртээ гүйн ирэв.

Тэгтэл ч эцэг эх хоёр нь эргээд ирж  
гэнээ.

# ШИДЭТ МӨНГӨН ТАВАГ ШИМТ УЛААН АЛИМ

Эмгэн өвгөн хоёр гурван охинтой юмсанжээ. Хоёр том охин нь эрх танхи, гоёж гоодох дуртай гэнэ, харин бага охин Маша даруу төлөв зантай гэнэ. Хоёр том охин өнгийн бошинз өмсдөг, өндөр өсгий гишгэдэг, шармал сондор зүүдэг, сайхан бүхнийг нэхдэг гэнэ. Харин Машагийн өмссөн бошинз даруухан ч өглөөн нар шиг нүдтэй гэнэ, өдрийн гэгээ шиг жавхаатай гэнэ, газар хүрсэн гэзэгтэй гэнэ, ганхах цэцэгсэд шүргэдэг гэнэ. Хоёр эгч хойрго залхуу, хоосон цагаан гартай

гэнэ. Бага жаахан Маша үүрийн түяанаас үдшийн бүрий болтол гэрт гадаах бүхий л ажлаа амжуулж, төмсөө усалж, тахиа нугасаа тэжээж, үнээ малаа сааж өдрийн турш ажилладаг гэнэ. Ээж аавынхаа хэлсэн бүхнийг хийдэг гэнэ, сөрсөн үг хэлдэггүй гэнэ. Хоёр эгч нь Машагаар хамаг ажлаа хийлгэж, хавчин шахан гадуурхдаг гэнэ. Маша дув дуугүй л байдаг аж. Нэг удаа эцэг нь зээлийн газар явах болж, охидоосоо «Та нарт ямар бэлэг авчрах вэ?» гэж асуужээ. Том охин нь,

- Бошинз хийх торго авчраарай гэхэд хоёр дахь охин нь, улаан хамба

ХИЛЭН ЗАХИВ ГЭНЭ.

Маша дуугүй зогсож байтал эцэг нь  
өрөвдөн,

- Машенька, чамд юу авчрах вэ? гэв.

- Хүндэт эцэг минь, надад шимт  
улаан алим шидэт мөнгөн таваг  
авчирч өгөөрэй гэлээ.

Хоёр эгч нь хөхрөн шоолж,

- Эх Маша Маша, ийм тэнэг амьтан  
даа! Гадаа хаяанд алим ургаж  
байна. Хэдийг л бол хэдийг ав, бас  
тавгаар яах нь вэ! Нугас тэжээх гээ  
юу? гэцгээхэд Маша,

- Үгүй ээ, эгч нар минь! Алимаа би тавган дээгүүрээ өнхрүүлэн ариун нандин хүслээ шивгэнэн хэлнэ. Нэг эмгэн надад зааж өгсөн юм. Би тэр эмгэнд талархан бөөрөнхий талх бэлэглэсэн.

- За за, та нар дүүгээ шоолохoo тат! Хүн бүхэнд хүссэн бэлгийг нь авчирч өгнөө гээд эцэг нь явж зах зээлийн газар очоод өвсөө заран бэлэг авчээ. Нэг охиндоо цэнхэр торго, нөгөө охиндоо улаан хамба хилэн, Машад шидэт мөнгөн таваг шимт улаан алим авчирлаа гэнэ. Хоёр эгч баярлан бошинз хувцас оёно, басхүү Машаг шоолон хөхөрнө.

Маша нэгэн буланд суугаад шидэт мөнгөн таваг дээгүүрээ шимт улаан алимаа өнхрүүлэн,

- Шимт улаан алим минь, шидэт мөнгөн таваг дээгүүр өнхөр өнхөр. Төрөлх Орос нутгийг минь үүл тал, хот тосгон, тэнгис далай, тэнгэр газартай нь үзүүлээч! гэж хэлэв.

Гэнэт мөнгөн таваг хангинах чимээ гарснаа өрөө дүүрэн гэрэлтэй болж шимт улаан алим ч таваг дээгүүр өнхөн эргэлдэж таваг дээр хот тосгон, үүл нуга, хөндий тал, тэнгис далай, тэнгэр газрын үзэсгэлэн гоо

харагдаж гэрэлт нар гэгээн сарны араас бөмбөрөн, од мичид тойрон бүжигтээ бэлдэн, хүн шувуу нуур үсандaa дуулан чуулах нь үзэгдэв гэнэ.

Хоёр эгч нүд салгалгүй ширтэн хоршар нь хөдлөн Машад атаархана. Тэгээд Машагаас мөнгөн таваг улаан алимыг нь яаж авах вэ? гэж бодож сэтгэх болов. Маша юугаар ч солихгүй, юунаас ч өгөхгүй, харин орой болгон тавгаа үзэж цэнгэнэ гэнэ.

Тэгэхэд хоёр эгч Машаг ой руу явъя гэжээ.

- Хонгорхон дүү минь, жимсэнд явъя, аав ээж хоёртоо амттай шүүстэйхнээс түүж ирье.

Тэгээд гурвуулаа ойд явсан чинь ямар ч жимс гүзээлзгэнэ олдсонгүй.

Маша тавгаа гарган алимаа дээгүүр нь өнхрүүлэн,

- Шимт улаан алим минь, шидэт мөнгөн таваг дээгүүр өнхөр өнхөр, номинхон навч, ногоохон гүзээлзгэнэ хаана байгааг үзүүлээч гэлээ.

Гэнэт мөнгөн таваг хангинаан шимт улаан алим шидэт мөнгөн таваг

дээгүүр өнхрөн өнхрөн, таваг дээр ойг бүхэлд нь үзүүлэв. Номинхон навч, ногоохон гүзээлзгэнэ, нүүгдсан мөөг, нүүгисан булаг, нүүр үс хун шувууг харуулав. Үүнийг үзсэн хоёр эгчийнх нь атаа хорсол арвалзан буцалж хуурай гишүү шүүрэн авч буурай даруухан Машаг цохиж алаад хус модны ёроолд бүлж орхиод алим таваг хоёрыг нь авчээ. Тэгээд гэртээ орой болсон хойно сагс дүүрэн мөөгтэй эргэж ирээд,

- Машенька бид хоёроос салаад зугтаагаад гүйсэн. Бид хоёр ой modoор эрж эрж олсонгүй ирлээ. Чононд бариүлчихсан юм болов уу! гэж хэлжээ.

Эх нь уйлан гашуудаж, эцэг нь,

- Улаан алимыг мөнгөн таваг дээгүүр өнхрүүл, Машенька хаана байгааг үзүүлээд өгч магадгүй гэв. Хоёр эгч ухаанаа гартал айв, гэхдээ эцгийнхээ үгнээс зөрчиж чадсангүй. Тэгээд улаан алимыг мөнгөн таваг дээгүүр өнхрүүлэх гэтэл шидэт мөнгөн таваг хангинан дуугарсангүй, шимт улаан алим ч бөмбөрөн өнхөрс өнгүй, ой мод, үул нүрүү, тэнгис далай, тэнгэр газрыг үзүүлсэнгүй гэнэ.

Тэр үед нэг малчин хонио эрж яваад цав цагаан хүс модны ёроолд жижигхэн овгор, овгорыг тойроод номин ногоон цэцэг дэлгэрэн ургаж

байхыг үзжээ. Цэцэгсийн дунд зэгс ургаж байв. Малчин зэгснээс огтолж аваад бишгүүр хийн үлээх гээд ам руугаа дөнгөж ойртуултал бишгүүр өөрөө дуугаран тоглож,

- Зэгсэн бишгүүр, дуул дуул, залуухан малчныг баясга баясга. Улаахан алим мөнгөн тавагны төлөө залуухан миний амь насыг хороосон доо, хороосон... гэв. Малчин айн тосгонд гүйн очиж хүмүүст энэ тухайгаа ярьжээ. Хүмүүс үулга алдан, яанаа ийнээ болов. Машагийн эцэг ч гүйж ирэн бишгүүрийг гартаа авмагц бишгүүр бас л өөрөө дуугаран,
- Зэгсэн бишгүүр, дуул дуул,

төрүүлсэн аавыг минь баясга баясга. Улаахан алым мөнгөн тавагны төлөө залуухан минийамь насыг хороосон доо, хороосон гэлээ. Эцэг уйлан хоньчноос «Зэгс огтолж авсан газраа зааж өгөөч!» гэж гүйв.

Малчин нөгөө жижигхэн овгорынхoo дэргэд тэднийг авчрав. Хус модны ёроолоор номин ногоон цэцэг дэлгэрэн, модны мөчир дээр хөх бух шувуу дуулан жиргэнэ гэнэ. Овгорыг ухвал Маша хэвтэж байлаа. Үхсэн мөртлөө амьдаасаа илүү үзэсгэлэн гоо болчихсон, хацар нь үлайчихсан унтаж байгаа юм шиг харагдана. Бишгүүр хангинан,

- Зэгсэн бишгүүр, дуул дуул, хөөрхий жаахан намайг хоёр эгч минь ойд авчирсан, улаахан алим мөнгөн тавагны төлөө залуухан амийг минь хорлосон. Зэгсэн бишгүүр минь, дуул дуул, хайртай буурал аав минь, хааны худгаас мөнхийн үс авчраач авчраач гэлээ. Атаархан хорсогч хоёр эгч нь айн чичрэн, өвдөг сөгдөн унаж өөрсдийн хийсэн хэргийг хүлээхэд тэднийг хааны зарлиг гартал төмөр цоожны цаана суулгав гэнэ. Өвгөн эцэг нь мөнхийн үс авдрах гэж хааны хотыг зорин явсаар хааны ордонд ирэхэд хаан алтан довжооноосоо бууж явав.

Өвгөн доор гэгч бөхийн болсон явдлыг ярилаа. Хаан,

- Миний худгаас мөнхийн ус ав. Харин охиноо амь орж сэргэхээр улаан алимтай нь, мөнгөн тавагтай нь миний ордонд авчраарай. Бас залт хоёр эгчийг нь авчир гэлээ.

Өвгөн баярлан талархаад мөнхийн ус аван гэрийн зүг яарав.

Ингээд гэртээ ирээд Машагаа мөнхийн усаар дөнгөж шүршмэгц охин амь орон сэргэж эцгийнхээ хүзүүнээс тэврэн авлаа.

Хүмүүс цуглан ирж бөөн баяр

болжээ.

Өвгөн охидтойгоо хот руу явав. Хааны ордонд ороход хаан гарч ирээд Машаг харна. Хаврын цэцэг шиг Маша охины нүднээс нь гэрэл цацарч, нүүрнээс нь үүрийн туяа гийх мэт ажээ. Хацар дээгүүр нь сувд лугаа адил нүлийн бөмбөрнө.

Хаан,

- Шимт алим шидэт таваг чинь хаана байна? гэв. Маша шимт улаан алимаа шидэт мөнгөн таваг дээгүүрээ өнхрүүлэн үзүүлэв.

Мөнгөн таваг хангинаан дуугарч таваг

дээр оросын хот тосгон дараа  
дараалан харагдаж, түг далбаа  
намируулсан цэргийн хороо  
жигдрэн жагсаж аравт зуутаар  
зэрэгцэн зогсох нь үзэгдсэнээ их  
буугаар галлаж бөөн үүл хүйлран  
босож халхлан далдлав гэнэ.

Шимт улаан алим шидэт мөнгөн  
таваг дээгүүр өнхрөн бөмбөрөн  
дахин таваг дээр тэнгис далай  
давалгаалан долгилж хүн шувуу шиг  
хөлөг онгоц хөвөн далбаа  
дарвуул нь салхинд хийсэн  
харагдсанаа бас л их буугаар галлан  
бөөн үүл хүйлран босож халхлан  
далдлав гэнэ. Тэгснээ дахин шимт  
улаан алим шидэт мөнгөн таваг

дээгүүр өнхрөн бөмбөрөн таваг дээр хөх цэнхэр тэнгэр цэлийж гэрэлт наран гэгээн сарны цаагуур нуугдан бөмбөрч, од мичид тойрон бүжгээ эхлэхэд бэлдэн, хун шувуу нуур усандаа дуулан ганганах нь үзэгдэв гэнэ. Хаан энэ ид шидийг үзэн гайхан зогсоход үзэсгэлэнт Маша охин нулимсаа цувруулан,

- Эрхэм хаантан, та энэ мөнгөн таваг улаан алимыг авч хайлраач. Харин эгч нарын минь амь насыг өршөөн хэлтрүүлээч гэж гүйв.

Хаан өвдөг сөгдсөн Машаг өргөн босгож,

- Өөрийн чинь таваг мөнгө юм, өр зүрх чинь алт юм. Хамаг баялгийн .эзэгтэй, хаан миний эхнэр болооч! Чиний гүйсан ёсоор хоёр эгчийг чинь би өршөөн хайлана гэлээ.

Хааны ордонд хамаг баялаг бэлэн хойно агуулах саваа онгойлгон амттан шимтэнийг гарган хотол олныг донсолгосон их найр хуримыг тэр дорхноо хийж тэнгэрийн одыг үнатал газрын хөрсийг халцартал дуулж бүжиглэв гэнээ.

# ИЛБЭТ ЦУРХАЙН ТУШААЛААР

Эмгэн өвгөн гурван хүүтэй  
юмсанжээ. Хоёр том нь ухаантай,  
бага хүү Емеля нь тэнэг гэнэ. Хоёр ах  
нь гар хүмхихгүй ажилладаг байхад  
Емеля өдөржингөө пийшин дээр  
хэвтэж юу ч хийдэггүй, юу ч  
сонирхдоггүй ажээ. Нэг удаа ах нар  
нь зах явжээ. Бэр эгч нар нь Емеляг  
дуудан,

- Усанд яваад ирээч гэж гүйв.
- Залхүү хүрээд байна аа... гэж Емеля  
пийшин дээрээсээ хариуллаа.
- Емеля, ус аваад ир л дээ, ах нар

чинь чамд бэлэг авчрахгүй шүү.

- За за явахаас.

Тэгээд Емеля пийшин дээрээсээ буугаад хувцсаа өмсөн хувин, сүхээ аван гол рүү явжээ. Мөс цавчин харз гаргаад хувингаараа ус утгаж авчихсан мөртлөө харз руугаа хараад зогсоод байв. Юу гэвэл, харзанд цурхай загас байжээ. Емеля үхасхийн гараа дүрэн цурхай загасыг бариад авав.

- Сайхан шөл болно доо!

Тэгсэн чинь цурхай загас гэнэт хүний хэлээр,

- Емеля, намайг тавиач, би чамд тус болно гэв. Емеля инээн,
- Чи надад яаж тус болох юм бэ?..  
Үгүй дээ, би чамайгтэртээ аваачна,  
бэргэн эгч нар сайхан шөл чанана  
даа.

Цурхай загас дахин гүйсан нь,

- Емеля, Емеля, намайг тавиач дээ.  
Юу хүссэнийг чинь би цөмийг  
биелүүлнэ гэлээ.
- За за. Харин чи эхлээд худлаа  
хэлээгүй гэдгээ үзүүлээдэх, тэгвэл  
тавина.

Цурхай загас,

- Емеля, Емеля, одоо чи юу хүсэж байна? гэж асуув.
- Хувинтай ус минь цалгилгүйгээр хурдан явж хариг гэж хүсэж байна...
- Тэгвэл чи тогтоож ав. Ямар нэг юм хүсэхээрээ «Емеля миний хүслээр, илбэт цурхайн тушаалаар» гээд хүссэн юмаа хэлж бай гэж цурхай загас зааж өглөө.
- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Хувинтай ус минь, өөрөө Хурдан явж харигтун!

гэж Емеляг дөнгөж хэлмэгц хувингууд нь өөрсдөө гэрийнхээ зүг явав. Емеля цурхай загасыг харзанд буцааж тавиад хувингуудынхаа араас явлаа. Хувингууд өөрсдөө явж байгааг тосгоныхон хараад гайхан шуугилдана. Емеля ард нь инээмсэглэн алхана. Хувингууд гэрт ормогцоо өөрсдөө вандан дээр тавигдав, Емеля ч пийшин дээрээ гарч суув. Бэргэн эгч нар нь дахиад л,

- Чи яагаад хэвтээд байгаа юм бэ? Гарч түлээ хагалбал дээрсэн! гэв.
- Залхүү хүрээд байна аа...

- Түлээ хагалахгүй бол ах нар чинь чамд бэлэг авчирч өгөхгүй дээ.

Емеля пийшин дээрээсээ бүухаас дургүйхэн байснаа гэнэт цурхай загасыг санажээ. Тэгээд,

- Емеля миний хүслээр

Илбэт цурхайн тушаалаар Хангинуур сүх гарч түлээ хагал. Хагалсан түлээ өөрсдөө пийшинд оротун! гэв. Сүх вандан доноос үсрэн гарч түлээ хагалав, хагалсан түлээ өөрсдөө пийшинд орж өрөгдөв гэнэ. Бэргэн эгч нар нь дахиад л,

- Манай түлээ дууслаа. Ууланд очиж

мод авчир гэлээ.

- Та нар өөрсдөө авчрахгүй юу! гэж Емеля хариулав.
- Түлээнд эм хүн явдаг юм уу?
- Залхуу хүрээд байна аа...
- Тэгвэл чамд бэлэг авчирч өгөхгүй дээ! Яах ч арга байсангүй, Емеля пийшин дээрээсээ бууж дулаан хувцсаа өмсөөд олс сүх аваад гадаа гарч чарган дээрээ сүугаад,
- Хөөе, хаалгаа онгойлгоорой! гэж хашгирав.

- Ээх тэнэг минь, морио хөллөөгүй байж чарган дээрээ суучихдаг чинь юу вэ! гэж бэргэн эгч нар нь шуугилдав.

- Надад морь хэрэггүй!

Бэргэн эгч нар нь хаалга онгойлгов.  
Емеля амандаа,

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Чарга минь, ой руу давхи... гэжхэлэв.

Чарга нь өөрөө хаалгаар гаран давхилаа, харавсан сум шиг хурдаллаа.

Тосгоныхоо дундуур цас манараган давхиж торж тээглэсэн хүнийг дайрч түлхэн өнгөрөв. Хүмүүс «Бариад ав! Бариад ав!» гэж хашгиралдана. Емеля энэ бүгдийг огт тоосонгүй чаргаа шавдуулсаар ойд ирлээ.

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Хурц хангинуур сүх минь, Хуурай мод хугалан цавч Унасан модод чарган дээр хураагд Урт олсоор уягдан дарагд... гэж Емеляг хэлэхэд сүх нь хуурай мод цавчин унагаж, унасан мод түлээ чарган дээр ачигдаж, уяа олсоор уягдан дарагдав гэнэ. Дараа нь Емеля сүхэндээ өргөж даахуйц бороохой цавчиж өг гэж тушаав.

Тэгээд л,

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Чарга минь, гэр лүүгээ давхиад!... гэж шивгэнэв.

Чарга нь гэрийнхээ зүг хурдлан давхив. Дахиад л нөгөө хүн амьтныг дайрч түлхэн унагасан гудамжаараа өнгөрч явтал тэнд уурлаж өширсөн хүмүүс хүлээж байв. Емеляг шүүрэн авч чарган дээрээс нь унагах гэж татаж чангаан, балбаж нүдэн, хараан загнав гэнэ. Емеля тэсэхээ байхаар амандаа,

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Бороохой минь,

Эднийг Больё гэтэл балбаад өгөөч!..  
гэж шивгэнэжээ.

Бороохой хүмүүсийг балбаж нүдэж  
гараад хүмүүс зугтан одов. Емеля  
гэртээ ирээд пийшин дээрээ гаран  
хэвтжээ. Емелягийн энэ явдлыг хаан  
сонсоод ордонд авчир гэж нэгэн  
цэргийн даргаа явуулжээ. Дарга тэр  
tosгонд ирэн Емелягийнд ороод,

- Тэнэг Емеля гэдэг чи юу? гэж асуув.
- Яах гээв? гэж Емеля пийшин  
дээрээсээ асуув.
- Хувцсаа хурдан өмс, хаанд чамайг  
аваачиж өгнө.

- Залхуу хүрээд байна аа...

Дарга уурлан Емеляг алгадаад авав.  
Тэгэхэд Емеля амандаа,

- Емеля миний хүслээр Илбэт  
цурхайн тушаалаар Бороохой минь,  
энэ даргыг Больё гэтэл нь балбаад  
өгөөч! гэж шивгэнэжээ.

Бороохой үсрэн цэргийн даргыг  
балбаж нүдэхэд дарга амь мэнд  
зугтан одов гэнэ.

Емеляг авчирч чадаагүйд хаан ихэд  
гайхан, хамгийн том генералаа  
явлувлав.

- Тэнэг Емеляг авчрахгүй бол толгойтий чинь авна! гэжээ.

Генерал үзэм, чавга, боов, чихэр худалдан аваад нөгөө тосгонд ирэн Емелягийн бэргэн эгч нараас нь Емеля юунд дуртай вэ? гэж асуужээ.

- Эелдэг зөөлөн ярьж хэлж, гоёмсог хүрэм амлах юм бол Емеля юу ч гүйсан хийгээд өгнө, юу ч гэсэн за гэнэ дээ гэж гэнэ.

Генерал Емеляд үзэм, чавга, боов, чихэр өгөөд,

- Емеля, яагаад чи пийшин дээрээ хэвтээд байгаа юм бэ? Алив хоёулаа

хаанд бараалхъя! гэж гэнэ.

- Энд дулаахан тухтай байна аа...
- Емеля, хаан чамайг ханаж цадтал чинь дайлж зочилно.
- Залхуу хүрээд байна аа...
- Емеля, хаан чамд гоё хүрэм, гутал, малгай бэлэглэнэ дээ.

Емеля бодож бодож,

- За, би араас чинь очьё гэжээ.  
Генералыг явсны дараа Емеля  
пийшин дээрээ жаахан хэвтэж  
байгаад,

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Халуухан пийшин минь, хоёулаа Хааны ордон руу явъя гэв. Тэгтэл байшингийнх нь өнцөг булан шажигнаж, дээвэр нь ганхсанаа хана туурга нь ховхрон пийшин нь шууд л гадаа гарч замаар орон хааны ордон чиглэлээ гэнэ.

Хаан цонхоороо хараад тун гайхаж,

- Энэ юу вэ? гэхэд генерал нь,

- Емеля пийшин дээрээ суугаад ирж явна. Хаан довжоон дээрээ гаран,

- Емеля, чи олон хүнийг дайрсан байна, олон хүн гомдол зарга

мэдүүлсэн! гэхэд Емеля,

- Чарганы замаас өөрсдөө холдоогүй шүү дээ! Энэ үед хааны охин Марья гүнж цонхоор харж байжээ. Емеля гүнжийг хараад амандаа шивгэнэв.

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар

Хааны охин надад

Хайртай болог! гэж шивгэнэснээ,

- Халуухан пийшин минь, харья гэжээ. Пийшин эргэн давхиж гэртээ орж байсан байрандаа байрлав гэнэ. Емеля пийшин дээрээ

хэвтдэгээрээ хэвтээд л байж.

Гэтэл хааны ордонд хашгираан  
үйлаан, нус нулимс болж гэнэ.

Марья гүнж Емеляг санаж, Емелягүй  
бол сууж байж чадахгүй гэж,  
Емелятай суулгаач гэж хаан эцгээсээ  
хайлан үйлан гүйна гэнэ. Хаан гунин  
ганихран байснаа генералаа дуудан,

- Емеляг амьд ч бай, үхсэн ч бай  
хамаагүй, заавал авчир! Авдрахгүй  
бол толгойгий чинь авна гэжээ.  
Генерал амтат дарс, даруулах зүүш  
аваад Емелягийнд ирэн түүнийг  
дайлж зочлов гэнэ.

Емеля ууж идэж согтоод унтахаар

хэвтжээ. Генерал түүнийг чарган дээр ачин хаандаа аваад ирж гэнэ. Хаан төмөр бүслүүртэй том торх авчир гэж тушаав. Тэгээд тэр торхондоо Емеляг өөрийн охин Марья гүнжтэй цуг хийгээд гаднаас нь давирхайдан тэнгист хаяжээ. Емеля унтаж унтаж сэrsэн чинь тас харанхуй, хөдөлж болохгүй давчуу байхад гайхан,. - Бн хаана байнаа? гэжээ.

- Емеля минь, ямар үйтай хорсолтой байна вэ! Биднийг торхонд хийгээд тэнгист хаясан гэх хариу сонсогдов.
- Чи хэн бэ?

- Би Марья гүнж байна. Тэгэхэд Емеля,
  - Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Далайн эрчит салхи минь, Давирхайт том торхыг минь Улайран шаргалтах элсэн дээр
- Усгүй хуурай эрэг дээр гаргаж хаяач! гэж шивгэнэв. Хүчит салхи үлээн, хүйтэн тэнгис давалгаалав, төмөр бүслүүрт торхыг түлхэн өнхрүүлсээр эрэг дээр хаяв гэнэ. Емеля Марья гүнж хоёр торхноос гарлаа.
- Емеля минь, хоёулаа орон гэргүй одоо яж амьдрах вэ? Ямар нэг орон босгооч гэж Марьяг хэлэхэд

Емеля,

- Залхүү хүрээд байна аа... гэв.

Марья дахин дахин гүйхад Емеля,

- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Алтан дээвэртэй чулуун ордон Асарлан сүндэрлэн босогтун! гэж хэлэв.

Түүнийг ингэж хэлмэгц алтан дээвэртэй чулуун ордон асарлан сүндэрлэн босов гэнэ. Эргэн тойронд нь нов ногоон цэцэрлэг нуга нэлийж, цэцэг навч дэлгэрэн, жигүүртэн шувуу жиргэн дуулна гэнэ. Марья гүнж Емеля хоёр ордондоо орон гэрэлтэй цонхныхоо

хажууд суув.

- Емеля, чи сайхан эр болон хувирч болохгүй юу? гэж Марьяг асуухад Емеля,
- Емеля миний хүслээр Илбэт цурхайн тушаалаар Төрсөн бие минь одоохон

Зурсан юм шиг сайхан бол гэж шивгэнэв. Емеля тэр даруйхнаа үлгэрт хэлшгүй үзгээр бичишгүй сайхан залуу болов гэнэ.

Яг тэр үед хаан анд явж байгаад урьд өмнө үзэгдээгүй шинэ ордон байхыг хараад,

- Миний газар нутаг дээр хэн ингэж хэлж асуулгүйгээр ордон бария вэ! гээд «Мэдээд ир!» гэж элчээ явуулав.

Элч зарц нар нь ордны цонхон доор ирээд асуухад Емеля,

- Хаан эзэн өөрөө манайд зочлог, хаанахын хэн болохоо би ганцхан түүнд хэлнэ гэв.

Хаан ирлээ. Емеля угтан авч ордондоо оруулан ширээнээ суулгав. Тэгээд дайлж зочлоход хаан амттаныг идэж үүж сүүхдаа гайхан,

- Сайхан төрсөн сайн эр минь, чи

хаанахын хэн бэ? гэж асуулаа.

- Пийшин дээрээ сүугаад таны ордонд очсон тэнэг Емеляг санаж байна уу? Та охинтойгоо цуг торхонд хийгээд тэнгист шидсэн шүү дээ. Би Емеля байна. Хэрвээ

би хүсвэл хаант улсыг чинь хар үнс болгож чадна гэхэд хаан ихэд айн өршөөл үүчлал гүйн,

- Охинтой минь сүү! Орон улсыг минь авч захир, гагцхүү амь насыг минь хэлтрүүл! гэлээ.

Тэгээд хотлыг донсолгосон их найр хийж, Емеля Марья гүнжтэй гэрлэн,

улс орноо удирдан залах болжээ.  
Ингээд сонин үлгэр төгслөө, сонссон  
хүнд гялайлаа.

# МЭЛХИЙ ГҮНЖ

Эрт урьд цагт гурван хүүтэй нэг хаан байжээ. Хөвгүүд нь эрийн цээнд хүрэхэд хаан хажуудаа дуудан,

- Өвгөрч хөгшрөхийнхөө өмнө би өөрийн хайрт хөвгүүд та нараа гэрлүүлж ачийнхаа зулайг үнэрлэмээр байна гэжээ. Хөвгүүд нь эцгээсээ,
- Адис ерөөлөө өг дөө, эцэг минь. Аль газрын ямар хүний үртэй биднийгээ гэрлүүлмээр байна даа? гэж асуухад хаан эцэг нь,
- Нум сумаа аваад цэлгэр талд

гарцгаа. Сум хаана унана, тэнд та нарын заяны хань бий гэж хэлэв. Хөвгүүд эцгээ мэхийн хүндлээд нум сумаа аван цэлгэр талд гаран харваж гэнэ.

Том хүүгийн сум ноёны үүдэнд унаж, ноёны охин сумыг газраас авлаа. Дунд хүүгийн сум худалдаачны өргөн хашаанд унаж худалдаачны охин сумыг газраас авлаа. Бага хүү Иваны сум шүнгинан ниссээр алга болов. Иван сумаа эрэн явж явж намагт тулж очвол тэнд нэг мэлхий сумыг нь тэврэн сууж байх юм гэнэ. Хаан хүү Иван,

- Мэлхий, миний сумыг өгөөч гэв.

- Намайг эхнэрээ болгон аваач! гэж мэлхий хэлэв гэнэ.
- Юу гэнээ, би яаж мэлхийтэй сүүх юм бэ?
- Надтай сүү л даа, хувь заяа чинь шүү. Иван гунихран ганихран аргаа барахдаа мэлхийг авч гэртээ авчирчээ. Хаан гурван хурим хийв. Том хүүгээ ноёны охинтой, дунд хүүгээ худалдаачны охинтой, азгүй мүү Иванаа мэлхийтэй гэрлүүлжээ. Хаан хөвгүүдээ дуудан,
- Гурван бэрийн хэн нь үйлэнд илүү уран бэ? гэдгийг би мэдэхийг хүснэ. Маргааш гэхэд надад нэг нэг цамц

оёж өгөөрэй гэжээ. Хөвгүүд нь гэр гэртээ буцав. Хаан хүү Иван ирээд толгой бөхийн суув гэнэ. Мэлхий шалан дээгүүр үсчин байснаа,

- Хаан хүү Иван, юунд толгой гудайн сүуна вэ? Гай зовлон тохиолдов үү? гэж асуув.
- Эцэг минь чамайг маргааш гэхэд цамц оёж авчир гэнээ.
- Хаан хүү Иван минь, бүү гунихар, одоо унтаж амар. Оройноос өглөө сэргэлэн гэдэг дээ гэж мэлхий хэлэв. Хаан хүү Иван үнтмагц мэлхий довжоон дээрээ үсрэн гарч мэлхийн арьсаа унагаан үлгэрт хэлшгүй үгээр

бичишгүй үзэсгэлэнтэй сайхан  
Мэргэн Василиса болон хувирав.  
Мэргэн Василиса алга ташин,

- Асрагч тэтгэгч эгч ээжүүд минь,  
цуглан ирцгээ! Өглөө гэхэд эцгийн  
минь өмсдөг шиг тийм гоё цамц оёж  
надад авчирч өгөөч гэж хашгирав.

Өглөө хаан хүү Иван сэрэхэд мэлхий  
шалан дээр үсрэн дэвхрэн байна  
гэнэ. Харин ширээн дээр алчуурт  
боолттой цамц тавьжээ. Иван  
баярлан цамцыг аван эцэгтээ  
аваачиж өгөв. Хаан эцэг нь энэ үед  
том хөвгүүдийнхээ бэлгийг авч байв.  
Том хүү цамцаа дэлгэн өгөхөд хаан  
эцэг авахдаа,

- Энэ цамцыг босго намхан бор гэрт өмсвөл зохино гэв. Дунд хүү цамцаа дэлгэн өгөхөд хаан,
- Энэ цамцыг хаяандаа байгаа халуун усны байшинд очихдоо л өмсвөл зохино гэв.

Иван уран нарийн хээтэй алт мөнгөн утсаар алаглуулан хатгасан цамцаа дэлгэн өгөхөд хаан эцэг нь харангүутаа,

- Энэ ч ёстой найр наадамд өмсөх нандин сайхан цамц байна даа гэв.

Хоёр ах нь харих замдаа,

- Иваны эхнэрийг шоолж хөхөрдөг дэмий л юм боллоо. Мэлхий биш ямар нэг шидэт эм байхаа гэж ярилцжээ.

Хаан хөвгүүдээ дахин дуудаж,

- Миний бэрүүд маргааш надад талх жигнэж өгөг, хэн нь илүү сайн тогооч юм бэ дээ мэдэхийг хүснэ гэж гэнэ.

Хаан хүү Иван толгой гудайлган гэртээ ирэв. Мэлхий,

- Яагаад гуниглаа вэ? гэж асуухад Иван,

- Маргааш хаан эцэгт талх жигнэж аваачих ёстой гэв.

- Хаан хүү Иван, унтаж амар,  
оройноос өглөө сэргэлэн гэдэг дээ  
гэж мэлхий тайтгаруулав.

Нөгөө хоёр ахынх нь эхнэрүүд эхлээд  
мэлхийг шоолж инээж хөхөрч  
байсан бол энэ удаа мэлхий яаж  
талх жигнэхийг хараад ир гэж нэг  
эмгэнийг явуулжээ. Мэлхий үүнийг  
нь мэджээ. Тэгээд жонхуу зуурч,  
пийшингээ дээрээс нь хэмхэлж  
онгойлгоод тэр нүх рүүгээ жонхуугаа  
цутгачижжээ. Эмгэн энэ бүгдийг  
нууцаар хараад нөгөө хоёр бэрд  
ярихад нөгөө хоёр бэр дуурайжээ.  
Харин мэлхий довжоон дээрээ гаран  
Мэргэн Василиса болон хувираад  
алгаа ташин,

- Асрагч тэтгэгч эгч ээжүүд минь, цуглан ирцгээ! Өглөө гэхэд эцгийнхээ гэрт миний иддэг байсан шиг тийм зөвлөн цагаан талх жигнэж өгөөч гэв.

Хаан хүү Иван өглөө сэrvэл ширээн дээр хажуу бөөрөөрөө хээ үгалзтай дээгүүрээ байшин цамхаг өрж хийсэн шинэхэн талх бөмбийж байна гэнэ.

Иван баярлан талхаа алчуурт ороон эцэгтээ аваачиж өгчээ. Эцэг нь тэр үед том хөвгүүдийнхээ бэлгийг авч байв. Эмгэн тагнаачийн хэлснээр хоёр ахын эхнэр гурилаа шүуд пийшин рүүгээ хийсэн юм чинь нэг

нэг түлэнхий хар гурил болжээ. Хаан том хүүгээсээ талхыг авч харснаа зарц барлагт өг гэв. Дунд хүүгийнхээ бэлгийг аваад бас л зарц барлагт өгүүлэхээр түлхэв. Харин Иваныг талхаа өгөхөд хаан эцэг нь,

- Энэ чинь ёстой баяр ёслолоор идэх талх шиг талх байна даа гэжээ.

Тэгээд гурван хүүдээ маргааш эхнэрүүдтэйгээ цуг найранд ир гэж хэлжээ.

Хаан хүү Иван дахин толгой гудайн гунигтай буцжээ. Мэлхий шалан дээгүүр үсчин,

- Вуаг вуаг, хаан хүү Иван, юундаа гуниглаа вэ? Хаан эцэг чинь гашуун үг хэлэв үү? гэхэд Иван,
- Мэлхий минь, би яаж ч гуниглахгүй байх юм бэ дээ. Эцэг найрандаа эхнэртэйгээ ир гэж байна. Гэтэл би чамайг яаж хүн олонд үзүүлэх вэ? гэж хариулав.
- Хаан хүү Иван минь, бүү гунь. Найранд чи ганцаараа яв, би араас чинь очно. Түг таг хийх их чимээ сонсоод бүү аиж сандраарай, харин юу болохыг асуувал «Энэ миний мэлхий хайрцагт сүугаад ирж явна» л гээрэй гэж мэлхий хэллээ гэнэ.

Хаан хүү Иван найранд ганцаараа явав. Хоёр ах нь гоёж гоодсон эхнэрүүдээ дагуулвн иржээ. Иваныг харан шоолж дооглон инээлдэн зогсоно.

- Яагаад ганцаараа ирээ вэ? Мэлхийгээ алчуурт боогоод аваад ирэхгүй. Чи тийм үзэсгэлэнт бүсгүй хаанаас олоо вэ? Их намгийг нэгжиж байж олсон байхаа гэлцэнэ. Хаан хөвгүүд бэрүүдтэйгээ, хүндэтгэл ихэд зочидтойгоо зэрэгцэн амттан шимтэн өрсөн аварга том царсан ширээнээ сууж найр эхэлжээ. Гэнэт түг түг хийх их чимээ гарч ордон шилтгээн чичрэн доргив гэнэ. Зочид айн сандарч суусан газраасаа

сугаран босоход Иван,

- Хүндэтгэл ихэд зочид минь, бүү ай, бүү сандар. Миний мэлхий хайрцагт суугаад ирж яваа нь энэ гэлээ. Хааны ордны үүдэнд зургаан цагаан морь хөллөсөн алтан сүйх ирж зогсоход тэндээс тааж хэлж баршгүй тайлж зурж болшгүй, үлгэрийн дагина гэмээр үзэсгэлэн гоо, од гялбалзсан номин хувцастай, огторгуйн тунгалаг сар толгой дээр нь гэрэлтсэн Мэргэн Василиса гарч ирэв гэнэ. Мэргэн Василиса хаан хүү Иваныг гараас нь түшин авч амттан шимтэн өрсөн аварга том царсан ширээнээ суув. Зочин олон сууж идэж дуулж хуурдаж эхэллээ. Мэргэн Василиса

аягатай дарсаа үугаад үлдсэнийг нь зүүн ханцуй руугаа цутгачихлаа гэнэ, амсаж идсэн махныхаа ясыг баруун ханцуй руугаа шидчихэж гэнэ.

Албаар ингэж үзүүлснийг нь ах нарын эхнэр дуурایв гэнэ. Ууж идэж цадаад дуулж бүжиглэх болов.

Мэргэн Василиса Иваныг аван бүжиглэж гарлаа. Олон зочдыг гайхан шагширтал онц сайхан бүжиглэж зүүн ханцуйгаараа даллахад нуур мэлтэлзэн бий болов, баруун ханцуйгаараа даллахад дун цагаан хүн шувуу хөвлөө гэнэ. Хаан эцэг, хамаг зочид шагшин гайхав.

Том хоёр хүүгийн эхнэрүүд бүжиглэхээр гараад ханцуйгаараа

даллатал зочдоо шүршчихэж гэнэ, нөгөө ханцуйгаараа даллатал хатуу яс цацагдан, нэг яс хааны нүдэнд орчихож. Хаан уурлан хоёр том бэрээ хөөчихөж гэнэ.

Энэ зуур хаан хүү Иван сэмхэн гарч гэртээ очоод мэлхийн арьсыг олж гал руугаа шидэн шатаажээ. Мэргэн Василиса гэртээ эргэж ирээд мэлхийн арьс нь байхгүйд гуниглан ганихран сууж Иванд,

- Хаан хүү Иван, чи юу хийх нь энэ вэ! Гуравхан өдөр хүлээж чадсан бол би энэ насаараа чинийх байхсан. Одоо үүрд баяртай. Намайг зуун үүлын цаанатаа зургаан үлсын тэртээ

Хорт Ясан хэдрэгийн үс нутгаас эрж олоорой... гээд үнсэн саарал хөхөө шувуу болон хувираад цонхоор нисэн одов гэнэ.

Хаан хүү Иван уйлж уйлж дөрвөн зүгт мэхийн ёслоод Мэргэн Василиса эхнэрээ олохоор харсан зүг рүүгээ явжээ. Яваад л байж, яваад л байж, гутал нь элж, хүрэм нь цоорч, нар салхи бороо шороонд цохигдсоор малгай нь урагджээ. Тэгтэл нэг өвгөн дайралдаж,

- Сайн эр минь, хэт нутаг хаана вэ, хэрэг зориг хэнд вэ? гэв.

Хаан хүү Иван учир байдлаа хэлэхэд

- Мэргэн Василиса төрсөн эцгээсээ илүү ухаантай сэргэлэн байна. Эцэг нь уурлан түүнийг гурван жил мэлхий байг гэж хувиргажээ. Одоо яая ч гэхэв дээ, чи энэ бөөрөнхий утсыг ав. Утас хаашаа өнхөрнө, чи тийшээ яваад бай гэж зааж өгөв. Хаан хүү Иван өвгөнд талархаад бөөрөнхий утсаа даган явжээ. Утас өнхрөн задарна, Иван ч даган гүйнэ. Ойн нэгэн цэлгэр цоорхойд баавгай тааралдav. Иван алахаар шагайж онилж байтал баавгай хүний хэлээр,
- Хаан хүү Иван минь, намайг бүү алаач, хэзээ нэг цагт би чамд хэрэг болж магад гэж гэнэ.

Иван баавгайг өрөвдөөд  
харавсангүй цааш явжээ. Тэгтэл нэг  
эр нугас дээгүүр нь эргэлдэн нисэв  
гэнэ. Бас л алахаар шагайтал нугас  
хүний хэлээр,

- Хаан хүү Иван, намайг бүү алаач,  
хэзээ нэг цагт би чамд хэрэг болно  
гэв.

Иван нугасыг өрөвдөөд харавсангүй  
цааш явжээ. Тэгтэл нэг туулай гүйж  
явна гэнэ. Дахиад л алахаар  
шагайтал туулай хүний хэлээр,

- Хаан хүү Иван, намайг бүү алаач,  
хэзээ нэг цагт би чамд хэрэг болно  
гэв.

Иван туулайг өрөвдөөд цааш явав.  
Хөхрөх тэнгисийн захад тулж иртэл  
эргийн элсэн дээр багтарч үхэх  
шахсан нэг цурхай загас хэвтэж  
байв. Цурхай хүний хэлээр,

- Хаан хүү Иван, намайг өрөвдөөч,  
халгих их тэнгист минь оруулж  
өгөөч! гэж гүйжээ,

Иван цурхайг тэнгист нь хаяад цааш  
эрэг даган явжээ. Яваад л байж, явж  
явж бөөрөнхий утас нь ой руу орлоо  
гэнэ. Ойд татах хаалга таглах  
цонхгүй, тахиан хөлт байшин  
эргэлдэн байна гэнэ.

- Байшинхан байшинхан, ар ханаа

ой руу ангайх хаалгаа над руу  
харуулаач гэж гэнэ.

Байшинхан ар ханаа ой руу ангайх  
хаалгаа Иван руу харуулав. Иван  
байшинд орж явчихвал тахир ясан  
хөлтэй, тааз тулсан хамартай  
Шулмас эмгэн махир шүдээ тавиур  
дээр тавиад есөн давхар туйпуутай  
пийшин дээр хэвтэж байв.

- Сайн эр, юу гэж явна? Ажлаас  
зугтаж явна уу, аль эсвэл эрж явна  
уу? гэж Шулмас эмгэн асуув.

- Хөгшин чөтгөр чи эхлээд намайг  
ундалж цайлаач. Дараа нь хэрэг  
зоригийг минь асуугаач гэж хаан хүү

Иван хэлэхэд эмгэн Иваныг үндалж цайлаад унтах ор засаж өгчээ.

Тэгэхэд хаан хүү Иван өөрийн эхнэр Мэргэн Василисаг эрж яваа үнэн учраа ярьжээ.

- Чиний эхнэр одоо Хорт Ясан хэдрэгийнд байгаа. Ясан хэдрэгтэй тэмцэнэ гэдэг амар биш. Ясан хэдрэгийн үхэл зүүний үзүүр дээр, тэр зүү нь өндөг дотор, өндөг нугасны гэдсэн дотор, нугас түулайн гэдсэн дотор, туулай чулуун авдар дотор, чулуун авдар өндөр царсан дээр байгаа. Тэр царсыг Хорт Ясан хэдрэг хар нүднээсээ илүү хайллан хамгаалдаг даа гэж Шулмас эмгэн хэлэв. Хаан хүү Иван Шулмас

Эмгэнийд хоноод явахад өглөө нь эмгэн түүнд өндөр царс хаана ургаж байгааг зааж өгчээ. Иван явсаар явсаар нөгөө өндөр царсанд тулж ирэв. Найган шуугисан өндөр царсан дээр чулуун авдар гар хүрэхийн аргагүй өндөрт байв гэнэ. Гэнэт ханаас ч юм бэ, баавгай давхин ирж царсыг үндсээр нь булга татав гэнэ. Авдар газар унаж хагарав. Авдраас түүлай огло үсрэн гарч хар хурдаараа зугтав. Гэтэл араас нь өөр нэг түүлай хөөн гүйцэж нөгөө түүлайг хэдэн хэсэг тас татан хаяв гэнэ. Тэгтэл түүлайн гэдсэн дотроос нугас гаран өндөр гэгч нисэн одоход эр нугас хөөн гүйцэж өндгийг нь

унагаав. Өндөг хөх цэнхэр тэнгист унав. «Энэ их тэнгисийн усан дотроос яаж тэр өндгийг олохов дээ!» гээд хаан хүү Иван гашуун нүлимсаа дуслуулан үйлав. Гэтэл гэнэт өмнө нь цурхай загас амандаа өндгийг зуучихсан//сэлээд ирлээ гэнэ. Хаан хүү Иван өндгийг хагалан зүүг гаргаж аваад үзүүрийг нь тас тас даран хугалав. Ингэж Иван зүүг хугалан үйхэд Хорт Ясан хэдрэг байж ядан тийчилж тийчилж үхэв. Хаан хүү Иван Ясан хэдрэгийн цагаан өргөө рүү яван очвол Мэргэн Василиса эхнэр нь гүйн гарч ирээд балын амтат үрүүлыг нь үнсэв гэнэ.

Тэгээд хоёулаа өөрийн гэртээ буцаж

ирээд өтөл насыг хүртэл амар сайхан  
аз жаргалтай амьдрان сүусан гэдээг.